



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА ДАШЗЭГВИЙН
АМАРБАЯСГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.08.12 № 35-1/105
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000244003407



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024.08.12 № ХЭГ/1460
танай _____-ны № _____-т

Тогтоолын төсөл өргөн мэдүүлэх
хугацаа товлох тухай

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1 дэх хэсэгт заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА




Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:

“2.ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

МОНГОЛ УЛСЫН
ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Л.ГАНТӨМӨР

БАТЛАВ.

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

БАТЛАВ.

ХҮҮЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн Хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтад “Төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөв, түүний гүйцэтгэл, хөгжлийн бодлогын болон төлөвлөлтийн баримт бичиг, түүнчлэн өмч, татвар, эрүү, иргэн, захиргааны ерөнхий болон зөрчлийн тухай анхдагч хууль, шинэчилсэн найруулга болон Засгийн газар санаачлахаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд тусгайлан заасан асуудлаар хууль тогтоомжийн төслийг зөвхөн Засгийн газар санаачлах.” гэж, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон, эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, ...хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлнэ.” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоол нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8.1.а дахь заалт дахь “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнд хүрэхээр чиглэсэн байх;” гэж заасан шаардлагыг хангана.

Хоёр.Тогтоолын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Тогтоолын төсөл нь 4 заалт, 2 хавсралттай байх бөгөөд нэгдүгээр заалтад “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-г 2

дугаар хавсралтаар тус тус батлахаар тусгана. Тогтоолын төслийн Хоёрдугаар заалтад Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтарч ажиллахыг Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт үүрэг болгохоор, мөн тус хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар, түүнчлэн тогтоолын төслийн Гуравдугаар заалтад энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Засгийн газраас бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлж, түүнд тулгуурлан татварын ялгаатай бодлого хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын орон зайн хуваарилалтыг оновчтой болгох, бүс тус бүрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулахаар, мөн тогтоолын төслийн 4 дүгээр зүйлд уг тогтоолын дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Тогтоолын төсөл батлагдсанаар Монгол Улсын Засгийн газар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад тулгуурласан эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, импортын хамаарлыг багасгах замаар эдийн засгийн зардлыг бууруулж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг ил тод, үр ашигтай болгож, засаглал, институтийн чадавх, суурь дэд бүтцийг сайжруулан, эдийн засгийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлнэ.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Хууль тогтоомжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомж байхгүй болно.

---oOo---

ТАНИЛЦУУЛГА

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.” гэж, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь заалтад “...Засгийн газар Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон, эсхүл хуульд заасан хугацаанд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эхэлснээс хойш 60 хоногийн дотор, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, төсвийн төслийг хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлнэ;” гэж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.2 дахь заалтад “...Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу энэ хуулийн ...4.1.8-д заасан баримт бичгийн төслийг энэ хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулж, Засгийн газарт танилцуулах;” гэж, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт “...Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус заасны дагуу “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Уг тогтоолын төсөл нь 4 заалт, 2 хавсралттай байх бөгөөд нэгдүгээр заалтад “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-г 2 дугаар хавсралтаар тус тус батлахаар тусгасан. Тогтоолын төслийн Хоёрдугаар заалтад Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтарч ажиллахыг Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт үүрэг болгохоор, мөн тус хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар, түүнчлэн тогтоолын төслийн Гуравдугаар заалтад энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Засгийн газраас бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлж, түүнд тулгуурлан татварын ялгаатай бодлого хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын орон зайн хуваарилалтыг оновчтой болгох, бүс тус бүрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулахаар, мөн тогтоолын төслийн 4 дүгээр зүйлд уг тогтоолын дагаж мөрдөх хугацааг тус тус тусгалаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн, Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар Улсын Их Хуралд суудал авсан Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан, төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгаа, иргэний нийгэм болон олон улсын байгууллагын саналыг тусган, үр дүнд суурилсан нэгдсэн арга зүйн дагуу боловсруулав.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан нийгмийн бодлогын шинэчлэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, авлигагүй төр, шударга ёсыг бэхжүүлэх цахим засаглал, эхлүүлсэн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтууд, Ардчилсан

намын мөрийн хөтөлбөрт туссан хүний хөгжил, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, технологи суурьтай мэдлэгийн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга төрийн зорилтууд, ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан эрчим хүчний болон боловсролын салбарын реформ, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон тусгалаа.

Түүнчлэн, уг хөтөлбөрийг бусад улс орнуудтай нэг тоон хэмжээсээр ойлголцох, бодлогын зорилт, үр дүнг олон улсад хэрэглэгддэг индексүүдээр хэмжиж үнэлэх, үр дүнг тодорхой, бодитой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, цаг хугацаатай байх /SMART/ шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төсөлд “Бүсчилсэн хөгжлийн бодлого”, “Хүний хөгжлийн бодлого”, “Эдийн засгийн бодлого”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого” гэсэн 4 бодлогын чиглэлийн хүрээнд “Улаанбаатар хот-20 минутын хот”, “Бие даасан эдийн засаг бүхий дагуул хот”, “Бүсийн төрөлжсөн хөгжил”, “Орон нутгийн хөгжил”, “Чинээлэг Монгол хүн”, “Эрдэм боловсролтой Монгол хүн”, “Эрүүл Монгол хүн”, “Баялагтаа эзэн Монгол хүн”, “Эдийн засгийн эрх чөлөө”, “Бизнес, хөрөнгө оруулалтын орчин”, “Эдийн засгийн төрөлжилт, либералчлал”, “Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт”, “Хүний эрх, эрх чөлөө”, “Авлигагүй засаглал”, “Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл”, “Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар ба амар тайван нийгэм” зэрэг 16 зорилго, 62 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 569 үйл ажиллагааг тусгасан болно.

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд: Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ. **Хангайн** бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс” болгон, **Баруун** бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс” болгон, **Хойд** бүсийг “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Говийн** бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” болгон, **Төвийн** бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Зүүн** бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд: Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ. Мөн гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах болон төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн бодлогын хүрээнд: Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн, олон тулгуурт, хүртээмжтэй эдийн засгийг бэхжүүлж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана. Уул уурхай, боомт, тээвэр логистик, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл зэрэг салбаруудад тулгуурласан эдийн засгийн төрөлжилтийн бодлогыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, банк санхүү, даатгал, татварын реформоор дэмжин хэрэгжүүлнэ. Шинжлэх ухаан технологи, инноваци шингэсэн

мэдлэгийн эдийн засгийн бэхжүүлэхийг зорьж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамж бүхий ногоон хөгжлийг цогцлооно.

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд: Төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ. Монгол үндэсний үнэлэмжийг нэмэгдүүлж, эх оронч сэтгэлгээг бий болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гадаад бодлогын нээлттэй олон тулгуурт зарчмыг баримтална. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, шүүхийн процессыг цахимжуулах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг ил тод болгохыг зорино. Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Агуулга

НЭГ. ЭДИЙН ЗАСАГ	4
1.1 Макро Эдийн засаг	4
1.2 Нийслэл	7
1.3 Эрчим хүч	9
1.4 Аялал жуулчлал	11
1.5 Соёл	12
1.6 Уул уурхай	13
1.7 Зам, тээвэр, боомт	14
ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ	16
2.1 Эрүүл мэнд	16
2.2 Боловсрол	19
2.3 Барилга	22
2.4 Хөдөлмөр эрхлэлт	24
2.5 Нийгмийн баталгаа	25
2.6 Хөдөө аж ахуй	26
ГУРАВ. НОГООН ХӨГЖИЛ	29
3.1 Уур амьсгалын өөрчлөлт	29
3.2 Эрчим хүчний шилжилт	29
3.3 Байгаль орчин	30
3.4 Усны нөөц	30
3.5 Агаарын бохирдол	31
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ	32
4.1 Авлига	32
4.2 Төрийн бүтээмж	32
4.3 Засгийн газрын үр ашиг	32
4.4 Хуулийн засаглал	33
4.5 Гадаад харилцаа	33
4.6 Цахим засаглал	34
ТАВ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ	35
5.1 Хотжилт	35
5.2 Захын бүс	36

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1 Эдийн засгийн өсөлт дэх салбаруудын оролцоо /нэгж хувь/	4
Зураг 2. ДНБ-ний өсөлт ба уул уурхайн болон уул уурхайн бус салбарын ДНБ-д эзлэх хувийн жин	5
Зураг 3. Импортын цахилгаан эрчим хүч	9
Зураг 4. Эрчим хүчний салбарын алдагдал, тэрбум төгрөг.....	9
Зураг 5. ЦЭХ-ний үйлдвэрлэл болон хэрэглээ, сая кВт.ц.....	10
Зураг 6. Дамжуулалт болон түгээлтийн алдагдал, сая кВт.ц	10
Зураг 7. МУ-д аялж байгаа жуулчдын улс орны ялгаа.....	11
Зураг 8. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь.....	13
Зураг 9. Тээвэрлэлтийн орлого, тэрбум төгрөг	15
Зураг 10. Зорчигч тээвэр, сая хүн.....	15
Зураг 11. Ачаа тээвэр, мянган тонн.....	16
Зураг. 12. Хүн амын нийт өвчлөл, 10,000 хүн амд, хүйсээр	17
Зураг 13.Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, нийт даатгуулагчаас эзлэх хувь	19
Зураг 14.Бүлэг дүүргэлт аймгаар.....	20
Зураг 15. ЕБС-ын бүлэг дүүргэлт	20
Зураг 16. ЕБС-ын мэргэжлийн хангалт	21
Зураг 17. Эрэлттэй 8 мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ.....	21
Зураг 18. Зураг. Орон сууцны төрөл (нийт өрхөд эзлэх хувиар).....	22
Зураг 19. Барилга угсралт, их засварын ажил (тэрбум төгрөг)	23
Зураг 20. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн зардлын хуваарилалт, халамж хүртэгчдийн амьжиргааны түвшний бүлгээр	25
Зураг 21. Агаарын чанарын индекс	31

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Монгол улсын 2023 оны эдийн Засгийн өсөлтийн бүтэц /нэгж хувь/.....	4
Хүснэгт 2. Аялал жуулчлалын хөгжлийн индекс, ДЭЗФ	11
Хүснэгт 3. Жуулчдын манай улсад ирсэн байдал, 2023 оны байдлаар, ҮСХ	11
Хүснэгт 4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт	24
Хүснэгт 5. Газар тариалан эрхэлсэн өрх, аж ахуй нэгж байгууллага	26
Хүснэгт 6. Хөнгөн үйлдвэрийн салбарын экспорт, импорт /сая ам.долл/	28

НЭГ. ЭДИЙН ЗАСАГ


1.1 Макро Эдийн засаг

Макро эдийн засгийн нөхцөл байдал:

Эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгож чадахгүй байна. Нэрлэсэн ДНБ 2023 онд урьдчилсан гүйцэтгэлээр 68.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 27.9 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 30.5 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.0 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлэв. Мөн гадаад худалдааны нийт эргэлт 24.4 тэрбум ам.доллар, экспорт 15.2 тэрбум ам.доллар, импорт 9.3 тэрбум ам.доллар болж, төлбөрийн тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан. Гэсэн хэдий ч энэ нь эдийн засгийн нөхцөл байдал бүрэн сайжирсан гэсэн үг биш бөгөөд сүүлийн 30 гаруй жилийн эдийн засгийн өсөлтийн хандлага ерөнхийдөө тогтворгүй байна. Энэ хугацаанд бидний бий болгож чадаагүй зүйл нь тогтвортой өсөлтийн асуудал юм. 2023 оны эдийн засгийн өсөлт 7.0 хувьтай гарахад уул уурхай, тээвэр, үйлчилгээ гэсэн хэдхэн салбар голлох нөлөө үзүүлсэн. Сүүлийн 10 жилийн эдийн засгийн өсөлт, бууралт нь уул уурхайн салбарын гарц, бүтээгдэхүүний үнээс ихээхэн хамааралтай болсон нь гол эрсдэл.

Хүснэгт 1 Монгол улсын 2023 оны эдийн Засгийн Зураг 1 Эдийн засгийн өсөлт дэх өсөлтийн бүтэц /нэгж хувь/ салбаруудын оролцоо /нэгж хувь/

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
ДНБ	5.6	-4.6	1.6	5.0	7.0
ХАА	0.7	0.8	-0.8	1.7	-1.3
Үйлдвэрлэл	0.9	-1.3	-0.6	-1.2	3.1
Уул уурхай	-0.3	-1.4	0.1	-2.1	2.6
Боловсруулах	0.3	0.3	-0.1	0.5	0.4
Цахилгаан, ус	0.1	0.0	0.2	0.1	0.1
Барилга	0.7	-0.1	-0.9	0.2	0.0
Үйлчилгээ	2.9	-3.0	1.8	3.2	4.3
Худалдаа	1.2	-1.4	0.6	1.1	0.7
Тээвэр, агуулах	0.2	-1.0	-0.3	0.4	1.8
Үйлчилгээний бусад	1.5	-0.6	1.5	1.7	1.9
Цэвэр татвар	1.0	-1.1	1.3	1.4	0.9




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Түүхий эдийн олон улсын үнийн хэлбэлзлээс хамааралтай эдийн засаг. Монгол Улс дэлхийд зэсийн нөөцөөр эхний 5-д, нүүрс, төмрийн хүдрийн нөөцөөр эхний 25-д тус тус жагсдаг. Экспортод гаргасан бүтээгдэхүүний 2022 оны бүтцийг задлан харвал 55.3 хувийг нүүрс, 23.2 хувийг зэс, 9.6 хувийг алт, 3.3 хувийг төмрийн хүдэр 2.1 хувийг газрын тос тус тус бүрдүүлж байгаа бөгөөд нийт экспортын 92 хувийг түүхий эд, 4 хувийг хагас боловсруулсан, 2 хувийг боловсруулсан, 0.3 хувийг нь ре-экспорт бүрдүүлдэг. Улмаар нүүрс, зэс зэрэг нэг төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс хэт хамааралтай манай улсын эдийн засгийг төрөлжүүлэх, боловсруулалтын түвшнийг үе шаттай хөгжүүлэх шаардлагатай.

Монгол улсын эдийн засгийн төрөлжилт хангалтгүйгээс гадна бизнес эрхлэхэд таатай орчин бүрдэхгүй байна. Дэлхий дахиныг хамарсан цар тахал, геополитикийн хямралт нөхцөл байдал, БНХАУ-ын “Тэг-Ковид” бодлогын нөлөөгөөр манай улсын эдийн засгийн өсөлт 2020 онд -4.6 хувиар агшиж, гадаад валютын албан нөөц 2022 оны 8 дугаар сард 2.5 тэрбум ам.доллар хүртэл буурч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл сүүлийн 4 жил алдагдалтай гарч, инфляц 2022 оны хагас жилд 16.1 хувь хүртэл өссөн зэрэг тогтворгүй нөхцөл байдлуудтай тулгарав. Гэсэн хэдий ч эдийн засгийг тогтворжуулах, экспортын валютын орлогыг нэмэгдүүлэх бодлогуудыг авч хэрэгжүүлсний үр дүнд эдийн засаг 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 6.9 хувиар өсөж, гадаад валютын албан нөөц 2023 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар 4 тэрбум ам.долларт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай гарч, инфляц 9.1 хувь хүртэл буурч нэг оронтой тоонд орсон.

Хэдийгээр макро эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгаа ч дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувь, экспортын орлогын 86 хувь, эдийн засгийн 7.9 хувийн өсөлтийн 3.4 нэгж хувийг уул уурхайн салбар бүрдүүлсэн байна. Энэхүү нэг салбараас өндөр хамааралтай байдал нь дэлхийн түүхий эдийн үнийн хэлбэлзэл, геополитикийн зөрчил зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөнөөс хамаарсан эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Мөн Дэлхийн өв уламжлалын сангаас гаргадаг Эдийн засгийн эрх чөлөөт байдлын индексээр Монгол Улс 2023 онд 73 дугаар байранд эрэмбэлэгдэж байна. Энэ индексийн “Хөрөнгө оруулагчдад ээлтэй байдал” үзүүлэлтээр манай улс хамгийн бага оноо буюу “бизнес эрхлэхэд таатай орчин бүрдээгүй” гэсэн үнэлгээ авчээ.

Зураг 2. ДНБ-ний өсөлт ба уул уурхайн болон уул уурхайн бус салбарын ДНБ-д эзлэх хувийн



жин

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо 2019-2023 оны жилийн эцсийн байдлаар

Дотоод эдийн засгийн орчинд өрийн дарамт нэмэгдэх эрсдэлтэй. БНХАУ-ын хилийн боомтууд бүрэн нээгдсэнээс хойш экспорт эрчимтэй өсөж, манай улсын урсгал тэнцэл сайжирсан. Ялангуяа нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрч нэмэгдсэн нь урсгал тэнцэл эерэг гарах гол хүчин зүйл байв. Хөрөнгө санхүүгийн данс 2023 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 56.6 хувиар буурсан хэдий ч урсгал тэнцэл сүүлийн 2 улирал дараалан ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлсөн. Гэсэн хэдий ч, хөдөлмөрийн захын голлох үзүүлэлтүүд сайжирч цар тахлын өмнөх түвшинд ойртож, бодит цалин сүүлийн 4 улирал дараалан өссөн. Цалин хөлсний өсөлтийн нөлөөгөөр өрхийн дундаж орлого

нэмэгдэж байгаа хэдий ч, өрхийн зарлага орлогоос илүү хурдтай тэлж байна. Өрхийн орлого зарлагын зөрүү үргэлжлэн өсөж, зөрүүг зээлээр санхүүжүүлэх тохиолдолд өрхийн өр нэмэгдэж, өрийн дарамтад орох эрсдэлтэй нөхцөл байдал бий болж байна.

Банкны салбар дахь хувийн байгууллагын нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 11.2 их наяд төгрөгт хүрлээ. Үүний 32.0 хувийг худалдаа, 16.3 хувийг барилга, 15.7 хувийг боловсруулах, 11.2 хувийг уул уурхай, 24.8 хувийг бусад салбарын зээл тус тус бүрдүүлж байна. Гэвч аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл нь салбараар болон зээлдэгчийн хувьд төвлөрөл өндөр хэвээр байна. Мөн Монгол Улсын нийт гадаад өр 2023 оны 2 дугаар улирлын байдлаар 33.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өссөн нь гадаад өрийн дарамт өндөр байгааг илтгэж байна.

Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс үүдэн гарсан бүс нутгийн ядуурал бий болох төлөвтэй байна. Дэлхийн цаг уурын байгууллага болон уур амьсгалын судалгаа хийж буй бусад олон улсын болон төрөлжсөн байгууллагуудын олон жилийн туршид хийсэн ажиглалт, судалгааны үр дүнд дэлхийн уур амьсгал дулаарч байна гэсэн дүгнэлт хийжээ. Уур амьсгалын өөрчлөлт нь Монгол орны цаг агаар, бэлчээр, ургамлын гарцад ч хүчтэй нөлөөлж буйг манай мэргэжлийн байгууллагууд, цаг уур, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэд, судлаачид удаа дараагийн судалгааны үр дүн, дүгнэлтдээ тусгаж, энэ талаар анхааруулж, сэрэмжлүүлж ирсэн билээ. Хот суурины өрхийн орлогын 60 орчим хувь нь цалингийн орлогоос бүрдэж байгаа бол хөдөөгийн малчин өрхийн орлогын тал нь мал аж ахуйн үйлдвэрлэлээс ордог. Тэгвэл, өнгөрсөн 2023 оны зун Улаанбаатар хот, Төв, Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн нутгаар удаа дараа орсон аадар бороо, тохиосон үер, 2023- 2024 оны өвлийн улиралд нийт нутгаар орсон ахиу цас, огцом хүйтрэлт нь 12-14 жилд нэг удаа тохиож буй байгалийн гамшигт үзэгдэл юм. Өнгөрсөн өвөл, хаврын улиралд тохиож буй зудын улмаас 2024 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 4.0 сая орчим толгой мал хорогдсон гэж ОБЕГ-аас мэдээлж байна. Ирэх 4-5 дугаар сард тохиох хаврын салхи шуурганы улмаас турж эцсэн мал сүрэг нэмж хорогдох магадлал маш өндөр байдаг. Иймээс өвөл, хаврын улирал өндөрлөсний дараа 2024 оны эцэст нийт малын хорогдлын тоо 2009-2010 оны зудын хохирлын хэмжээтэй дүйцэж ч болзошгүй байна. Үүнээс үүдэн өнгөрсөн онд 8.9 хувийн бууралттай гарсан хөдөө аж ахуйн салбар 2024 онд ч мөн адил ихээхэн бууралттай гарч, нийт эдийн засгийн өсөлтөд таагүй нөлөө үзүүлэх магадлал өндөр боллоо. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монгол орны нутгаар олон аймаг, сумдын нутгийг хамарсан гурван ч удаагийн зуд тохиож, олон тооны мал сүрэг хорогдсон, тухайлбал, 2003- 2023 оны хооронд хорогдсон нийт малын зүй бусын хорогдол 36.4 сая толгойд хүрсэн бөгөөд малын зүй бус хорогдол үндсэн хөрөнгийн хуримтлалыг 5.4 хувиар буурахад хүргэлээ. Мал аж ахуйн салбарыг цаашид байгаль цаг уурын өөрчлөлт, эрсдэлийг даван туулах чадвартай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, бэлчээрийн даацдаа тохирсон аж ахуй болгон хөгжүүлэхгүй бол жил тутамд учирч буй өвөлжилтийн хүндрэл, тодорхой давтамжтай тохиож буй зудын улмаас малчин өрхийн амьжиргаа доройтож, улмаар хөдөөгийн ядуурлыг үүсгэх гол хүчин зүйл болж байна.

Иймээс Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дээрх асуудлаар тодорхой зорилтуудыг тусган хэрэгжүүлэх, малын индексжүүлсэн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх зэрэг бодлогын олон талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эрчим хүчний найдваргүй байдал эдийн засагт сөргөөр нөлөөлөх хандлагатай. Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь

хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээний 20 орчим хувийг импортолж байна. Мөн манай улсын эрчим хүчний хангамж нь төвлөрсөн системтэй ба станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Эрчим хүчний нийлүүлэлт тасалдах нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй. Тиймээс эрчим хүчний салбарт шинэчлэл хийх, тухайн салбарыг төрөлжүүлэх шаардлагатай.

Гадаад худалдааны үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа их хэвээр байна. Нийт экспортын 70 орчим хувь Замын-Үүд, Гашуунсухайт боомтод, импортын 90 гаруй хувь нь Алтанбулаг, Замын-Үүд, Гашуунсухайт боомтод ноогдож байгаа нь эдгээр боомтууд дээрх ачааллыг ихэсгэж, төвлөрлийг бий болгож байна. Гааль, хяналтын болон бусад холбогдох байгууллагуудын худалдааны үйл ажиллагааны үр ашгийг экспорт, импортын логиستيкийн үйл явцад зарцуулсан хугацаа, зардлаар хэмждэг хил давсан худалдааны үзүүлэлтээр Монгол Улс 2016 оноос хойш нийт 136 байраар ухарч, 2020 оны байдлаар 190 орноос 143 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Тиймээс эдийн засаг дахь төрийн зохицуулалтыг хялбарчилж, гадаад худалдааны үйл ажиллагаанд зарцуулж буй хугацааг багасгах шаардлагатай.

1.2 Нийслэл

Нийслэлд авто замын түгжрэл даамжирсаар байна. Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувийг эзэлдэг нийслэл Улаанбаатар хотод 2023 оны байдлаар нийт хүн амын 49 хувь нь оршин сууж, сүүлийн 10 жилийн хүн амын жилийн дундаж өсөлт 2.7 хувь байна. Хүн амын өсөлттэй зэрэгцэн Монгол улсын банкны нийт зээлийн 74.2 хувь, хадгаламжийн 82.2 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 65.4 хувь нь Улаанбаатар хотод бий болж, хотын эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, санхүүгийн салбарын хөгжилд түлхэц өгч байгаа боловч хотын одоогийн дэд бүтэц хэрэгцээг хангах боломжгүй болоод байна.

Улаанбаатар хотод бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийн тоо 712.9 мянга ба сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 47.0 мянган тээврийн хэрэгсэл нэмэгдэж, нийслэлийн нийт өрхийн 72.2 хувь нь автомашин эзэмшиж, улсын нийт авто тээврийн хэрэгслийн 56 хувь нь Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөнд оролцож байна. Иргэдийн авто машин эзэмшлийн өсөлттэй харьцуулахад авто замын сүлжээний хүчин чадал сүүлийн 10 жилд ердөө 19 хувиар нэмэгдсэн бол авто замын ачаалал 3 дахин нэмэгдсэн.

Улаанбаатар хотод өдөрт давтагдсан тоогоор 2,882,317 удаагийн замын хөдөлгөөний зорчилт хийгддэг ба хотын иргэдийн дийлэнх буюу 83 хувь нь ажил, сургууль, цэцэрлэг, төрийн үйлчилгээ авах, албан хэргээ гүйцэлдүүлэх зорилгоор замын хөдөлгөөнд оролцдог ба ингэхдээ 24 хувь нь нийтийн тээврийн хэрэгслээр, 64 хувь нь хувийн машинаар, 11 хувь нь явган болон унадаг дугуйгаар, 1 хувь нь бусад тээврийн хэрэгслээр зорчдог байна.

Тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцохдоо иргэд дунджаар өдөрт 3 цаг, жилд 33 өдрийг замын түгжрэлд өнгөрөөж, эрүүл мэнд, хөрөнгө санхүүгээрээ хохирч байна.

Нийслэлийн хэмжээнд 465.1 мянган өрх амьдарч байгаагаас 56.4 хувь буюу 262.3 мянган өрх нь орон сууцанд, үлдсэн 43.6 хувь буюу 202.8 мянган өрх нь гэр хороололд амьдарч байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын эх үүсвэрийн хувьд 55.6 хувийг гэр хороолол, 28.9 хувийг автомашин, 15.5 хувийг бусад эх үүсвэр эзэлж байна.

2024 оны хүйтний улирал 01 дүгээр сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад PM10 тоосонцор 7 мкг/м³-ээр буюу 5 хувиар, хүхэрлэг хий (SO₂) нь 17 мкг/м³-ээр буюу 10 хувиар бага, харин PM2.5 тоосонцор 4 мкг/м³-ээр буюу 4 хувиар, азотын давхар исэл (NO₂) нь 7 мкг/м³-ээр буюу 11 хувиар тус тус их байна.

Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, гэр хорооллын төлөвлөлтгүй тэлэлт, байгаль орчин доройтох, хүрээлэн буй орчны бохирдол нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх, үйлчилгээний салбар доголдох зэргээр хот, суурин газарт тулгамддаг асуудал хуримтлагдаж нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байна. Тиймээс авто замын ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого баримтлах шаардлагатай байна.

Инженерийн дэд бүтцийн хүртээмж хангалтгүй байна. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн систем нь Дулааны цахилгаан станц II, III, IV болон Амгалан дулааны станцаас хангагдах ба нийт 13,450 гаруй барилга, байгууламжийг дулааны эрчим хүчээр хангадаг. Улаанбаатар хотод жилд дунджаар 221-244 МВт (190-210 Гкал/ц)-ийн хэрэглээ бүхий 300 орчим барилга байгууламж төвлөрсөн дулаан хангамжид холбогдож, хэрэглээ 7-8 хувиар өсөн нэмэгдэж байна.

Дулааны эх үүсвэрийн суурилагдсан хүчин чадлаас 1,838.1 МВт (1,580.5 Гкал/ц)-аар илүү буюу 60 хувиар хэтэрсэн ачаалалттай байгаа нь цаашид хотжилт тэлэн барилгажих, төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдох боломжгүй байдалд хүрсэн байна.

2030 оны түвшинд нийслэлийн цахилгаан эрчим хүчний хэрэглээ 3,328 МВт хүрэх тооцоо боловсруулагдсан бөгөөд 1,848 МВт цахилгаан эрчим хүчний дутагдалд орно. Энэ нь хотын нийт хэрэглээний 55%-ийн эх үүсвэрийн чадлын дутагдалд орно гэсэн үг юм.

Суурилагдсан чадлаас илүү гарсан хэрэглээг хангахын тулд ОХУ-аас жилдээ 150.0 сая долларын импортын эрчим хүч авч хэрэглэж байна. Нийслэл хотод 220кВ-ын 53.3 км, 110кВ-н 352.2 км, 35 кВ-н 133.6 км цахилгаан дамжуулах агаарын шугамаар хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангаж байна.

2023-2024 оны өвлийн их ачааллын үед цахилгаан станцуудын эрчим хүчний нийлүүлэлт, хэрэглэгчдийн цахилгаан ачааллаас хамааран нэгдсэн сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор давхардсан тоогоор 1,484 фидерийн (цахилгааны шугамын тоо) 1,974,241 хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчийг 3,141МВт-аар хязгаарласан бөгөөд энэ нь эрчим хүчний системийн цахилгаан эрчим хүчний чадлын дутагдал орсон байна. Иймд эрчим хүчний эх үүсвэрийн өргөтгөл шинэчлэлт хийх, шинэ эх үүсвэр барих асуудал зайлшгүй тулгарсан байна.

Мөн хотын усан хангамжийн гол шугам сүлжээний 60% нь ашиглалтын хугацаа дуусаж, бохир ус цэвэрлэх хүчин чадал 17%-аар хэтэрч, ариутгах татуургын гол шугам сүлжээний 50% нь ашиглалтын хугацаа дууссан.


Зураг 3. Импортын цахилгаан эрчим хүч



1.3 Эрчим хүч

Эрчим хүчний салбарын эдийн засгийн алдагдал өссөөр байна. Сүүлийн жилүүдэд үнэ тарифт өөрчлөлт оруулалгүй тогтвортой мөрдөж ирсний улмаас эрчим хүчний салбар жил бүр алдагдалтай ажиллаж байна. Цахилгаан эрчим хүчний үнэ тариф үйлдвэрээс гарах бодит өртөг 1 кВт.ц цахилгааныг 243₮ бол айл өрхийн худалдан авч байгаа дундаж өртөг 142₮, аж ахуйн нэгж байгууллага дунджаар 215₮-р авч байгаа нь алдагдал үүсэх бодит нөхцөлийг бүрдүүлж байна.

Зураг 4. Эрчим хүчний салбарын алдагдал, тэрбум төгрөг



Эрчим хүчний салбар хэрэглээгээ бүрэн хангаж чадахгүй байна. Манай улс эрчим хүчний хэрэглээгээ дотооддоо бүрэн хангаж чадахгүй байгаа ба дутагдсан эрчим хүчээ БНХАУ, ОХУ-аас импортоор авч байна. Монгол улсын хэмжээнд 2023 оны гүйцэтгэлээр 10.9 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 9.9 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг түгээсэн байна. Нийт түгээсэн цахилгаан эрчим хүчний 75.5%-ийг дотоодын эх үүсвэрүүдээс, 24.5%-ийг импортын цахилгаан эрчим хүчээр тус тус хангасан байна. Нийт импортолсон цахилгаан эрчим хүчний 938.0 сая кВт.ц буюу 38.3%-ийг ОХУ-аас, 1,508.6 сая кВт.ц буюу 61.7%-ийг БНХАУ-аас тус тус авсан байна. Эрчим хүчний хэрэглээгээ дотооддоо бүрэн хангахын тулд том чадлын ДЦС, оргил ачааллын үед горим тохируулга хийх, их чадлын усан цахилгаан станц, усан цэнэгт, цэнэгт хураагуур болон хийн станцууд мөн нар салхины эх үүсвэрүүдийг үе шаттайгаар барьж байгуулж, суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зураг 5. ЦЭХ-ний үйлдвэрлэл болон хэрэглээ, сая кВт.ц



Сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал хангалтгүй байна. Манай улс нар салхины арвин их нөөцтэй хэдий ч сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин 18.3% байна. Улсын хэмжээнд арилжааны үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 155 МВт-ын салхин цахилгаан станц, 90 МВт-ын нарны эрчим хүчний эх үүсвэрүүд ажиллаж байна. 2023 онд нийт 8,528.3 сая квт.ц цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэсний 9.1% буюу 772.6 сая квт.ц цахилгааныг сэргээгдэх эрчим хүчний станцаар үйлдвэрлэсэн байна. Сэргээгдэх эрчим хүчний томоохон станцуудыг ашиглалтад оруулж хэрэглээгээ дотооддоо хангахаас гадна экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлж эрчим хүчний тасралтгүй найдвартай байдлыг хангах шаардлагатай байна.

Цахилгаан эрчим хүчний дамжуулалт түгээлтийн алдагдал нэмэгдсээр байна. Эрчим хүчний салбарын хэмжээнд эх үүсвэр болон цахилгаан дулааны дамжуулах, түгээх сүлжээний үндсэн тоног төхөөрөмжийн насжилт хэтэрсэн хуучирсан хүртээмж хангалтгүй байгаа нь цахилгаан дулааны эрчим хүч тасрах эрсдэлийг бий болгож байна. Цахилгаан эрчим хүчний дамжуулалт түгээлтээр цахилгааны 13%, дулааны эрчим хүчний 18-20% нь алдагдаж байна. Монгол Улсын хэмжээнд 8,299 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 105 ком дэд станц, 51,927 км цахилгаан түгээх шугам, 12,294 дэд станц байгаагаас хангайн бүсэд байрлах дэд станцууд болон Улаанбаатар хотын 110 кВ-ын 12 дэд станц 75-95%-ийн, Булган А, Б, Мөрөн, Бор-Өндрийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 90-96% хүртэл ачаалагдаж байна. Мөн хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн нийт шугам сүлжээний 90 орчим хувь нь дулаан нэвтрүүлэх хүчин чадал хүрэлцэхгүй болсон ба дулаан дамжуулах гол шугамуудын 24 гаруй хувь нь 30 жилээс дээш жил ажилласан, ашиглалтын хугацаа дууссан бол 76 хувь нь 30 хүртэлх жилийн насжилттай шугам байна. Үүнээс шалтгаалан хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх боломжгүй, оргил ачааллын үед хязгаарлах горимд хүргэж байна.

Зураг 6. Дамжуулалт болон түгээлтийн алдагдал, сая кВт.ц



Улаанбаатар хотын дулаан хангамж доголдол үүсэх эрсдэлд орсон. Улаанбаатар хотын эрчим хүчний эх үүсвэрүүдийн дулаан үйлдвэрлэлийн суурилагдсан хүчин чадал 2,318 Гкал/ц бол дулаан хангамжийн системд холбогдсон хэрэглэгчдийн тооцоот ачаалал 2023 онд 3,373.6 Гкал/ц ба суурилагдсан хүчин чадал 31.2%-р хэтэрсэн байна. Өөрөөр хэлбэл эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан хотын гадна агаарын тооцоот температур хэмийн утгад хүрч хүйтрэл удаан хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд эх үүсвэрийн дулаан хангамжийн суурилагдсан хүчин чадал хүрэлцэхгүй ба дулаан хангамжийн эх үүсвэрээс алслагдсан цэгүүдэд хүндрэл үүсэх нөхцөл байдалтай байна.

1.4 Аялал жуулчлал

Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийн хөгжил сул байна. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийн хөгжил сул, салбарын хүний нөөц бага, жуулчдад санал болгодог үйлчилгээний нэр төрөл багатай байгаагаас олон улсын аялал жуулчлалын индексийн үзүүлэлтээр доогуур байр эзэлж байна.

Хүснэгт 2. Аялал жуулчлалын хөгжлийн индекс, ДЭЗФ

Он	2013 он	2015 он	2017 он	2019 он	2021 он	2024 он
Улс	140	141	136	140	117	119
Байр	99	99	102	93	84	85


Улирлын хамаарал ихтэй байна. Аялал жуулчлалын салбар улирлын хамаарал ихтэй байгаагаас үүдэн салбарын тогтвортой байдал алдагдаж байна. Жилийн дөрвөн улирал тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллага цөөн байна.

Хүснэгт 3. Жуулчдын манай улсад ирсэн байдал, 2023 оны байдлаар, ҮСХ

Хугацаа	2023-I	2023-II	2023-III	2023-IV
Ирсэн жуулчид	78,056	226,848	486,188	594,013

Цөөн тооны улсаас жуулчид ирж байна. Тээвэр, логистик, газарзүйн байршлын онцлогоос хамааран агаарын тээвэр үнэтэй, аяллын компани, тур оператор, тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл бага байна.

Зураг 7. МУ-д аялж байгаа жуулчдын улс орны ялгаа



Нийт жуулчдын 84.3%-ийг 5 улсын жуулчид эзэлж байна. /2023 он/

Виз хөнгөвчлөх, агаарын тээврийн либералчлалыг эрчимжүүлэх шаардлагатай. Монгол Улсын виз хөнгөвчлөх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна. 2023 онд 34 улсын виз хөнгөвчилж, визгүй зорчих боломжийг бүрдүүлснээр тэдгээр улсын иргэд Монгол Улс руу зорчих болсон. Цаашид виз хөнгөвчлөх ажлыг эрчимжүүлснээр илүү олон улсын жуулчид манай улсыг зорин ирэх, сурталчлах боломж бүрдэж, цаашлаад салбарын орлого нэмэгдэх үр өгөөжтэй юм.

Салбарын хүний нөөц хангалтгүй, хүчин чадал багатай байна. Одоогийн байдлаар аялал жуулчлалын хөтөлбөртэй 17 их, дээд сургуульд 1,000 гаруй оюутан суралцаж байна. Хүний нөөц дутагдалтай байгаа нь салбарын томоохон асуудлуудын нэг юм. Салбарын хүний нөөц, ажиллах хүчнийг нэмэгдүүлэх нь нэн чухал шаардлагатай.

2024 онд “Go Mongolia” уриатайгаар биет болон цахим сурталчилгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Гадаад болон дотоодод шаардлагатай арга хэмжээнүүдийг зохион байгуулж, зорилтот сурталчилгаа хийж байна. Мөн хил орчмын аялал жуулчлал хөгжүүлэх хүрээнд БНХАУ-тай хиллэдэг 4 хилийн боомтоор автомашинтай зорчих боломжтой болж, цаашид хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх санал дэвшүүлээд байна.

1.5 Соёл

Монгол Улсын Засгийн газраас соёлын салбарын соёлын бүтээлч үйлдвэрлэлийг ДНБ-ний 4 хувьд хүргэх зорилт тавьсан бөгөөд хууль, эрх зүйн хүрээнд “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл (2022-2027), “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээ (2022-2030 он)”-г тус тус батлан хэрэгжүүлж байна.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай. Дэлхийн эдийн засагт соёлын бүтээлч үйлдвэрлэл 2.2 их наяд доллароор хэмжигддэг бөгөөд 29 сая хүнийг ажлын байраар хангаж байгаа том зах зээл боловч Монгол Улсын соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын үнэлгээ 143 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 0.4 хувийг эзэлж байна. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэл арга хэмжээний хүрээнд Монголыг сурталчлах контентуудыг хийж, олон нийтийн цахим сүлжээгээр түгээн танилцуулж, нийгмийн сүлжээнүүдээр нийтэлсэн бөгөөд цаашид үргэлжлүүлэх нь монгол улсад соёлын аялал жуулчлал хөгжих монгол улсыг дэлхий дахинд сурталчлах нөхцөл бүрдэж дэлхийн зах зээл дээр өрсөлдөөд эхэлбэл энэ тоо ДНБ-ий дөрвөн хувь болж арав дахин өснө.

Монгол брэндийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай. Монгол Улсын Олон улс дахь сурталчилгаа мэдээллийн үндэсний хорооны үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулах хүрээнд Монгол Улсыг олон улсад сурталчлан таниулах үйл ажиллагааг идэвхжүүлж, гадаадад сурталчлах өнгө төрхийг тодорхойлох “Welcome to Mongolia”, “Go Mongolia” түлхүүр үгийг бий болгосон. Тус түлхүүр үг нь үндэсний брэнд аялал жуулчлал, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг шингээсэн Монгол Улсын нэгдсэн дүр төрх, онцлог, мөн чанарыг илэрхийлэх Монгол брэнд юм.

Соёлын салбарын төсөв, хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэх шаардлагатай. Соёлын салбарын бүх зардлыг үндсэн нэг хөтөлбөр буюу “соёл урлаг” хөтөлбөрт тусгаж байгаа нь учир дутагдалтай ба салбараас иргэдэд үзүүлж буй соёлын үйлчилгээний үр дүн, гүйцэтгэлийг гарц, бүтээгдэхүүний төрөлтэй уялдуулан тодорхойлох шаардлага тулгарч байна. Эцсийн хэрэглэгч болох иргэд, олон нийтэд театр, чуулгын, сонгодог урлагийн, номын сангийн болон музейн үйлчилгээ, соёлын боловсрол, соёлын өв, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээг

үзүүлэхийн тулд төсвийн зориулалт, зарцуулалт, үр дүнг тодорхойлох хянах, нөгөө талаас соёлын үзвэр, үйлчилгээний хэлбэрийг олон улсын чиг хандлагад нийцүүлэх шинэчлэх, дэлхийн зах зээлд нэвтэрсэн соёлын шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоход салбарын хөтөлбөрийн төрлийг оновчтой тодорхойлж, зориулалтыг сайжруулах асуудал чухал байна. Энэ хүрээнд соёлын салбарын төсөв, хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дараах 4 хөтөлбөрөөр төсвийг төлөвлөж, зарцуулах шаардлагатай байна. Үүнд:


1. Соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг театр чуулга, соёлын төв, номын сангийн үйлчилгээ, музейн үйлчилгээ, хөрөнгө оруулалт;
2. Соёлын өвийн чиглэлд соёлын өвийг хамгаалах, хөгжүүлэх, сурталчлах үйлчилгээ, судалгаа;
3. Соёлын бүтээлч үйлдвэрлэл;
4. Соёлын бодлого, удирдлага гэсэн зарлагын 4 хөтөлбөрөөр төсвийг төлөвлөж, зарцуулалтад хяналт тавих шаардлагатай байна.

Түүнчлэн соёлын салбарын удирдлагын тогтолцоог тогтвортой байлгах асуудал чухал ба соёл урлагийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх, соёлын бүтээлч үзвэр үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх соёлын аялал жуулчлалыг эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлагатай.

1.6 Уул уурхай

Уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл нэг төрлөөс хамааралтайгаас гадна байгалийн баялгийн олборлолтоороо дэлхийд доогуур байр эзэлж байна. 2023 онд PWC байгууллагаас хийсэн “Уул уурхайн салбарын дахин бүтээн байгуулалтын эрин” хэмээх судалгаанд нүүрсний томоохон уурхай сүүлийн 10 жилийн хугацаанд 40 гаруй хувиар буурсан. Харин газрын ховор “Critical mineral” буюу ховор элементийг эрэл хайгуул хийн, салбарт огцом өөрчлөлт гарах шинэ үе иржээ гэж дүгнэсэн байна. Цахилгаан хэрэгсэл, цахилгаан машин гэх мэт батареин технологи руу шилжиж буй энэ цаг үед зэс, лити, никель, кобальт гэх мэт ховор элементийн эрэлт хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ өсөж байгаа хэдий ч манай улсын хувьд нэр, төрлийн хувьд харьцангуй цөөн, технологийн агууламж бага, голдуу хагас боловсруулсан бүтээгдэхүүн хэлбэрээр экспортолж байна.

Зураг 8. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувь



Мөн уул уурхайн салбартай холбоотой газар нутаг, байгаль орчинд сөрөг үр дагавартай гэж дүгнэдэг ч нийт газар нутгийн 1.2 хувьд ашиглалтын үйл ажиллагаа явагдаж байна. Эндээс манай улс ГШХО-аар дамжуулан дэлхийн зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхэд газар нутгийн хувьд ашиглалтыг нэмэгдүүлэх боломж байгааг харуулж байна.

Хайгуулын шатны үйл ажиллагаа сайн хийгдэж байж дараагийн Эрдэнэт, Оюу толгой гэх мэт Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулах уурхай үйл ажиллагаа явуулах боломж нээгдэж, эдийн засаг, нийгэмд баялгаас хүртэх өгөөж нэмэгдэнэ.

Иймд манай улс салбарын ирээдүйн чиг хандлагатай нийцүүлэн ховор элементэд багтах, хариуцлагатай уурхайг хөгжүүлэх бодлогыг төрөөс барих хэрэгцээ үүсэж байгаа бөгөөд, Экспортын бүтээгдэхүүний боловсруулалтын шатыг ахиулах, нэмүү өртөг шингэсэн байдлыг өсгөх, цаашлаад төрөлжүүлэх, үүний тулд аж үйлдвэржилтийг сэргээн эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ хүрээнд нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нефть-хими, кокс-хими, металлургийн үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан хийн үйлдвэрлэл, технологийн парк, ган төмөрлөгийн үйлдвэр зэрэг өндөр технологийн хүнд үйлдвэрийн цогцолборуудыг хөгжүүлэх шаардлагатай байна.

1.7 Зам, тээвэр, боомт

Авто зам

Монгол Улс олон улсын тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдоогүй байгаа бөгөөд олон улс, улсын чанартай авто замын сүлжээний хатуу хучилттай авто замын уртыг нэмэгдүүлж, олон улсын тээвэр логистикийн сүлжээнд холбогдох нөхцөлийг бий болгох шаардлагатай байна. Улсын хэмжээнд авто замын сүлжээний нийт урт нь 111,916.7 км. Үүнээс 14,921.3 км буюу 13 хувь нь олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд хамаардаг. Олон улс, улсын чанартай авто замын сүлжээний 50.5 хувь буюу 7,535.6 км нь хатуу хучилттай авто зам байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан Монгол Улсын авто замын үндэсний сүлжээг бий болгох зорилтын хүрээнд 2020-2023 онд улсын хэмжээнд нийт 896.1 км хатуу хучилттай авто зам, 3,172.51 у/м гүүрийг барьж ашиглалтад оруулан 21 аймгийн төв, 104 сум, 5 хилийн боомт хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдоод байна.

Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврийг нэмэгдүүлэх, боомтуудын төвлөрлийг бууруулах шаардлагатай бөгөөд экспортын тээврийн ачаа тээвэрлэх хүчин чадал сул хэвээрээ байна. Монгол Улс нь нийт 3,349.4 км /дэлгэмэл урт/ төмөр замын сүлжээтэй бөгөөд нийт 12,235 хөдлөх бүрэлдэхүүн бүртгэлтэй байгаагаас зүтгүүр 190, ачааны вагон 11,724, зорчигчийн вагон 321 байна.

Төмөр замын сүлжээг өргөтгөх ажлын хүрээнд 2023 онд Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг байнгын ашиглалтад оруулан, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтыг дуусган туршилтын тээврийг эхлүүлээд байна.

Агаарын тээвэр

Үндэсний агаарын тээврийн өрсөлдөх чадварыг сайжруулах, тийзийн үнэ хямдруулахын тулд агаарын тээврийн либералчлахыг үргэлжлүүлэх, олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай. Монгол Улс нийт 16 агаарын хаалгатай бөгөөд ОХУ-тай 10 агаарын хаалгаар, БНХАУ-тай 6 агаарын хаалгаар хиллэдэг. Монгол Улсын агаарын зайг 6 секторт хуваан агаарын навигацийн үйлчилгээг үзүүлж байна.

Одоогийн байдлаар олон улсын 16, орон нутгийн 8 нийт 24 чиглэлд 16 агаарын тээвэрлэгч нислэг үйлдэж байна. Монгол Улсад нийт 60 агаарын хөлөг байгаагаас

4 агаарын хөлөг гадаад улсад бүртгэлтэй байна. Үүнээс 30 агаарын хөлөг нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.

Улсын хэмжээнд нийт 25 нисэх онгоцны буудал байгаагаас олон улсын 5, орон нутгийн 20 нисэх онгоцны буудал байна. Үүнээс 4E ангилал 1, 4D ангилал 1, 4C


Далай ашиглалт, усан замын тээвэр 2023 оны байдлаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгүүлсэн нийт 375,823.9 тонны даац бүхий 25 орны 270 хөлөг онгоц Монгол Улсын төрийн далбааг мандуулан далайд аялж байна.

Улсын бүртгэлд 2023 оны байдлаар гэрчилгээ, улсын дугаартай нийт 206 усан замын тээврийн хэрэгсэл байна. Усан замаар 2023 онд 64.7 мянган зорчигч тээвэрлэсэн бөгөөд 2022 онтой харьцуулахад 71 хувиар өссөн байна.

Тээврийн салбарын орлого болон зорчигч, ачаа тээвэр

2023 онд тээврийн нийт орлого 6.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 52.1%-аар өсжээ. Үүнээс авто тээврийн орлого 4.7 их наяд төгрөг болж өмнөх оноос 47.3%-аар, төмөр замын тээврийн орлого 1.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 50.4%-аар, агаарын тээврийн орлого 941.9 тэрбум төгрөг болж өмнөх оноос 83.6%-аар, усан замын тээврийн орлого 1.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 2.5 дахин өссөн байна.


Зураг 9. Тээвэрлэлтийн орлого, тэрбум төгрөг



Эх сурвалж: ЗТХЯ


2023 онд бүх төрлийн тээврээр 146.5 сая зорчигч тээвэрлэсэн бол ачаа тээврийн хэмжээ 107.4 сая тонн болж түүхэн амжилт тогтоолоо.

Зураг 10. Зорчигч тээвэр, сая хүн



Эх сурвалж: ЗТХЯ

Зураг 11. Ачаа тээвэр, мянган тонн



Боомт

Дэлхийн банкны 139 орныг хамруулсан тээвэр логиستيкийн гүйцэтгэлийн индексийн 2023 оны тайланд Монгол Улс 2.5 оноотойгоор 97-д бичигджээ. Монгол Улс нь далайд гарцгүй орон бөгөөд хамгийн том асуудал нь тээвэрлэлтийн дэд бүтэц сул байгаа ба тус тайланд дурдсанаар Монголд боомтоор ачаа бараа орж ирэх дундаж хугацаа нь 25 өдөр байдаг байна. Монгол Улсад хилийн 24 боомт ажиллаж, 184 орны 5.3 сая зорчигч, 89 орны 5.2 сая тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлж, өмнөх оноос зорчигч 2.6 дахин, тээврийн хэрэгсэл 1.9 дахин өссөн. Чингис хаан, Замын-Үүд, Сүхбаатар, Боршоо боомтуудыг өргөтгөн шинэчилж, хилийн Алтанбулаг, Гашуунсухайт, Цагаандэл-Уул боомтын бүтээн байгуулалтын ажил үргэлжлэн хийгдэж байна.

Шалган нэвтрүүлэх албанд ашиглах “Гэрэгэ-24” системийг хөгжүүлж, “Чингис хаан” олон улсын агаарын боомтод E-Gate цахим гарцыг нэвтрүүлсэн. Хилийн цэргийн 0245 дугаар ангийн “Хүдэн”-гийн заставын хариуцсан хэсэг болон “Боршоо” боомтод 52 км шилэн кабелийг татан, “Боршоо” боомтод 12 ширхэг дулаан мэдрэгч камер суурилуулж, дохиолол, хяналтын системийг ажиллагаанд оруулсан.

Монгол Улсын Засгийн газраас гадаад худалдааг хөнгөвчлөх, экспортын зах зээлийг өргөжүүлэх, хилийн боомтуудын дэд бүтцийг нэмэгдүүлж, ачаа нэвтрүүлэх процессыг хөнгөвчлөх, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог өргөжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Импортоор бараа, бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой бүх төрлийн гэрээний бүртгэлийг автоматжуулж, бараа нэвтрэх боомтыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр байна. Мөн эдийн засгийн идэвхжил өндөр байж завсрын хэрэглээний бүтээгдэхүүний импорт нэмэгдэж, импортын өсөлтөд голлох нөлөөг үзүүлэхээр байна.

Экспортын тээвэрлэлтийг боомтуудаар авч үзвэл, Гашуунсухайт боомтоор 36.7 сая тонн, Шивээхүрэн боомтоор 19.1 сая тонн, Булган боомтоор 2.7 сая тонн бусад боомтоор 9.7 сая тонн ачаа тээвэрлэсэн байна. Экспортын тээвэрлэлтэд уул, уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт голлож байгаа бөгөөд нүүрсний экспорт 119.2 хувиар, газрын тосны экспорт 51.6 хувиар, зэсийн баяжмалын экспорт 25.2 хувиар тус тус өссөн байна.

ХОЁР. НИЙГМИЙН ХӨГЖИЛ


2.1 Эрүүл мэнд

Монгол Улсын хүн амын өвчлөл, нас баралт буурахгүй байна. Монгол улсад сүүлийн 30 жилд урьдчилан сэргийлж, эрт илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх боломжтой, хүн амын зан үйл, нийгмийн хүчин зүйлээс ихээхэн шалтгаалдаг халдварт бус өвчин зонхилж, үүнээс шалтгаалсан нас баралт нэмэгдсээр байна. Халдварт бус өвчний тэргүүлэх шалтгаанд хоол боловсруулах, амьсгал, зүрх судас, шээс бэлгэсийн

тогтолцооны өвчин орж, архаг хэлбэрт шилжин, хожуу үед оношлогдон, өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ авч санхүүгийн өндөр эрсдэл дагуулж байна.

2023 онд улсын хэмжээнд хүн амын өвчлөлийн тохиолдол 3.8 саяд (давхардсан тоогоор) хүрч, 2014 оноос 1,546.1 мянгаар, өмнөх оноос 237.8 мянгаар тус тус нэмэгдсэн байна.

Зураг. 12. Хүн амын нийт өвчлөл, 10,000 хүн амд, хүйсээр



Хүн амын нас баралтын хувьд зүрх судас, хавдар, гэмтэл, хордлого, гаднын шалтгаант нас баралт тэргүүлж байна. Эрэгтэйчүүдийн хувьд зүрх судасны өвчнөөр нас барсан тохиолдол эмэгтэйчүүдтэй харьцуулахад 3 дахин өндөр байна. Харин осол гэмтлээр нас барсан тохиолдол 4 дахин өндөр байгаагийн дийлэнх хувийг архины хордлого, амиа хорлолт, зам тээврийн осол эзэлж байна. Насны хувьд эрэгтэйчүүдийн 50.2 хувь нь ид хөдөлмөрийн насандаа (30-60 нас) нас барж байна.

Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоо бүрдээгүй байна. Үндэсний хэмжээнд 5 жил тутам хийгддэг халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтын судалгаагаар хүн амын дундах тамхины хэрэглээ 24.2 хувь, өөх тосны хэрэглээ 87.2 хувь, давсны хэрэглээ ДЭМБ-аас зөвлөмж буй хэмжээнээс 2 дахин өндөр буюу 10.5 гр, илүүдэл жинтэй хүн амын эзлэх хувь 30.9, хүн амын 18.5 хувь таргалалттай гарсан байна. Өөрөөр хэлбэл хүн амын дунд эрүүл амьдралын хэв маяг, зан үйл хэвшээгүй, иргэдийн эрүүл мэндийн боловсрол хангалтгүй байна.

Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан нь халдварт бус өвчлөл байгаа нь иргэдэд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх нэгдсэн тогтолцоо, орчин бүрдээгүйтэй холбоотой. Нийслэл, орон нутагт нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц зохион байгуулалт байгаа ч 70 гаруй хувь нь захиргааны үйл ажиллагаа эрхэлдэг ба бие даасан төвийн үйл ажиллагаа явуулахгүй байна.

Иргэд өвдөхөөсөө өмнө бус өвдсөн хойно эмнэлэгт ханддаг хандлага түгээмэл байсаар байгаа бөгөөд олон улсад нийгмийн эрүүл мэндийн болон анхан шатны суурь тусламж үйлчилгээний хамрагдалт 58 хувьтай байхад манай 19.6 хувьтай байна. Нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний хамрагдалт олон улсад 17.2 хувь байхад манай улсад 40.5 хувь байгаа нь тусламж үйлчилгээний санхүүжилт бүхэлдээ эмнэлэгт суурилсан тусламж үйлчилгээнд зарцуулагдаж байгааг харуулж байна.

Хүн амын эрүүл мэндийн хамралт дэлхийн дунджаас доогуур байна. Тогтвортой хөгжлийн зорилтын 3.8-д заасан эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний хамралтыг нийт 14 үндсэн үзүүлэлтийн дунджаар тооцоолж гаргадаг бөгөөд Монгол улсад эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж

үйлчилгээний хамралт /2021 оны байдлаар/ 65 хувь байгаа нь дэлхийн дунджаас 3, бүсийн дунджаас 11 хувиар тус тус бага байна.

Эмийн үнэ өндөр, эмийн чанарын хяналт сул байна. Хүн амын өвчлөл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээг даган эрүүл мэндээс үүдэлтэй зардал жил ирэх тусам нэмэгдэж байна. ДЭМБ-аас хүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад хувь хүний хармаанаасаа төлөх төлбөрийн хэмжээ 25 хувиас хэтрэхгүй байх нь оновчтой болохыг улс орнуудад зөвлөдөг. Тэгвэл энэ үзүүлэлт манай орны хувьд 35.4 хувь байна. (Эрүүл мэндийн үндэсний тооцоо 2016-2021 он, ЭМХТ)

Эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлд өртөх үзэгдэл хүн амын хамгийн ядуу болон хамгийн чинээлэг бүлгийн аль алинд тохиолддог учир Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэхээр зорьж байгаа манай орны хувьд эмийн үнийг бууруулах, эмийн үнэд зохицуулалт хийх асуудал тулгамдсан асуудал болж байна.

Хөдөө орон нутагт эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай, нийгмийн баталгаа хангалтгүй байна. Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа 63 мянган ажиллагсдын 13,900 гаруй их эмч 13,400 гаруй сувилагч ажиллаж байна. Өөрөөр хэлбэл эмч, сувилагчийн харьцаа улсын хэмжээнд 1:1 байна гэсэн үг. Гэтэл энэ үзүүлэлт олон улсад 1 их эмчид дор хаяж 3 сувилагч ногдож байж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртээмжтэй байна гэж үздэг.

Нийт ажиллагсдын 82 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааны чиглэлээр 2022 онд хийгдсэн судалгааны дүнгээр Улаанбаатар хотод амьдарч байгаа эрүүл мэндийн ажилтны 45.1 хувь, аймгийн төвийн хувьд 49.1 хувь нь гэр болон хашаа байшинд амьдарч, нийт ажилчдын 89 хувь нь “зээлтэй” гэсэн судалгааны дүн гарсан байна.

Эрүүл мэндийн салбарын цахим шилжилт удаашралтай байна. Дэлхийн банкны дэмжлэгтэй “Цахим эрүүл мэнд” төсөл 2016 оноос тус салбарт хэрэгжсэн хэдий ч “Эрүүл мэндийн өгөгдөл солилцооны платформ” HIEP нэвтрүүлэх үйл ажиллагаа төслийн санхүүжилт зогссонтой холбоотойгоор хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

Үүний улмаас эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 4,000 гаруй эрүүл мэндийн байгууллагын ашиглаж байгаа 37 төрлийн программ хангамж хоорондоо мэдээллээ солилцох боломжгүй нөхцөл байдал үүсэж байна.

УИХ-аар батлагдаж 2022 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж байгаа Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад эрүүл мэндийн салбарын лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлж байгаа 58 эрүүл мэндийн байгууллага орсон.

Нэг талаас хувь хүний эрүүл мэндийн нууцлалын асуудалтай холбогдох мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нөгөө талаас Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилтод дэвшүүлсэн эрүүл мэндийн статистик мэдээллийг нотолгоонд суурилсан үнэн зөв гаргах, эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа программ хангамжийн мэдээлэл солилцооны шуурхай байдлыг хангах, хөгжүүлэлтийг тогтмол хийх, хяналт тавих зорилтыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага бий болж байна.

Сумдын эмнэлгүүдийн ариун цэврийн байгууламж хангалтгүй байна.

“Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2019 оны судалгаа”-аар нийт сумын эрүүл мэндийн төвийн 19 хувь нь төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон бол 81 хувь нь хэсгийн усан хангамжийн системтэй байна.

Нийт сумын эрүүл мэндийн төвийн 71 хувь нь гадна байрлах АЦБ (ариун цэврийн байгууламж)-тай, 11 хувь нь дотор байрлах ариун цэврийн өрөөтэй, 18 хувь нь

хоёуланд нь ашиглаж байна. Үүнээс гадна байрлах АЦБ-тай сумын эрүүл мэндийн төвийн 43 хувь нь амбулаториор үйлчлүүлэгчдэд зориулсан тусдаа АЦБ-гүй, 52 хувь нь ажилчдад зориулсан тусдаа АЦБ-гүй байна.

Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого, зарлагын түвшин тэнцвэргүй байна.

Ажил олгогчийн орлогоос шимтгэл төлж буй даатгуулагч нь 2023 оны байдлаар нийт даатгуулагчийн 24 хувийг эзэлж байгаа бөгөөд даатгалын сангийн орлогын 69.2 хувийг бүрдүүлж, сангийн зардлыг 13.7 хувийг хүртсэн байна. Гэтэл төр хариуцах иргэд нь нийт даатгуулагчийн 71 хувийг эзэлж, даатгалын сангийн орлогын 27.4 хувийг бүрдүүлж, сангийн зардлын 77 хувийг хэрэглэж байна.

Зураг 13. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага, нийт даатгуулагчаас эзлэх хувь



Төрөөс олгож буй шимтгэлийн орлого болон эрүүл мэндийн даатгалын сангаас зарцуулж буй зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2023 онд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд 82.1 тэрбум төгрөгийн орлогыг, 678.4 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байгаа бөгөөд зардал нь бүрдүүлж буй орлогоос 8.3 дахин их байна.

Бусад даатгуулагч болох хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого болон тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2023 онд хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн шимтгэлийн орлого 21.9 тэрбум төгрөг, 100.1 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байгаа бөгөөд зардал нь бүрдүүлж буй орлогоос 4.6 дахин их байна.

Ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлого болон тусламж, үйлчилгээний зардлын гүйцэтгэлийг харьцуулан үзвэл 2023 онд 616.1 тэрбум төгрөг шимтгэлийн орлогыг бүрдүүлсэн бөгөөд 192.2 тэрбум төгрөгийн тусламж, үйлчилгээг зардлын гүйцэтгэлтэй байна.

2.2 Боловсрол

Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж муу байна. 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн цэцэрлэг 25-р нэмэгдсэн боловч хувийн хэвшлийн цэцэрлэгийн тоо 28-аар буурч улсын хэмжээнд нийт цэцэрлэгийн 80% нь тогтоосон нормативаас хэтэрсэн үзүүлэлттэй байна.

Хувийн хэвшлийн цэцэрлэгийн тоо буурах болсон гол шалтгаан нь төрийн өмчийн цэцэрлэгийн нэг хүүхдэд ногдох м2 5.6 байсныг 4 болгосон, цэцэрлэгийн түрээсийн

байр нэмэгдүүлсэн, орон нутагт явуулын багшийн үйлчилгээг бий болгож байгаа зэрэг нь хувийн хэвшлийн цэцэрлэгийг сонгогчдын тоог бууруулж байгаа бөгөөд зарим хувийн хэвшлийн цэцэрлэг үйл ажиллагаагаа зогсооход хүрсэн байна.

Зураг 14.Бүлэг дүүргэлт аймгаар



Ерөнхий боловсролын сургуулийн тоо жил тутам өсөж байгаа ч бүлэг дүүргэлт норматив хэмжээнээс хэтэрсэн хэвээр байна. Улсын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд 871 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх онотой харьцуулахад 1.4 хувиар өссөн үзүүлэлт боловч нийт сургуулийн бүлэг дүүргэлт стандарт түвшнээс хэтэрсэн хэвээр буюу нэг багшид ногдох хүүхдийн тоо 20.9 байна. Нэг багшид ногдох хүүхдийн тоо өндөр байгаагаас шалтгаалан багш хүүхэд бүрд хүрч ажиллаж чадахгүй байна. Энэ нь боловсролын чанарт сөргөөр нөлөөлөх бас нэгэн гол үзүүлэлт юм.

Өмнөх онд 3 ээлжээр хичээллэх эрсдэлтэй 68 сургууль байснаас сургалтын орчинд тохирсон барилга түрээслэх, боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажиллан 2023-2024 оны хичээлийн жилд 8 сургуулийн 64 бүлэгт 2,418 хүүхэд гурван ээлжээр хичээллэж байна.

Зураг 15. ЕБС-ын бүлэг дүүргэлт




Боловсролын салбарт чадварлаг хүний нөөц дутмаг байна. Боловсролын салбарын хүний нөөцийн жил ирэх тутам буурч байна. 2023-2024 оны хичээлийн жилд багшийн хангалт 93.3-92 хувьд хүрсэн нь 1.3 хувиар буурсан үзүүлэлт юм.

Багшийн ажиллах цаг урт, үнэлэмж, цалин хөлс муу зэргээс шалтгаалан багш мэргэжлийг эзэмшигчид болон, багш мэргэжлийг сонгон суралцагчдын тоо буурч байна. Тухайлбал 2019 оноос хойш багшийн цалин нийт 5 удаа нэмэгдэж дундаж цалин хөлс 1,465.4 мянгад хүрсэн боловч энэ нь улсын дундаж цалин хөлсөнд хүрэхгүй хэвээр байна.

Цаашид багшийн ажлын чанар, сургалтын үр дүнг үнэлж, багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох, өөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлээ удирдах, хариуцлагатай хандах соёлыг төлөвшүүлэх, улмаар сургалтын чанарыг сайжруулах зорилгоор “Багшийн гүйцэтгэлийн үнэлгээг” зохион байгуулж байгаа ба 2022-2023 оны хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд гүйцэтгэлийн үнэлгээнд 10,675 багш хамрагдаж улсын дундаж үзүүлэлт 51.6, нийслэлийн дундаж 53.4 хувьтай үнэлэгдсэн байна.

Багш мэргэжилтнүүдийн мэргэжлээрээ ажиллахгүй байгаа болон ажлаасаа гарсан шалтгааны 60.4 хувийг өөрийн хүсэлтээр, 39.6 хувийг эрүүл мэндийн шалтгаан, өөр албан тушаалд томилогдсон, тэтгэвэрт гарсан гэх мэт шалтгаанууд эзэлж байна.


Зураг 16. ЕБС-ын мэргэжлийн хангалт



Эх сурвалж: БШУ-ны салбарын статистик 2022/2023

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын чанар хүртээмж муу байна. Мэргэжлийн боловсролын салбарын хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт ихтэй 8 мэргэжлийн хөтөлбөрийг сонгон чанарын үнэлгээ хийхэд улсын дундаж 66.6 хувьтай буюу дунд түвшинд хүрэхгүй байгаа нь сургалтын чанар муу байгааг илтгэж байгаа буюу хөдөлмөрийн зах зээл дээр нийт 70.9 мянган ажилгүй иргэд байгаагийн 3 хүн тутмын 1 нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байна.

Зураг 17. Эрэлттэй 8 мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ



Эх сурвалж: БШУ-ны салбарын статистик 2022/2023

Тусгай хэрэгцээт цэцэрлэг, сургуулийн хүртээмж муу байгаагаас ХБХ бүрэн хамрагдаж чадахгүй байна. Улсын хэмжээнд тусгай хэрэгцээт хүүхдэд зориулагдсан орчинтой сургууль, цэцэрлэгийн хүртээмж дутмаг байгаа буюу стандарт орчин, нөхцөлөөр хангагдсан 10 цэцэрлэг, 6 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бол Улсын хэмжээнд ерөнхий боловсролын 871 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 110 сургууль нь ХБХ зориулагдсан орчин нөхцөлөөр хангагдсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 0-5 насны нийт 1,930 хүүхдээс 1,498 хүүхэд нь тусгай хэрэгцээт цэцэрлэгт, 6-17 насны 9,500 хүүхдээс 5,653 хүүхэд нь тусгай хэрэгцээт сургуульд тус тус хамрагдсан байгаа буюу цэцэрлэг, сургуулийн хүртээмж муугаас ХБХ бүрэн хамрагдаж чадахгүй байна.

2.3 Барилга

Нийт өрхийн 62 хувь нь инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжгүй байшин хороолол болон гэр сууцанд амьдарч байна. 2022 оны байдлаар манай улсын нийт 941.4 мянган өрхийн 32.1 хувь буюу 302.2 мянган өрх нь инженерийн дэд бүтцийн шаардлага хангасан орон сууцанд амьдардаг бол 29.7 хувь буюу 279.6 мянган өрх нь инженерийн дэд бүтцийн бүрэн хангамжгүй байшин хороололд, 38.2 хувь буюу 359.7 мянга нь гэр сууцанд тус тус амьдарч байна.

Зураг 18. Зураг. Орон сууцны төрөл (нийт өрхөд эзлэх хувиар)



Эх сурвалж: Барилга, хот байгуулалтын яам

2023 оны эхний 3 улирлын байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 11,346 айлын орон сууц ашиглалтад орсон бол үүний 83 хувь нь нийслэл хотод ашиглалтад орсон байна. Ипотекийн зээлээр хөтөлбөр эхэлснээс хойш 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газар, Монгол банк, арилжааны банкнуудын эх үүсвэрээр нийт 114.8 мянган иргэнд хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээлийг олгоод байна.

Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар барилга угсралт, их засварын ажлын 40.2 хувийг орон сууцны барилга, 33.9 хувийг орон сууцны бус барилга, 22.1 хувийг инженерийн барилга, байгууламж, 3.8 хувийг их засварын ажил тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон сууцны барилга 20.86 хувиар, орон сууцны бус барилгынх 41.30 хувиар, их засварын ажил 45.17 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байгаа бол инженерийн барилга байгууламж 13.51 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 19. Барилга угсралт, их засварын ажил (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгаруулалт өндөр байна. Барилгын салбар нь дэлхийн нийт ДНБ-ний 13 хувь, хүлэмжийн хийн ялгаруулалтын 23 хувийг эзэлдэг ба материалын урсгалын 30-40 хувь нь энэ салбарт ногддог байна.

Ногоон барилга нь хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, цаг уур, эрчим хүч, усны хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй барилга байгууламж бөгөөд байгалийн үнэт баялгийг хадгалж, амьдралын чанарыг сайжруулж, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, барилгын материал ашигласан, дулааны алдагдал бага байх хийцтэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, сэргээгдэх эрчим хүчээр шийдсэн, цас, борооны усыг хуримтлуулж дахин ашиглах технологитой байх шаардлагатай байна.

Шинжилгээгээр ундны усны эрүүл ахуй, чанар, аюулгүй байдал шаардлага хангахгүй байна. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс /тухайн үеийн нэрээр/ Монголын Шинжлэх ухааны академи, Шинжлэх ухааны академийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Химийн хүрээлэнтэй хамтран хийсэн Монгол Улсын ундны усны чанарын судалгааг 21 аймгийн 330 сум, Улаанбаатар хотын 9 дүүрэг, 128 төмөр замын зөрлөг, бусад суурин газрын ус түгээх байр, гүний худаг болон төвлөрсөн шугам сүлжээний 3,582 цэгээс сорьц авч 88 үзүүлэлтээр усны чанарыг тодорхойлсон. Шинжилгээний дүнгээр 1,367 сорьц ундны усны эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй байна.

Улсын хэмжээнд 330 сум, 21 тосгон, 128 төмөр замын зөрлөгт хүн амын суурьшил үүсэж, эдгээр суурин газруудад бохир ус цэвэрлэх байгууламж байх шаардлагатай бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар 85 төв, суурин газар бохир ус цэвэрлэх байгууламжтай бөгөөд эдгээрээс 24 цэвэрлэх байгууламж нь ашиглалтын шаардлага хангахгүй болсон байна. Мөн шинээр баригдаж байгаа болон ашиглалтад хүлээж аваагүй 23 цэвэрлэх байгууламж байна.

Улс орны санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл, байдлаас шалтгаалан хот, суурин газрын ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих санхүүгийн эх үүсвэр дутагдах хандлагатай байна.

Орон сууцны тухай хуульд заасан нэр томьёо, ойлголт нь бусад хуулийн нэр томьёо, ойлголттой зөрчилтэй байгаа тул сууц өмчлөгчдийн холбооны чиг үүргийн давхардлыг арилгах шаардлагатай байна. 2022 оны байдлаар улсын хэмжээнд нийтийн зориулалттай орон сууцны барилгуудын ашиглалт, засвар үйлчилгээг нийт 1638 сууц өмчлөгчдийн холбоо, 129 мэргэжлийн байгууллага

хариуцан ажиллаж байна. Цаашид орон сууцны барилгын дундын өмчлөлийн инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагад хариуцуулан орон сууцны ашиглалтын байгууллагуудын үйл ажиллагааны хүрээ, эрх, үүргийг шинээр тодорхойлон, сууц өмчлөгчдийн холбооны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаснаар орон сууцны барилгын ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангах чухал ач холбогдолтой.

2.4 Хөдөлмөр эрхлэлт

Ажиллах хүчний оролцоо дэлхийн дунджаас доогуур, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хангагдахгүй байна. Ажиллах хүчний оролцоо 2023 онд 57.6 хувь байгаа нь (өмнөх оноос 1.0 хувиар буурсан) дэлхийн дунджаас 3.2 хувиар доогуур (Дэлхийн дундаж 60.8 хувь, эрэгтэй 77.1 эмэгтэйчүүд 48.6) байна. Монгол улсад ажиллах хүчний оролцооны түвшин эрэгтэйчүүд 66.3 хувь, эмэгтэйчүүд 50.6 хувь, 15.7 хувийн зөрүүтэй байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо буурч буй шалтгааны 58 хувийг жирэмсэн, хүүхэд болон өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн, өндөр настан асарч байгаа буюу асрахуйн шалтгаануудаар тайлбарлагдаж, ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо нэмэгдсээр байна.

Сүүлийн арван жилийн байдлаар ажлын байрны эрэлт жилд дунджаар 1.2 хувиар өссөн бөгөөд жил бүр 11.2 мянган ажлын байр шинээр бий болсон. Нөгөө талаас, мөн хугацаанд хөдөлмөрийн нийлүүлэлт өссөн хандлагатай буюу жилийн дундаж өсөлт 1.2 хувь байсан. Хэдий эрэлт, нийлүүлэлт адил өссөн ч, нийцтэй байдлыг задлан үзвэл хөдөлмөрийн зах зээл дээрх ажилгүй иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Хүснэгт 4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт

Үзүүлэлт	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Нэг. Хөдөлмөрийн зах зээлийн нийлүүлэлт								
1.1 Ажиллах хүчний хэмжээ	1,206.6	1,243.9	1,275.7	1,357.4	1,358.6	1,273.9	1,250.6	1,225.3
1.2 Нийт нийлүүлэлт	1,206.6	1,243.9	1,275.7	1,357.4	1,358.6	1,273.9	1,250.6	1,225.3
Хоёр.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт								
2.1. Хөдөлмөр эрхлэлт	1,110.7	1,151.2	1,147.8	1,238.3	1,253.0	1,146.2	1,163.0	1,125.5
2.2 Нийт эрэлт	1,110.7	1,151.2	1,147.8	1,238.3	1,253.0	1,146.2	1,163.0	1,125.5
Гурав.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт								
3.1. Ажилгүй иргэд	95.9	92.7	127.8	119.1	105.6	127.7	87.6	99.7
3.2. Ажиллах хүчний илүүдэл	95.9	92.7	127.8	119.1	105.6	127.7	87.6	99.7

Эх сурвалж: Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн ажлын байрны эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох нь, 2021 он

Хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний илүүдэлтэй ч сул ажлын байрны захиалга байсаар байгаа нь ажиллах хүчний боловсрол, мэдлэг, ур чадвар, цалин болон бусад хүчин зүйлсээс хамаарсан нийлүүлэлтийн илүүдэл бий болсныг илтгэж байна. Эрэлт нийлүүлэлтийн нийцгүй байдлыг мэргэжилд тохирох ажил олдохгүй 12.9 хувь, мэргэжил, дадлага туршлага байхгүй 9.4 хувь, ажил олгогчийн зүгээс тавьсан шаардлагад нийцэхгүй 3.9 хувь зэрэг шалтгаан үүсгэж байна. Иймд мэргэжлийн болон дээд боловсролын төгсөгч зах зээлийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй, ирээдүйн хэтийн хөгжлийн чиг хандлагатай уялдахгүй байгааг харуулж байна.


Халамжийн үйлчилгээг оновчтой болгох шаардлагатай. Монгол улсын халамжийн бодлогын дийлэнх (99%) нь бэлэн мөнгө тараах хөтөлбөрүүд бөгөөд өрх иргэдийг чадавхжуулах, сургах, зөвлөх, дэмжих нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг хүргэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаагаас шалтгаалан нийгмийн халамжийн нийт санхүүжилтийн 1 орчим хувийг энэ арга хэмжээнд зарцуулж байна. Тэдгээр бэлэн мөнгөний хөтөлбөр, арга хэмжээнүүд ядуурлыг бууруулахад чиглэгдэж буй боловч эдийн засгийн өсөлтийг дагаж ядуурлын хамрах хүрээ дорвитой буурахгүй байна.

Халамжийн зардлын 68.3 хувийг нийтлэг мөнгөн тусламж хэлбэрээр олгож 31.7 хувийг эмзэг буюу зорилтот бүлэгт зарцуулж байна.

Монгол Улсын нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн зорилтот бүлэгт чиглэсэн байдлыг 2018 оны тоон мэдээлэлд үндэслэн судалсан бөгөөд судалгаагаар хүнсний эрхийн бичгийн хөтөлбөр зорилтот бүлэгт хамгийн их чиглэсэн хөтөлбөр байна. Үүний 99 хувь нь хүн амын амьжиргааны түвшин хамгийн бага 20 хувьд хуваарилагдаж байна. Харин эсрэгээр Алдар цолтон ахмад настанд чиглэсэн хөтөлбөр хамгийн зорилтот бүлэгт чиглэгдээгүй хөтөлбөр бөгөөд нийт зардлын 65 хувь нь хүн амын амьжиргааны түвшин хамгийн өндөртэй 20 хувьд хуваарилагдаж байна.

Бусад хөтөлбөрүүдийн хувьд орлого багатай иргэдэд хуваарилагдаж буй зардлын хэмжээ нь харьцангуй өндөр орлоготой иргэдэд хуваарилагдаж буй зардлаас бага зэрэг өндөр боловч хангалттай хэмжээнд зорилтот бүлэгт чиглэгдэж чадаагүй байна.

Зураг 20. Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн зардлын хуваарилалт, халамж хүртэгчдийн амьжиргааны түвшний бүлгээр



Эх сурвалж: (Эрдэм Партнерс, 2019)

2.5 Нийгмийн баталгаа

Ядуурал нэмэгдэх эрсдэлтэй байна. Үндэсний статистикийн хорооноос 2 жил тутамд ядуурлын түвшнийг тооцдог. 2022 оны байдлаар ядуурлын түвшин 27.1 хувь байна. Ядуурлын шугамаас доогуур хэрэглээтэй 914.2 мянган хүн байгаа бөгөөд ядууралд өртөхөд ойрхон 346.4 мянган хүн ам байгаа нь ядуурал 10.3 хувиар нэмэгдэх эрсдэлтэй байна. Ядуурлын шугамыг 2022 оноос шинэчлэн 418,090 төгрөгөөр тогтоосон. 2010 онд 92,220 төгрөг (өрхийн сарын үндсэн хэрэгцээг хангах амьжиргааны хамгийн бага зардал) байсан.

Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна. Нийгмийн даатгалын тухай хууль 1994 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш 28 жилийн хугацаанд орсон 30 гаруй удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөх, тэтгэврийн нас нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг тэтгэвэр авагч, даатгуулагчийн эрх ашигт нийцсэн олон арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлсэн. Нийгмийн даатгалын сангийн орлого 2023 онд 4.2 их наяд болж 2022 оныхоос 900 тэрбумаар өсч (102.4 хувь), зарлага 4.0 их наяд болж 630 тэрбумаар нэмэгдсэн (97.0 хувь) байна. Улсын хэмжээнд 2023 онд 58.2 мянган аж ахуй нэгж, байгууллага шимтгэл төлж нийгмийн даатгалын сангаас давхардсан тоогоор 748.4 мянган иргэнд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгосон байна.

Өнөөдрийн байдлаар 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 5 байгаа бөгөөд 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж, дундаж наслалт нэмэгдсэнээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчдын тоо өсөж 2030 онд 7, цаашид 10 тэтгэвэр авагч болохоор байгаа юм.

2.6 Хөдөө аж ахуй

ХАА-н салбарын хөдөлмөрийн бүтээмж улсын дунджаас 40 хувиар доогуур, шинэ технологийн нэвтрэлт муу байна. Хөдөө аж ахуйн салбарт төрийн оролцоо өндөр байна. Түүхий эд бэлтгэн нийлүүлэгч буюу малчин, тариаланчдад арьс шир, улаан буудай, нөөцийн мах, сүү, ноос, ноолуур гэх мэт гарцад нь суурилсан дэмжлэг, татаас олгож байна. Энэ нь салбарын зах зээлийн тогтвортой хөгжилд гажуудал үүсгэж, хохирол учруулж байна.

Иймд тус салбарын Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн оролцоог хязгаарлаж, татаас, дэмжлэгийг боловсруулах шатны үйлдвэрлэл рүү чиглүүлэн, илүү оновчтой байдлаар шийдвэрлэх нь зүйтэй.

Газар тариалангийн салбарын хөгжил сул байна. Монгол улс нийтдээ 1,050.0 мянган га тариалангийн эргэлтийн талбайтай бөгөөд өнөөдрийн байдлаар нийт 22.3 мянган иргэн, аж ахуйн нэгж үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн тариалан эрхэлж байна. Манай улсад 2023 оны эцэст нийт 983.5 мянган өрх бүртгэгдсэний 17.7 мянган өрх буюу 1.8 хувь нь тариалан эрхэлсэн өрх байна. Газар тариалан эрхэлсэн өрхийн тоо өмнөх оноос 55 өрх буюу 0.3 хувиар буурсан байна.

Газар тариалан эрхэлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2023 онд 1,553 болж, өмнөх оноос 37 буюу 2.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 5. Газар тариалан эрхэлсэн өрх, аж ахуй нэгж байгууллага

	2015	2019	2022	2023	Өөрчлөлт 2023/22	
					Дүн	Хувь
Өрх	18,348	14,678	17,738	17,683	-55	-0.3
ААНБ	1,395	1,401	1,590	1,553	-37	-2.3

Газар тариалан нь хөдөө аж ахуйн салбарын 9 хувийг бүрдүүлж байгаа нь хангалтгүй тул нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Уур, амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар сул хөгжсөн, байгалийн эрсдэл, эмзэг байдлын төвшин өндөр байна. Монгол орны нөхцөлд таарсан уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд дасан зохицсон технологийн шийдлүүд, арга барилыг нэвтрүүлэхэд аж ахуй эрхлэгчид, иргэдийн мэдлэг, мэдээлэл тариаланчдын дунд дутмаг хэвээр байгаа тул сайжруулах шаардлагатай байна.

Хөдөө аж ахуйн таримлын үрийн чанар алдагдсан, үр үйлдвэрлэл, хуваарилалтын тогтолцоо бүрдээгүй байна. Үр үржүүлэг, сорт сорилтын салбарын бүтэц үйл ажиллагаа алдагдаж нутагшсан сортын үрийн хүрэлцээ хангамж муу байгаа шийдвэрлэх шаардлагатай.

Тариалангийн талбайн 61.6 % хүчтэй элэгдсэн, 47.7% нь маш бага үржил шимтэй болж эрсдэлийн байдалд хүрсэн байдлыг сайжруулж эргэлтийн талбайн хэмжээг сайжруулах хэрэгтэй.

Мал аж ахуйн салбар:

Монгол Улсад нийт малын тоо эрчимтэй өсөж, бэлчээр ашиглалтын зохистой харьцаа алдагдсан. Улсын хэмжээнд 2023 оны эцэст, мал тооллогын урьдчилсан дүнгээр 64.7 сая толгой мал тоологдсон. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 9.1 хувиар буурсан үзүүлэлт юм. Манай улсын мал сүргийн тоо нь бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх нөхцөл болохгүй байгаа тул малыг эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлагатай байна.

Үйлдвэрийн аргаар боловсруулсан Сүү, сүүн бүтээгдэхүүн хангамж хангалтгүй байна. Манай улс 2022 онд үйлдвэрийн аргаар 113.6 сая литр сүү боловсруулсан нь нийт хэрэгцээний 33 хувь болж байгаа бөгөөд дотоодын хэрэгцээг хангах сүү сүүн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

Бэлчээрийн талбайд хөнөөл учруулж буй мэрэгчидтэй тэмцэх шаардлага тулгарч байна. Манай орны 112.0 сая га бэлчээрийн талбайн 40.0 сая га-д үлийн цагаан оготно , 5.0 сая га-д царцаа тархсан. Сүүлийн жилүүдэд мэрэгчдийн тархалт баруунаасаа зүүн рүүгээ чиглэсэн, жилд 3.0-3.5 сая га бэлчээрт үлийн цагаан оготнотой, 40.0 мянган га бэлчээрт царцаатай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. 2023 оноос улсын төсөвт 1.6 тэрбум төгрөгийг батлуулан энэ оны хаврын технологит ажлын хүрээнд 8 аймгийн 46 сумын 120.0 гаруй мянган га бэлчээрийн ургамлыг мэрэгч амьтадын хөнөөлөөс хамгаалах арга хэмжээг микробиологийн аргаар хэрэгжүүлсэн. Ингэснээр бэлчээрийн ургамлыг ургаж эхлэх үед мэрэгч амьтдын хөнөөлд өртөхөөс сэргийлж, цаашлаад бэлчээрийн тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн.

Уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх шаардлагатай. Цаашид уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, хөгжүүлэх, тооноос чанарт шилжүүлэх, мэргэжлийн ажил үйлчилгээг төлөвшүүлэх, бэлчээрийн ашиглалт хамгаалалтын менежментийг сайжруулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарах. Мал аж ахуйн салбараас жилд дунджаар мах 500.0-600.0 мянган тн, арьс, шир 15.0-20.0 сая ширхэг, ноос 33.0-35.0 мянган тн, ноолуур 10.1 мянган тн, сүү 750.0-850.0 сая литр, өндөг 225.0-250.0 сая ширхгийг үйлдвэрлэн 2022 оны байдлаар ДНБ-ын 12.6 хувийг, экспортын 5.6 хувийг нийлүүлэв.

Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар эрчимжсэн аж ахуй эрхлэгч, тухайлбал махны үхрийн 715, сүүний үхрийн 1912, гахайны 728, тахианы мах, өндөгний 864, зөгийний 555, нийт 4785 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Эрчимжсэн мах, сүүний үхрийн аж ахуйг төв суурин газар болон газар тариалангийн бүс нутгийг түшиглэн хөгжүүлэх зорилгоор зээлийн болон зээлийн

хүүгийн хөнгөлөлт үзүүлэх, Цэвэр үүлдрийн мах, сүүний үхэр болон, гахай, тахианы үржлийн аж ахуй байгуулах шаардлагатай.

Хөнгөн үйлдвэрийн салбар:

Хөнгөн үйлдвэрийн салбарын экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай. Хөнгөн үйлдвэрлэлийн салбар 2023 онд нийтдээ 484.8 сая ам долларын экспорт, 1,077.5 сая ам долларын импорт хийсэн байна.

Хөнгөн үйлдвэрлэлийн салбарын гол экспортыг ноос, ноолуур, арьс ширэн түүхий эд, бүтээгдэхүүн эзэлж байгаа бөгөөд голчлог хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг экспортолж эргүүлээд боловсруулсан бүтээгдэхүүнийг өндөр үнэтэйгээр импортолж авч байна. Тиймээс хөнгөн үйлдвэрийн салбарыг төрөлжүүлэх, боловсруулах түвшнийг хөгжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 6. Хөнгөн үйлдвэрийн салбарын экспорт, импорт /сая ам.до/

Барааны нэр	Экспорт						Импорт					
	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Нэхмэл, нэхмэлийн бүтээгдэхүүн	409.8	434.6	279.5	370.7	489.7	451.2	90.2	85.0	85.8	103.7	133.8	150.7
Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	17.0	14.1	7.4	6.4	5.2	4.7	8.3	7.1	5.0	6.4	9.3	9.5
Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	2.3	2.5	1.8	2.2	2.1	3.2	19.9	19.8	17.8	24.6	35.1	36.2
Мод, модон эдлэл	0.3	0.6	0.3	0.1	0.3	0.3	34.0	43.5	43.4	67.3	81.7	79.5
Цаас болон картон, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	0.04	0.05	0.04	0.03	0.3	0.1	61.6	56.4	58.1	64.3	98.1	78.4
Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс	1.6	1.3	1.6	1.2	10.2	21.8	226.8	260.3	226.8	260.2	345.2	359.6
Нийт	431.04	453.15	290.64	380.63	507.8	484.8	440.8	472.1	436.9	526.5	703.2	1,077.5

Хөнгөн үйлдвэрийн салбарт дараах ажлууд зайлшгүй шаардлагатай байна. Үүнд:

- Үйлдвэрлэл, технологийн парк, цогцолбор үйлдвэрүүдийг /Дархан, Ховд/ байгуулж, салбарт дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх;
- Арьс ширний гүн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлэх;
- Ноос, ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, ээрэх үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх;
- “Монголын Хаан Ширхэгт” чанарын гэрчлэх тэмдэгт бүхий брэнд бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээлд таниулах;
- Угаасан ноолуурын экспортыг бууруулж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх хүрээнд тарифын болон тарифын бус зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Малын гаралтай түүхий эд бэлтгэлийг биржийн системээр дамжуулах тогтолцоог бүрдүүлэх;
- Бэлэн хувцасны дотоод зах зээлийн 15 хувийг хангаж, оёмол бүтээгдэхүүн хувцас үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Нийслэл, Хөвсгөл, Дархан-Уул аймагт мод боловсруулах, барилгын модон хийцийн цогцолбор үйлдвэрийг кластерийн зарчмаар хөгжүүлэх;

- Дахин боловсруулах үйлдвэрлэлийн салбарын боловсруулалтыг түвшнийг 2 дахин нэмэгдүүлэх.

Хүнсний үйлдвэрийн салбар:

Олон улсын худалдааны хорио цээртэй малын 4 гоц халдварт өвчин Монгол Улсад бүртгэгдсэн байна. Малын вакцинд хамрагдалтын хувь нь 2022 оны байдлаар шүлхий өвчний 20.7, үхрийн арьс товруутах өвчний 22.8, бог малын мялзан өвчний 5.1, хонины цэцэг өвчний 4.1 хувь байна. Тиймээс хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хадгалахын зэрэгцээ эрүүл аюулгүй хүнсээр иргэдийн хэрэгцээг хангах, хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

Хүнсний боловсруулах үйлдвэрийн сав баглаа боодолд аюулгүй байдлыг хангах утвар нөхцөлийг бий болгоход чиглэсэн эрх зүйн орчин сайжруулах, тухайн салбарт мөрдөх үйлдвэрлэлийн зохистой дадлын зааврыг боловсруулан олон улсын зөвлөхөөр хянуулж, гаргасан саналыг тусган ажиллах арга хэмжээг үргэлжлүүлэх шаардлагатай. Монгол Улс 2023 оны гаалийн экспортын гүйцэтгэлээр 80.4 мян.тн (түүхий ястай маханд шилжүүлэн тооцвол 117.0 мян.тн) мах, махан бүтээгдэхүүнийг 322.8 сая.ам.доллараар экспортолсон нь урьд өмнө хүрч байгаагүй өндөр түвшин бөгөөд 2022 онтой харьцуулахад 5 дахин өссөн боловч цаашид энэ түвшнийг нэмэгдүүлэх мах, махан бүтээгдэхүүн борлуулагч аж ахуй нэгж байгууллагыг дэмжин ажиллах шаардлагатай байна.

ГУРАВ. НОГООН ХӨГЖИЛ

3.1 Уур амьсгалын өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл нэмэгдэж байна. Монгол Улсын хүлэмжийн хийн ялгарууллын хэмжээ бага боловч, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмтгий улс гэж тооцогддог. Парисын хэлэлцээр 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн ба тус хэлэлцээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд Монгол Улс өмнө нь 2015 онд тодорхойлсон хүлэмжийн хийн ялгаралтыг 2030 он гэхэд 14 хувиар бууруулах зорилтоо ахиулан 22.7 хувь болгон тодорхойлж, Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт” -ыг батлуулан НҮБҮӨСК-ын Нарийн бичгийн дарга нарын газарт 2020 оны 10 дугаар сард хүргүүлсэн. Олон улсын төвшинд үүрэг, амлалт өгөхөөс гадна хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг үндэсний төвшинд бодитоор авч хэрэгжүүлэх замаар Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангуулах нь нэн чухал асуудал болж байна.

3.2 Эрчим хүчний шилжилт

Эрчим хүчний шилжилт удаашралтай байна. Улс орнууд хөгжлийн загвараа өөрчилж, ногоон, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэхэд өөрсдийн загвараа тодорхойлж энэ талын санхүүжилтийг нэмэгдүүлж байна. Манай улс сэргээгдэх эрчим хүчний нөөцөөр дэлхийд дээгүүр ордог бөгөөд улсын хэмжээнд арилжааны үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн 155 МВт-ын салхин цахилгаан станц, 90 МВт-ын нарны эрчим хүчний эх үүсвэрүүд ажиллаж байна. Салхины станцуудын системийн түгээлтэд 7.5 хувь, төлбөр тооцоонд 17.3 хувь, нарны эх үүсвэрүүд системийн түгээлтэд 1.4 хувь, төлбөр тооцоонд 6.8 хувь ба нийт дүнгээр нар, салхины эх үүсвэрүүд үйлдвэрлэлийн 9.2 хувь, төлбөр тооцооны 24.2

хувийг эзэлж байна. Эрчим хүчний нэгдсэн сүлжээний горимын зохицуулалтад оролцох боломжтой усан цахилгаан станц БНХАУ-д суурилагдсан хүчин чадлын 19.2 хувь, ОХУ-д 20.2 хувийг эзэлж байгаа бол манай улсын хувьд ердөө 1.7 хувийг эзэлж байна.

3.3 Байгаль орчин

Байгаль орчны гүйцэтгэлийн индексээр байр ухарч байна. Байгаль орчны гүйцэтгэлийн индексээр Монгол Улс 2016 онд 107 дугаарт эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд 144 дугаарт эрэмбэлэгдсэнээр сүүлийн 8 жилийн хугацаанд 37 байраар ухарсан байна. Ийнхүү ухрахад дараах дэд үзүүлэлтүүд доогуур үнэлэгдсэн нь нөлөөлжээ. Монгол Улс усны нөөцөөрөө дэлхийн 180 орноос 73-т эрэмбэлэгддэг боловч усыг хуримтлуулах, нөөцлөн ашиглагддаггүйгээс усны нөөц хамгийн бага 20 орны тоонд багтдаг. 2023 оны байдлаар манай орны 264 гол мөрөн, 704 булаг шанд, 286 нуур тойром, 12 рашаан ширгэсэн байна.

Монгол Улсын ойн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах бодлого шаардлагатай байна. /тэрбум мод/

Монгол орны ойн нийт нөөц 1,246,517,781 шоо метр бөгөөд үүний 79.29%-ийг шинэс, 8.92%-ийг хуш, 5.97%-ийг хус, 4.95%-ийг нарс, 0.23%-ийг гацуур, 0.01%-ийг жодоо, 0.17%-ийг улиас, 0.05%-ийг улиангар, 0.006%-ийг хайлаас, 0.25%-ийг бургас, 0.14%-ийг заг, 0.005%-ийг тоорой тус тус эзэлж байна. Шилмүүст мод зонхилсон ойн дундаж нас 131 жил, 1 га-ийн нөөц 142.9 м³, өсөлт 1.09 м³, навчит мод зонхилсон ойн дундаж нас 44 жил, 1 га-ийн нөөц 44.4 м³, өсөлт 0.98 м³, жилийн бүх дундаж өсөлт 10,212.5 сая м³ байна. Улсын хэмжээнд 2023 байдлаар 41 сум дундын ойн анги, 5 сумын ойн анги, аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дэргэд 7 ойн алба тус тус ажиллаж, орон нутагт ойн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах бодлогыг хэрэгжүүлж байна. 2022 оны байдлаар 1222 ойн нөхөрлөл 3,753.4 мян.га талбайг эзэмшиж байна. Ойн мэргэжлийн 94 аж ахуйн нэгж 138.9 мян.га ойн санг гэрээгээр эзэмшин хамгаалж байна.

Цаашлаад Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хоёр жилийн хугацаанд 41.5 сая мод тарьж ургуулсан. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мод үржүүлгийн 452 газарт 39 зүйлийн мод сөөгийн 12 тонн үр, 63 сая ширхэг тарьц суулгацын нөөц бүрдүүлсэн байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн талбайг нэмэгдүүлж, байгаль хамгааллыг эрчимжүүлэх шаардлагатай байна. Өнөөдрийн байдлаар, Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 21.0 хувь буюу 32.8 сая га талбайг улсын тусгай хамгаалалтад хамруулж, нэгдсэн сүлжээг бүрдүүлээд байна. Нийт нутаг дэвсгэрийн 15 орчим хувийг буюу 24.3 сая гаруй га талбайг орон нутгийн тусгай хамгаалалтад тус тус хамруулсан. Улсын тусгай хамгаалалттай нутгийг хуулиар тогтоосон 4 ангиллаар авч үзвэл 13.8 сая га талбай бүхий 22 дархан цаазат газар 13.8 сая га талбай, 13.5 сая га талбай бүхий 37 байгалийн цогцолборт газар, 5.3 сая га талбай бүхий 47 байгалийн нөөц газар, 106.557 га талбай бүхий 14 дурсгалт газрууд тус тус эзэлж байна.

Улсын тусгай хамгаалалттай газар нутагт цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрдэх эхийн 7.2 сая га талбай буюу 50 хувь, ойн сангийн 40 хувь нь хамрагдаж хамгаалагдсан.

3.4 Усны нөөц

Усны нөөцийн хамгаалал, зохистой ашиглалт сул байна. Манай орон хязгаарлагдмал усны нөөцтэй орны тоонд ордог. Нийт 564'800 сая шоо-метр нөөцтэйгөөс 10'500 сая шоо-метрийг ашиглах боломжит нөөц гэж тооцдог. Гэвч

энэхүү усны нөөцийн дийлэнх буюу 80 орчим хувь нь нутаг дэвсгэрийн 30%-д буюу хангайн бүсэд, томоохон голуудын хөндийд бүрэлдэн бий болдог.

Манай улс 2022 онд нийт 606.2 сая м.куб ус олборлож ашигласан байна. Үүнээс 55.9 хувийг хөдөө аж ахуй, 15.3 хувийг уул уурхай, 14.2 хувийг хүн амын унд ахуй, 7.6 хувийг эрчим хүч, 7 хувийг бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт тус тус ашиглажээ. Харин 2023 онд нийт 645.1 сая м.куб ус олборлож ашигласан. Үүнээс 41.20 хувийг хөдөө аж ахуй, 32.31 уул уурхай, 13.61 хувийг хүн амын унд ахуй, 7.22 хувийг эрчим хүч, 5.66 хувийг бусад үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт тус тус ашиглажээ. Энэ нь ус ашиглалт өмнөх оноос 6.4 хувиар нэмэгдсэн байна. Хүн амын өсөлт, хотжилт, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн хөгжлийн хурдац, төлөвлөлтийг харгалзан гол ус хэрэглэгчдийн хэтийн төлөвийг тоймлон тооцож үзэхэд 2030 онд ус хэрэглээ 3-4 дахин нэмэгдэхээр төлөвтэй байна. 2023 оны усны тооллогын дүнгээр 264 гол горхи, 704 булаг шанд, 286 нуур тойром ширгэсэн байна. Цаашид усны температур нэмэгдэж, ууршилт ихсэж, урсац буурах хандлагатай байна.

3.5 Агаарын бохирдол

Агаарын чанар бага байна. 2023 оны 12 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь агаар бохирдуулах бодисын дундаж агууламжийг өмнөх оны мөн үе буюу 2022 оны 12 дугаар сарын дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 5 мкг/м³-ээр буюу 5%-р, PM10 тоосонцор 16 мкг/м³-ээр буюу 12%-р, азотын давхар исэл (NO₂) нь 2 мкг/м³-ээр буюу 3%-р, хүхэрлэг хий (SO₂) нь 21 мкг/м³-ээр буюу 14%-р тус тус бага байна.


Агаар бохирдуулах бодисын 2023 оны жилийн дундаж агууламжийг 2022 оны жилийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор ижил түвшинд, хүхэрлэг хий 7 мкг/м³-ээр буюу 11%-аар, PM10 тоосонцор 6 мкг/м³-ээр буюу 7 %-аар, азотын давхар исэл 1 мкг/м³-ээр буюу 2 %-аар тус тус бага байна.

Агаар бохирдуулагч эх үүсвэр: Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогоос харахад 2021 онд нийслэлийн 6 дүүрэгт гэр хорооллын айл өрхийн 152,254 зуух тоологдож байсан бол 2022 онд 150,338 зуух тоологдож 1.3%-р буурсан байна.

2022 оны байдлаар нийт 1,134,794.0 авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас Улаанбаатар хотод 56.8% нь буюу 644,632.0 хөдөлгөөнт эх үүсвэр тоологдсон. Энэ нь 2022 оноос 8%-р нэмэгдсэн байна.

2022 оны нийт Усан халаалтын 15-100кВт хүчин чадалтай зуух -3,751 жилд 44,872 тн сайжруулсан түлш, 4,913 тн нүүрс, 100 кВт-аас дээш болон дулааны, цахилгаан станцын 394 зуух 6,260.095 тн нүүрс, 49,566.0 тн мидлинг хэрэглэж байна.

Зураг 21. Агаарын чанарын индекс



ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ

4.1 Авлига

Авлигын индекс өндөр хэвээр байна. Дэлхийн банкнаас гаргадаг Авлигын үзүүлэлтээр Монгол Улс сүүлийн 5 жил дараалан буурсан. (2018 онд 39.5%, 2019 онд 37.1%, 2020 онд 34.3%, 2021 онд 33.3%, 2022 онд 33.0%-ийн үзүүлэлттэй байна.) Мөн “Транспэренси Интернешнл” олон улсын байгууллагаас гаргадаг “Авлигын төсөөллийн индекс”-ийн үзүүлэлтээр Монгол Улс 2019 онд 35 оноогоор нийт 180 орноос 106 дугаар байрт эрэмбэлэгдсэн бол 2022 онд 33 оноогоор 116 дугаар байрт орж ухарсан. Энэхүү үр дүнгээс харахад авлигатай тэмцэх, бууруулахад чиглэсэн дорвитой арга хэмжээг авах шаардлагатайг илтгэж байна.

Авлига, ашиг сонирхлоос сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна. Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаа нь хууль өөрчлөх, хяналт шалгалт тавих, хариуцлага хүлээлгэх төдийхнөөр хязгаарлагдахгүй. Нэгэнтээ бий болсон нөхцөл байдалтай үндэсний хэмжээнд тэмцэх шаардлагатай болжээ. Иймд авлига, ашиг сонирхлоос сэргийлэх үндэсний тогтолцоо бүрдүүлэх, нийгмийн бүхий л хүрээнд авлигыг үл тэвчих хандлага тогтооход чиглэгдсэн шинэ үзэл баримтлал, арга зам санал болгох шаардлагатай байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах. Авлигын эсрэг олон хэрэгслийг ашиглахгүй байна. Эдгээр хэрэгслийг ашиглахын тулд төрийн байгууллагууд, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, иргэдийн хөдөлгөөнийг чадавхжуулах бүх хүчин чармайлтаа дайчлах хэрэгтэй. Энэ ажил нь улс төр, эдийн засгийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг сэргээх, бизнес эрхлэгчдийн итгэлийг бэхжүүлэх гол түлхүүр болно. Засгийн газраас лиценз, зөвшөөрөл олгох журмын ил тод, тодорхой байдлыг сайжруулах. Үүнийг ялангуяа мэргэжлийн хяналт, гааль зэрэг тэргүүлэх ач холбогдолтой, өндөр эрсдэлтэй салбаруудад хэрэгжүүлэх шаардлагатай байна. Засгийн газар, бизнесийн холбоод лиценз, зөвшөөрөл олгохтой холбоотой хууль тогтоомж, бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх ёстой. Салбарын болон бизнесийн холбоод нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, нийгэм, олон нийтийн оролцоо, мөн байгууллагын хариуцлага ба ёс зүйн чиглэлээр бизнесийн үйл ажиллагааг сайжруулахад санал санаачилгатай, манлайлагч байх ёстой.

4.2 Төрийн бүтээмж

Төрийн бүтээмж сул байна. Төрийн байгууллагуудын үр ашиггүй том бүтэц, чиг үүргийн давхардал, хийдэл, албан хаагчдын бүтээмжгүй байдал, хүнд суртал, зөвшөөрөл, хяналт шалгалт, зохицуулалтын шинжтэй асуудлууд, дэд бүтцийн хангалтгүй байдал, төсвийн оновчгүй зохицуулалт зэрэг нь ард иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, бүтээмжийг бууруулдаг гол хүчин зүйл болж байна. Иймд төрийн шийдвэр гаргах тогтолцооны ил тод, нээлттэй байх нь чухал байна.

4.3 Засгийн газрын үр ашиг

Засгийн газрын үр ашгаар 2019 онд 41.4 хувь байсан бол 2022 онд 34.9 хувь болж буурсан. Төрийн бүтээмжийг сайжруулах хүрээнд цахим технологийн оновчтой шийдлийг нэвтрүүлж, төрийн үйлчилгээг амжилттай цахимжуулж байна. Цаашид иргэн төвтэй мэргэшсэн, чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх, олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг бий болгох, шат дамжлагыг бууруулах, олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Засгийн газрын үр ашигтай ажиллаж байгааг илтгэх хөгжлийн үзүүлэлтүүд сул байна. Дэлхийн банкнаас гаргасан Засгийн газрын үр нөлөө үзүүлэлтээр 209 орноос 126-т, Зохицуулалтын чанар үзүүлэлтээр 111-т жагсаж байна. 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцоог халснаас хойш зэрэгцээ сонгуулийн циклийг даган Засгийн газрын үйл ажиллагааны бодлого, чиглэл ойр ойрхон өөрчлөгдөж, хоорондын уялдаа холбоогүй, бодит байдалд нийцээгүй, залгамж чанаргүй, төсөвтэй уялдаагүй бодлогын баримт бичгүүд хэт олширсон.

4.4 Хуулийн засаглал

Хуулийн засаглалын үзүүлэлтээр 45.8%-р 213 орноос 116-д жагсаж байна. Хуулийн засаглалын үзүүлэлтээр тухайн улс орны нийгмийн дүрэм журмыг сахих итгэл үнэмшлийн хэр хэмжээ, гэрээний хэрэгжилт, өмчлөх эрх, цагдаа болон шүүхийн чанар, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлал зэргийг хэмждэг. Мөн Засаглал сул байх нь хөрөнгө оруулалтын орчин муудах, гадаадын хөрөнгө оруулалтыг түлхэх, төсвийн сахилга бат сул болох, улсын өр нэмэгдэх зэрэг улс орны макро эдийн засгийг тогтвортой байдлыг алдагдуулах суурь нөхцөл болдог учир засаглалын үзүүлэлтийг сайжруулахад шаардлагатай байна.

Засгийн газар өнгөрсөн хугацаанд 5Ш ажиллагааны хүрээнд шилэн ажиллагааг явуулсан. Үүнийг хүрээнд Shilen.gov.mn-д төрийн 123 байгууллагаас 550 багц мэдээлэл хүлээн авч, тэдгээрийг 39 төрөлд ангилан 970,355 мөр мэдээлэл болгон боловсруулж, 5 сая гаруй хандалт авч, иргэдийн мэдэх эрхийг хангаж, Монгол Улсад анх удаа нээлттэй мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн. Иймд нийгэм-эдийн засгийн, хөгжлийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгоход зөв засаглалын асуудал чухал үүрэгтэй. Зөв засаглалыг бий болгоход авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, шүүхийн шударга тогтолцоог бэхжүүлэх зэрэг арга хэмжээг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай.

4.5 Гадаад харилцаа

Нэгдмэл гадаад бодлого явуулж Монгол Үндэстний үнэлэмжийг нэмэгдүүлэх шаардлагатай. “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газраас 2016-2020 онд хэрэгжүүлсэн “Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр”-ийн үргэлжлэл бөгөөд 2021 онд 4 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ хэрэгжүүлж **82.95%**, 2022 онд 6 зорилтын хүрээнд 91 арга хэмжээ хэрэгжүүлж **90%**, 2023 онд 6 зорилтын хүрээнд 309 арга хэмжээ хэрэгжүүлж **93.3%** -тай дүгнэгдсэн.

ГХЯ-ны зүгээс гадаад сурталчилгааны үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж, нэгдсэн бодлогоор удирдан зохицуулсны дүнд “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлж буй гадаад сурталчилгааны арга хэмжээний агуулга болон хамрах цар хүрээ өргөсөж, тоо, чанар, хэрэгжилт жилээс жилд өсөж байна. Уг цогц арга хэмжээний хүрээнд **2021-2023 онд 413 арга хэмжээ** хэрэгжүүлсэн байна.

Гадаадад зорчиход виз мэдүүлэхэд хүндрэлтэй байна. Улс орнуудтай виз хөнгөвчлөх хэлэлцээр хийх, визгүй зорчих улсын тоог нэмэгдүүлэх, хүчирхэг гадаад паспорттой болох нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна. 2024 оны 2 дугаар сарын байдлаар нийт 67 улстай “Визийн шаардлагаас чөлөөлөх тухай хэлэлцээр”-ийг байгуулаад байна.

Бүх төрлийн паспорт эзэмшигчид иргэд нийт 28 улс, Дипломат, албан паспорт эзэмшигч иргэд нийт 59 улс, Дипломат паспорт эзэмшигч иргэд нийт 64 улс руу тус тус визгүй зорчиж байна.

Гуравдагч хөршийн бодлогыг эрчимжүүлэх шаардлагатай байна. “Гуравдагч хөршийн бодлого”-ын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн

хамтын ажиллагааг бэхжүүлж, олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэн, аюулгүй байдлаа хангах хэрэгцээ, шаардлага тулгарч байна. Хоёр их гүрний дунд зэрэгцэн орших нь аль нэг улсын нөлөөнд автах аюул занал тулгарч байна. Тиймээс гуравдагч ертөнцийн улс орнуудтай дипломат харилцаа тогтоох, хүрээгээ тэлэх бодлого баримтлах нь зүйтэй байна.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заасны дагуу манай улс Япон, БНЭУ, АНУ, БНТУ, ХБНГУ, БНСУ, Канад, Австралийн Холбооны Улс зэрэг өндөр хөгжилтэй улсуудтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Цаашид ДНБ болон хүний хөгжлийн индекс, эдийн засгийн салбарын индексээр өндөр үзүүлэлттэй улсуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж, туршлага солилцон хамтран ажиллах, олон улсын түвшинд мөр зэрэгцэн хөгжихөд гуравдагч хөршийн бодлого чухал байна.

Бүс нутгийн интеграцид нэгдэж, олон талт хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

4.6 Цахим засаглал

“И-Монгол” платформын талаар зохицуулж, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Уг хууль батлагдахаас өмнө 2020 оны 10 дугаар сарын 01-нд “И-Монгол” платформыг үүсгэж, 81 төрийн үйлчилгээг нэгтгэж байсан бол түүнээс хойших Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 2024 оны байдлаар тус системийн 4.0 хувилбарыг хөгжүүлж, үндсэн 6 сувгаар төр, хувийн хэвшлийн 1,173 төрийн үйлчилгээг 43 сая удаа үзүүлсэн байна. Одоогоор хэрэглэгчийн тоо 1.77 саяд хүрч, насанд хүрсэн хүн 77%-д хүрсэн амжилттай тоон үзүүлэлттэй байна. Зөвхөн 2023-2024 онд гэхэд “И-Монгол” системээр дамжуулан үзүүлсэн төрийн үйлчилгээнд иргэнээс төрийн байгууллагад ирэх, буцах унааны зардал, баримт бүрдүүлэх, цаасны зардал зэрэгт 442 тэрбум төгрөгийн хэмнэлт үүсгэсэн гэсэн зардлын тооцоолол гарсан байна.

Мэдээллийн аюулгүй байдлын түвшин хангалтгүй байна. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн бодлого, стратеги байхгүй бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангах мэдлэг ойлголт сул байна. Үүнийг дагаад хөрөнгө оруулалт дутмаг байгаагаас энэ салбарын хөгжихгүй байна. Мөн хөгжил сул учир хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйгээс аюулгүй байдлын түвшин хангалтгүй байна.

Төрийн цахим дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай. Аливаа цахим аюул занал, халдлага зөрчил, хорт кодыг урьдчилан илрүүлж хариу арга хэмжээ авах, тайван болон онцгой байдлын үед оролцогч талуудыг халдлага зөрчлийн талаарх тогтмол мэдээллээр хангах техник технологийн дэд бүтэц байгуулагдаагүй.

Эстони Улсын Цахим засгийн Академиас 2020 онд нийтэлсэн Үндэстний кибер аюулгүй байдлын индексийн тайланд дурдсан 160 орноос Монгол Улс 120 дугаар байрыг эзэлсэн. Энэ тоон үзүүлэлтүүдээс харахад Манай улс кибер аюулгүй байдлын тогтолцоо дутмаг, цахим орчинд үйлдэгдэж буй халдлага, зөрчилд хариу үзүүлэх, аюул заналаас урьдчилан сэргийлэх чадвар хангалтгүй бөгөөд цаашид нэн даруй хөгжүүлэх шаардлагатай.

Үндэсний хэмжээнд кибер халдлага, аюул заналаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах чадамж бүхий боловсон хүчний нөөц бүрдээгүй байна. 2023 онд IMD-ээс гаргадаг Цахим өрсөлдөх чадварын үнэлгээгээр нийт 64 улсаас 63 т үнэлэгдэж мөн 3 үндсэн үзүүлэлт байдгаас мэдлэг боловсролоор 56-р байр, техник технологийн дэвшил 61-р байр, ирээдүйд бэлэн байдлаар 62-р байрт байна гэж үнэлэгдсэн.

ТАВ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

5.1 Хотжилт

“Хот”-ын статусыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэхгүй байснаар засаглалын чиг үүргийн давхардал үүсэж, хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын хурдацтай шилжилт хөдөлгөөн явагдаж байна. Үүний нөлөөгөөр хотжилтын түвшин 1950 оноос хурдацтай өсөж, 2023 оны байдлаар 70% хувьд хүрч дэлхийн дунджаас 10 хувиар илүү гарснаар Европын суурин соёл иргэншилтэй Унгар, Итали зэрэг орноос илүү гараад байна. Хүн амын өсөлтийн хэтийн тооцооноос үзвэл 2021-2040 онд хүн амын өсөлтийн жилийн дундаж хувь тогтвортой түвшинд буюу 1.7-1.9 хувь байж, улсын нийт хүн ам 2040 онд 4.6 сая, нийслэлийн хүн ам 2.1 сая, харин хөдөөгийн хүн ам тогтвортой буюу 1.0 сая орчимд хүрч өсөхөөр байна. Харин хүн амын нас, хүйсийн бүтцийн өөрчлөлтийн хандлагыг авч үзвэл Монгол улсын хүн амын залуужсан бүтэцтэй буюу 2020-2040 аад он хүртэл аажмаар өөрчлөгдсөөр дараагийн 20 жилд хөгшрөлийн бүтэцтэй болохыг судлаачид тооцоолжээ.

Энэ үед нийгмийн халамж, тэтгэвэр авагчид эрс нэмэгдэж эхлэх, хот байгуулалтад ахмад настны хэрэгцээ шаардлагыг тусгаж төлөвлөх зэргээр анхаарч стратегийн бодлогыг боловсруулах шаардлагатай юм. Өнгөрсөн зуунд хөдөөгөөс хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн бүхий хотжилтын эрин үе байсан бол ирэх 20-30 жилд тогтвортой хот байгуулалт, мэдээллийн технологи, ухаалаг төлөвлөлт бүхий уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, сэргэн хөгжих чадавх бүхий тогтвортой хот байгуулалтыг хөгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байгааг харуулж байна.

Эдийн засгийн потенциалын хязгаарлагдмал цаг үед хамгийн оновчтой байршил, салбар, төсөл хөтөлбөрийг харилцан уялдаатай байдлаар, цогцоор төлөвлөх шаардлагатай байна. Өргөн уудам газар нутагтай, цөөн хүн амтай, дэд бүтцийн хөгжил сул, хөрөнгө оруулалтын хэмжээ хязгаарлагдмал цаг үед бид хамгийн оновчтой байршил, салбар, төсөл хөтөлбөрийг харилцан уялдаатай байдлаар, цогцоор нь эхний ээлжид хэрэгжүүлж байж хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ. Бүх салбар, аймаг, сумдад тэнцүү хуваах зарчмаар хөрөнгө оруулалтаа хуваарилах нь үр ашиггүй зардал болоод байна. Иймд хөгжлийн ирээдүйтэй хот, сууриныг тодорхойлж улсын төсвийн хөрөнгө оруулалтын хуваарилалт, төсөл, хөтөлбөрийг оновчлох нь эдийн засгийн хөгжлийг дэмжих хурдасгуур болоод байна.

Улаанбаатар хотод суурин газарт тулгамддаг асуудал хуримтлагдаж эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байна. Нийслэл Улаанбаатар хотын одоогийн зарим статистик мэдээллээс харвал Нийслэл нь Монгол улсын газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг хэдий ч нийт хүн амын 46 хувь, их дээд сургууль, коллежийн 96 хувь, иргэдийн хадгаламжийн 82 хувь, автомашины 68 хувь, бүртгэлтэй аж ахуйн нэгжийн 75 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 66 хувийг эзэлдэг гэх мэт үзүүлэлтээр улсын хэмжээнд тэргүүлж байна. Ийнхүү нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрчимтэй өсөж, эдийн засаг, нийгмийн үйл ажиллагаа идэвхжихийн хэрээр хот байгуулалт, төлөвлөлт, байгаль орчин, экологийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төлөвлөлтгүй суурьших, байгаль

орчин доройтох, агаар, хөрс бохирдох, хог хаягдал, дуу чимээ нэмэгдэх, гэмт хэрэг, зөрчил ихсэх, замын хөдөлгөөний түгжрэл үүсэх, хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамж, үйлчилгээний салбар доголдох зэргээр хот, суурин газарт тулгамддаг асуудал хуримтлагдаж нийслэл хотын эдийн засаг, нийгмийн харилцаанд хүндрэл учирч байна.

5.2 Захын бүс

Хил орчмын бүс нутаг нь төвөөс алслагдсан, дэд бүтэц муу хөгжсөн, худаг, бэлчээрийн усан хангамж, малчин өрхийн суурьшил багатай, хүн амын шилжин явах хөдөлгөөн их, нягтшил багатай байгаа нь хүн амын төрөл ойртолт зэрэг эрсдэлүүд үүсэх нэг нөхцөл болж байна. Олон улсын жишгээр авч үзвэл, манай улсын хүн амын амьдрах тохиромжтой орон зай, тааламжит орчныг өөрийн хөгжиж ирсэн онцлог, газар нутгийн нөөц, баялаг, байгаль, цаг уурын өвөрмөц нөхцөлтэй уялдуулан, цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан тодорхойлох, энэ үндсэн дээр нийгэм, эдийн засгийн ойр ирээдүйн хөгжил, соёлын түвшнийг илэрхийлэх, нийгмийн дэвшилд идэвхтэй нөлөөлөх бодит үр дагавар бүхий нутаг дэвсгэрийг зохион байгуулах, хүн амыг зохистой байдлаар нутагшуулах төслийг боловсруулж, төрийн бодлогын түвшинд авч үзэн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарсаар байна.

Тиймээс нийгэм, эдийн засгийн хөгжлийн орон зайн нэгдсэн төлөвлөлтийг оновчтой болгох, хөгжлийн ирээдүйтэй өсөлтийн төв хот, сууриныг тодорхойлж баталгаажуулах, үндэсний орон зайн өгөгдлийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх замаар нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг оновчтой болгох шаардлагатай байна.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

Дугаар

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 1 дүгээр хавсралтаар, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтарч ажиллахыг Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт үүрэг болгож, тус хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцоолж, санхүүгийн эх үүсвэрийн үнэлгээ болон өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийх;

2/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг, түүний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

3/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

4/Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасны дагуу үнэлгээ хийх;

5/Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ энэ тогтоолын 2 дугаар хавсралтын үр дүнгийн тухайн оны зорилтыг хангахад чиглүүлэх.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 2024 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын 3.1 дэх заалтын “Бүсийн хөгжлийн зорилго нь дэлхий дахинд монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, Орхоны хөндий, Хангайн нурууны байгалийн онцлогт тулгуурлан аялал жуулчлал, боловсруулах үйлдвэрлэлийг дагнан хөгжүүлсэн “Дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүс” болно.” гэснийг “Бүсийн хөгжлийн зорилго нь дэлхий дахинд монголын түүх, төрт ёс, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, дэлхийн нүүдэлчдийн соёлын голомт нутаг, соёлын бүтээлч үйлдвэрлэлд тулгуурласан “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс” болно.” гэж, мөн 3.2 дахь заалтын “Бүсийн хөгжлийн зорилго нь Төв Азийн орнууд болон Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээлтэй холбогдож, Дэлхийн өв Увс нуурын сав, Монгол Алтайн нуруу-Хангайн нурууны байгалийн унаган төрх, олон угсаатны түүх, соёлын өвд түшиглэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалаар төрөлжиж, мал аж ахуй, газар тариалангийн нөөцөд тулгуурлан эко үйлдвэрлэлийн хоршилт бүхий “Тогтвортой хөгжлийн бүс” болно.” гэснийг “Бүсийн хөгжлийн зорилго нь Төв Азийн орнууд болон Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээлтэй холбогдож, Дэлхийн өв Увс нуурын сав, Монгол Алтайн нуруу-Хангайн нурууны байгалийн унаган төрх, олон угсаатны түүх, соёлын өв, эрчим хүчний нөөцөд түшиглэн “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс” болно.” гэж, мөн 3.3 дахь заалтын “Бүсийн хөгжлийн зорилго нь Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан аялал жуулчлал, амралт сувилал, хүнд үйлдвэрлэлээр төрөлжсөн “Аялал жуулчлал, аж үйлдвэрлэлийн хөгжлийн бүс” болно.” гэснийг “Бүсийн хөгжлийн зорилго нь Оросын Холбооны Улс болон Европын орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрний сав газрын эко систем, байгаль, түүх, соёлын өвд тулгуурлан “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болно.” гэж, мөн 3.4 дэх заалтын “Бүсийн хөгжлийн зорилго нь олон улстай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээнд холбогдож, уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжиж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангасан “Эрүүл хүнс үйлдвэрлэгч, экспортлогч бүс” болно.” гэснийг “Бүсийн хөгжлийн зорилго нь олон улстай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээнд холбогдон хөдөө аж ахуй болон байгалийн нөөцөд тулгуурлан “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болно.” гэж, мөн 3.5 дахь заалтын “Бүсийн хөгжлийн зорилго нь Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хан Хэнтийн нуруу, Дорнод Монголын байгалийн экосистем, Дэлхийн өв Бурхан халдун, Эзэн Чингис хааны төрт ёс, түүх, соёлын өвд түшиглэсэн аялал жуулчлал, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан, уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжсөн “Олон улсын худалдаа, тээвэр, логистикийн таталцлын бүс” болно.” гэснийг “Бүсийн

хөгжлийн зорилго нь Зүүн Хойд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, Хан Хэнтийн нуруу, Дорнод Монголын байгалийн экосистем, Дэлхийн өв Бурхан халдун, Эзэн Чингис хааны төрт ёс, түүх, соёлын өвд түшиглэн “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болно.” гэж, мөн 3.6 дахь заалтын “Бүсийн хөгжлийн зорилго нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, өндөр технологи бүхий уул уурхай, хүнд үйлдвэрлэлээр дагнан төрөлжсөн говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэсэн аялал жуулчлал хөгжсөн “Үндэсний баялгийн санг бүрдүүлэгч бүс” болно.” гэснийг “Бүсийн хөгжлийн зорилго нь Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Өмнөд Азийн орнуудтай эдийн засгийн харилцааг өргөжүүлж, уул уурхай, говийн унаган байгаль, түүх, соёлын өв, палеонтологийн нөөцөд түшиглэн “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” болно” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	14
1.1. Улаанбаатар хот - “20 минутын хот” стандарт	14
1.1.1. Хот төлөвлөлт, засаглалын реформ	14
1.1.2. Эрчим хүчээр хангагдсан хот	14
1.1.3. Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт	15
1.1.4. Ногоон - ухаалаг хот	15
1.1.5. Олон төрөлт нийтийн тээвэр, авто зам	16
1.2. Бие даасан эдийн засаг бүхий дагуул хот	16
1.2.1. Дагуул хотуудын дэд бүтэц	16
1.2.2. Дагуул хотуудын хөгжил	16
1.3. Бүсийн төрөлжсөн хөгжил	17
1.3.1. Хангайн бүс - “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс”	17
1.3.2. Баруун бүс - “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс”	17
1.3.3. Хойд бүс - “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”	18
1.3.4. Говийн бүс - “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс”	18
1.3.5. Төвийн бүс - “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”	19
1.3.6. Зүүн бүс - “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс”	19
1.4. Орон нутгийн хөгжил	19
1.4.1. Шилжилт хөдөлгөөн	19
1.4.2. Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт	20
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	21
2.1. Чинээлэг монгол хүн	21
2.1.1. Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого	21
2.1.2. Хөдөлмөр эрхлэлт	23
2.1.3. Нийгмийн баталгаа	24

2.1.4.	Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг.....	25
2.2.	Эрдэм боловсролтой монгол хүн.....	25
2.2.1.	Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол	25
2.2.2.	Мэдлэг чадвартай мэргэжилтэн	26
2.2.3.	Багшлах хүний нөөц	28
2.2.4.	Цахимжсан боловсрол	28
2.3.	Эрүүл монгол хүн	28
2.3.1.	Нийгмийн эрүүл мэнд	28
2.3.2.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж	29
2.3.3.	Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмж	29
2.3.4.	Эрүүл мэндийн салбарын хүний нөөц	30
2.4.	Баялагтаа эзэн монгол хүн	30
2.4.1.	Үндэсний баялгийн сан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалт	30
2.4.2.	Барилга, барилгын материалын үйлдвэрлэл	31
2.4.3.	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц	31
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО		33
3.1.	Эдийн засгийн эрх чөлөө	33
3.1.1.	Макро эдийн засгийн тогтвортой байдал.....	33
3.1.2.	Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа.....	33
3.1.3.	Банк, санхүү, даатгалын салбарын реформ.....	33
3.2.	Бизнес, хөрөнгө оруулалтын орчин.....	34
3.2.1.	Татвар, нийгмийн даатгалын реформ.....	34
3.2.2.	Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин	34
3.3.	Эдийн засгийн төрөлжилт, либералчлал	35
3.3.1.	Уул уурхай.....	35
3.3.2.	Боомтын шинэчлэл, тээвэр логистик	36
3.3.3.	Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал.....	38
3.3.4.	Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр	40
3.3.5.	Дөрвөн улирлын аялал жуулчлал	41
3.3.6.	Соёлын бүтээлч үйлдвэрлэл	42
3.3.7.	Шинжлэх ухаан, технологи, инновац.....	43
3.4.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт	43

3.4.1. Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент	43
3.4.2. Уур амьсгалын өөрчлөлт	44
3.4.3. Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар	44
ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	46
4.1. Хүний эрх, эрх чөлөө	46
4.1.1. Хүний эрх.....	46
4.1.2. Хэвлэлийн эрх чөлөө.....	47
4.1.3. Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа	47
4.1.4. Ил тод байдал ба хяналт	48
4.1.5. Парламентын засаглал ба эрх мэдлийн хяналт, тэнцэл.....	48
4.1.6. Шүүх засаглал.....	48
4.2. Авлигагүй засаглал	48
4.2.1. Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа	48
4.2.2. Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал	50
4.2.3. Төрийн албаны реформ	50
4.2.4. Орон нутгийн засаглалын бие даасан байдал	51
4.3. Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл	51
4.3.1. “E-Mongolia”-блок чейн-Цахим засаглал	51
4.3.2. Сансар судлал, харилцаа холбоо, мэдээлэл технологи	52
4.3.3. Цахим орчин дахь хүний эрх, кибер аюулгүй байдал	52
4.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм.....	53
4.4.1. Үндэсний эв нэгдэл.....	53
4.4.2. Гадаад бодлого.....	54
4.4.3. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцоо.....	56
4.4.4. Гамшгийн үеийн бэлэн байдал, эрсдэлийн удирдлага.....	57
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	59

ӨМНӨТГӨЛ

Дэлхий дахиныг хамарсан цар тахлын нөлөө багасаж, улс орнуудын мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр инфляцын түвшин буурахад нөлөөлж, саарсан нь ажил эрхлэлт, өрхийн хэрэглээнд дэмжлэг болсноор дэлхийн эдийн засаг 2023 онд 3.3 хувиар өслөө. Дэлхийн эдийн засгийн өсөлтийг Олон улсын валютын сан 2024 онд 3.2 хувь, 2025 онд 3.3 хувь орчимд тогтвортой байхаар тооцож байна.¹ Инфляцын бууралт нь мөнгөний бодлогын төлөвийг сулруулах орон зайг бий болгож, эдийн засгийн идэвхжлийг дэмжихээр байна.

Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг цар тахлын дараа сэргэж, 2023 онд 5.1 хувиар өссөн бол 2024 онд 4.8 хувь болж саарах төлөвтэй байна. БНХАУ-ын эдийн засгийн удаашрал бүс нутгийн орнуудын эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Дэлхийн санхүүгийн зах зээл дэх тодорхой бус байдал нэмэгдэж, байгалийн гамшигт үзэгдлийн тоо нэмэгдэж байгаа нь бүс нутгийн эдийн засагт томоохон эрсдэлийг дагуулж байна. Геополитикийн тогтворгүй нөхцөл байдал хурцдах, голлох эдийн засгийн өсөлт удаашрах, инфляц төсөөллөөс удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах зэрэг эрсдэл нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулж болзошгүй байна.

Харин олон улсын худалдаа, аялал жуулчлал сэргэсэнтэй холбоотойгоор тээвэр, худалдаа эрчимжиж, инфляц тогтворжсоноор хувийн хэрэглээ нэмэгдэж байгаа нь бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж байна.

Монгол улсын хувьд уул уурхайн салбарын экспортын сэргэлт 2023 онд үргэлжилж, төсөв, төлбөрийн тэнцэл түүхэнд байгаагүй ашигтай гарсан нь эдийн засаг 7.4 хувиар өсөх нөхцөл болсон. 2024 оны эхний улирлын байдлаар эдийн засаг 7.8 хувиар өссөн ба энэ онд 5.6 хувиар өсөх төлөвтэй байна. Үүнд зудын улмаас 8.1 сая толгой мал хорогдсон, хөдөө аж ахуйн салбарт агшилт үүссэн зэрэг нь сөргөөр нөлөөлж байгаа ч уул уурхайн салбарын сэргэлт бодит өсөлтийг тэтгэх үндсэн хүчин зүйл болж байна.

2024 оны эхний 7 сард нүүрсний экспорт 47.5 сая тн-д хүрч, өмнөх оноос 34 хувиар өсөж, оны эцэст 78 сая тн-д хүрэх төлөвтэй байна. Мөн Оюутолгой төслийн гүний уурхайн олборлолт эхэлсэн зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр уул уурхайн салбар энэ онд 13.5 хувиар өсөх хүлээлттэй байна.

Уул уурхайн салбарын дам нөлөөгөөр ачаа тээвэр өсөлттэй байх бол жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр аялал жуулчлал, үйлчилгээний салбар өсөх хүлээлттэй байна.

2024 оны 2 дугаар улирлаас цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэн нь өрхийн хэрэглээг дэмжиж, дотоод эрэлтийг урамшуулснаар худалдаа, үйлчилгээний борлуулалт нэмэгдэн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

¹ ОУВС-ийн 2024 оны 7 дугаар сарын тооцоолол

Импортын инфляцын нийт инфляцад үзүүлэх нөлөө 2023 оноос алгуур буурч тогтворжсоноор инфляцын түвшин саарч, 2024 оны 6 дугаар сард 5.1 хувь буюу мөнгөний бодлогын зорилтот түвшинд хүрээд байна.

Хөдөлмөрийн зах зээлд ажиллагсдын тоо 37.8 мянгаар нэмэгдэж, 1.3 саяд хүрсэн ба ажиллах хүчний оролцооны түвшин 2024 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 0.8 нэгж хувиар өсөж 59.4 хувь, ажилгүйдлийн түвшин 5.2 хувь байна.

Олон улсын байгууллагууд манай улсын эдийн засгийг дунд хугацаанд 6-8 хувиар өсөх төлөвтэй гэж үзэж байгаа ч дэлхийн болон бүсийн эдийн засагт үүсээд буй тодорхой бус байдлаас шалтгаалсан уул уурхайн голлох бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл, зудаас үүдэн хөдөө аж ахуйн салбарт тулгарах сорилт, мөн эдийн засгийн хурдтай өсөлтөөс үүдэн инфляцын түвшин өндөр хадгалагдах эрсдэл байгааг анхааруулж байна.

Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарах, түүхий эдийн үнийн тогтворгүй байдал үүсэх нь манай улсад орох хөрөнгийн урсгалыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Мөн хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй байна.

Боомтуудын ачаалал нэмэгдэж, тээврийн зардал, импортын барааны үнэ өсөж байгаа нь инфляц өсөхөд шууд нөлөөлж, үйлдвэрлэлийн салбарын түүхий эд, бараа бүтээгдэхүүний хангамжийг тасалдуулахад хүргэж байна.

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд газар олголт, хот байгуулалтын төлөвлөлтгүй байдлаас үүдсэн хүн амын төвлөрөл, орчны бохирдол, авто замын түгжрэл, дэд бүтцийн хүртээмжгүй байдал, эрх мэдлийн төвлөрөл, гамшгийн эрсдэл зэрэг асуудал нь хүн амын эрүүл мэнд, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, улмаар өрхийн бодит орлогыг бууруулах, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт, ажилгүйдлийн түвшин, тэгш бус байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын бодлогын оновчгүй, тогтворгүй байдал, үнийн зохицуулалтаас шалтгаалсан системийн хэмжээнд их хэмжээний өр төлбөр бий болж, хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал байдлаас тоног төхөөрөмж, техник хэрэгслийн шинэчлэл, засвар, үйлчилгээ хийгдээгүйгээс доголдох, гэмтэх, эвдрэх асуудал сүүлийн жилүүдэд тасралтгүй гарч байна.

Төр аж ахуйн шинжтэй үйл ажиллагааг хувийн хэвшилтэй зэрэгцэн төрийн өмчит компани, үйлдвэрийн газар байгуулах замаар эрхэлж байгаа нь үр ашиггүй ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө үнэгүйдэх, төрд үүсэх зардлыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна.

Улс төрийн тогтворгүй байдал, авлига, хээл хахуультай холбоотой засаглалын сорилт нь урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад болж байна.

Дэлхий дахиныг хамарсан цар тахлын дараах хямрал, геополитикийн тогтворгүй байдлын үед манай улс эдийн засгийн өсөлтөө тогтвортой хадгалах, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, улс төрийн тогтвортой байдлыг хангаж, үндэсний зөвшилцлийн хэмжээнд томоохон төслүүдээ урагшлуулах зайлшгүй шаардлагатай тулгарч байна.

Иймд энэ хүнд сорилтын цаг үеийг даван туулахад өмнөх Засгийн газраас авч хэрэгжүүлсэн эдийн засгийг тогтворжуулах, төрийн хэмнэлтийг бий болгох, төсвийн сахилга батыг дээшлүүлэх, авлигатай тэмцэх, далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах зэрэг арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж,

Улсын эрх ашиг нэгдүгээрт, улс төрийн намын эрх ашиг хоёрдугаарт, эцэст нь хувийн эрх ашиг байх зарчмыг үнэт зүйлээ болгон,

“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг цаг алдалгүй, хурдтай шийдвэрлэхийг зорин,

Үндэсний эв нэгдэл, үндэсний эрх ашгийг эрхэмлэж, эрх зүйт төрийн үндсэн зарчмуудыг удирдлага болгон,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу сонгуулийн холимог тогтолцоогоор бүрдсэн 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнг хүндэтгэж, парламентад ард түмний дэмжлэг авсан улс төрийн намуудад өгсөн иргэдийн саналыг гээхгүй байх суурь зарчимд үндэслэн,

Олонхыг бүрдүүлсэн Монгол Ардын намаас Засгийн газрын бүрэлдэхүүнд Ардчилсан нам, ХҮН намыг урьж ажиллуулах улс төрийн манлайллыг хэрэгжүүлж, хамтарсан Засгийн газрыг байгуулсан билээ.

Хамтарсан Засгийн газар хөгжлийн тулгамдсан асуудал, тулгарч буй сорилтуудыг илүү хурдан, үр дүнтэйгээр шийдвэрлэх, бүрэн эрхийнхээ хугацаанд бүтээлчээр, тогтвортой хамтран ажиллах зорилгоор ХБНГУ, Шинэ Зеланд, Австрали зэрэг улсын туршлагыг судалж, “ХҮРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” хамтарсан Засгийн газрын гэрээг байгуулсан.

Дээрх гэрээг удирдлага болгон 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд дэвшүүлсэн Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрт суурилсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулаа.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан нийгмийн бодлогын шинэчлэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, авлигагүй төр, шударга ёсыг бэхжүүлэх цахим засаглал, эхлүүлсэн томоохон төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилтууд, Ардчилсан намын мөрийн

хөтөлбөрт туссан хүний хөгжил, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, технологи суурьтай мэдлэгийн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн эрх чөлөөг баталгаажуулах, шударга төрийн зорилтууд, ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан эрчим хүчний болон боловсролын салбарын реформ, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болгон тусгалаа.

Түүнчлэн, уг хөтөлбөрийн бодлогын зорилго, зорилтыг тодорхой, бодитой, хэмжигдэхүйц, хүрэхүйц, цаг хугацаатай байх /SMART/ шаардлагад нийцүүлэн, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг олон улсад хэрэглэгддэг индексүүдээр хэмжиж үнэлэхээр боловсрууллаа.

Энэ удаагийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр шинэ 30 жилийн эхлэлийг зөв тавих нийгэм, эдийн засгийн хөгжлийн суурь реформын эхлэл цэг юм.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийг тодорхойлж, тэдгээрийн хүрээнд тус бүр 4 зорилго, нийт 593 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгалаа. Тухайлбал,

Нэг.Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд:

Нийслэлийн их, бага тойруу буюу 770 га газарт төвлөрсөн төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу “Go Mongolia” ган татлагат гүүрийн төсөл, Хөшигийн хөндийн туннелын төслийг хэрэгжүүлнэ.

Хөшигийн хөндийд төр, захиргааны нэгдсэн байрыг барьж ашиглалтад оруулна.

Хөшигийн хөндийд шилжин суурьших төрийн албан хаагчдыг орон сууцжуулах төсөл хэрэгжүүлнэ.

Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна.

Хүнд ээлтэй, эмнэлэг, сургууль, цэцэрлэг, эрүүл аюулгүй ногоон байгууламж, үзвэр үйлчилгээ, соёл, спортын үйлчилгээг 20 минут дотор авах хүний төлөө шинэ стандарт бүхий “амьд” хот төлөвлөлтийг цогцоор нь дахин хийж, “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-г боловсруулж, батлуулна.

Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг үргэлжлүүлэн чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.

Ипотекийн зээлийн санхүүжилтийн 50-аас багагүй хувийг дэд төв, дагуул хот, гэр хорооллын өрхөд олгоно.

Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км “Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1”, Ард Аюушийн өргөн чөлөө-Их тойруу-Намъянжүгийн гудамж-Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урт тусгай замын автобус “BRT Шугам-1”, Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт

“Дүүжин тээвэр шугам-1” бүхий олон төрөлт их багтаамжийн нийтийн тээврийн системүүдийн уялдаа холбоог хангаж, үе шаттай барьж байгуулна.

Олон улсын чанартай 88 км “Шинэ тойрог зам”, Туулын хурдны замыг барьж, ачаа тээврийн хөдөлгөөнийг хотын гадуур тойруулна.

Бид хамтдаа улс орноо бүсчлэн хөгжүүлж, Хархорум, Шинэ Зуунмод зэрэг шинэ хотууд, аймгийн төвүүдийг хооронд нь болон хилийн боомтуудтай холбох “ТАВАН ТОЙРОГ” дэд бүтцийн мега төслийн их бүтээн байгуулалтыг яаралтай хэрэгжүүлж дуусгах шаардлагатай.

Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлж, бүс бүхэнд ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд **Хангайн** бүсийг “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс”, **Баруун** бүсийг “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс” болгон, **Хойд** бүсийг “Байгалийн аялалын жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Говийн** бүсийг “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс” болгон, **Төвийн** бүсийг “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс” болгон, **Зүүн** бүсийг “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс” болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.

Хоёр.Хүний хөгжлийн бодлогын хүрээнд:

Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, Үндэсний баялгийн сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, “И-Монгол” платформоор дамжуулан иргэн бүрд хуримтлалын данс нээнэ.

Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ.

Шинжлэх ухаанч сэтгэлгээ, зөөлөн ур чадвар (soft skills), асуудалд суурилсан (Problem based learning) шүүмжлэн эргэцүүлэх чадамжтай (critical thinking), эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай гэр бүлийн гишүүн байх дэлхийн Монгол иргэнийг бэлтгэх боловсролын тогтолцоог бэхжүүлнэ.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ.

Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж буй хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратеги (one or two way messaging)-ийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжих боловсрол олгоно.

Олон улсын зохистой дадал, стандартыг бүрэн нэвтрүүлэхийн зэрэгцээ эм, эмнэлгийн хэрэгслийн салбар дундын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эмийн импортыг бүрэн цахимжуулна.

Иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ.

2025 оныг “Залуучуудын жил” болгон зарлаж, оюутан, залуучуудын чөлөөт цагаараа ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулж, нийгмийн идэвх, оролцоог дэмжинэ.

Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна.

Гурав.Эдийн засгийн бодлогын хүрээнд:

Боомтын шинэчлэлийг эрчимжүүлж, боомтын тоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг нь бүрэн цахимжуулж, төмөр замын хил дамнасан холболтыг гүйцээж, нүүрсний экспортын хэмжээг жилд 100 сая тоннд хүргэнэ.

Эрчээ алдсан эрчим хүчний салбарыг эргэн сэргээхгүйгээр хот байгуулах, эдийн засгийг тэлэх боломжгүй. Иймд эрчим хүчний салбарыг либералчилж, эх үүсвэр нэмэгдүүлэх төслүүд хэрэгжүүлнэ.

Хувийн хэвшлийн жам ёсны бизнесийн орчныг бүрдүүлж, татварын реформ хийж, Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, зах зээл дэх төрийн зохицуулалтыг багасгаж, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.

Хөрөнгө оруулалт, худалдаа, дампуурлын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа багц хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө.

Төрийн худалдан авах ажиллагааг хиймэл оюун ухааныг ашиглан зохион байгуулна.

Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, тэтгэврийн нөөц сан, хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын менежментээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлнэ.

Гадаадын банкны салбар нэгжийг дотоодын зах зээлд нэвтрүүлж, гадаадын хөрөнгө оруулалттай банк, санхүүгийн байгууллагыг байгуулна.

“Go Mongolia” аялал жуулчлалын хөтөлбөрийг үргэлжлүүлж, гадаад жуулчдын тоог жилд 2 саяд хүргэнэ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 8.8 хувьд хүргэнэ.

Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

30 жил хүлээгдсэн эрчим хүчний салбарын реформыг цаг алдалгүй эхлүүлж, эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, аж үйлдвэржилт, бүсчилсэн хөгжил, шинэ хотын бүтээн байгуулалт зэрэг эдийн засгийг тэлэх дараах мега төслүүдийг хэрэгжүүлнэ:

Д/д	Төслийн нэр	Хүрэх үр дүн
-----	-------------	--------------

1.	"Гашуунсухайт-Ганцмод", "Ханги-Мандал", "Шивээхүрэн-Сэхээ" хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал	-Экспортын хүчин чадал 40 сая.тн хүртэл нэмэгдэнэ. (Гашуунсухайт-Ганцмод 20 сая.тн, Ханги-Мандал 10 сая.тн, Шивээхүрэн-Сэхээ 10 сая.тн) -Экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.
2.	Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц	-Жилд 3150.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, Оюутолгойн өсөн нэмэгдэх 2,242.5 сая кВт.ц хэрэглээ болон Тавантолгойн орд газрууд, бусад стратегийн ач холбогдолтой өмнөд бүсийн уул уурхайн төслийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг дотоодоос хангах боломж бүрдэнэ. -Оюутолгой ХХК-ийн БНХАУ-аас импортолж байгаа 110-120 сая ам.долларын вальютын урсгалыг зогсооно. -Барилга угсралтын явцад давхардсан тоогоор 2000, ашиглалтад орсноор 300 байнгын ажлын байр шинээр бий болно.
3.	Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц	-Жилд 366 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ба баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 2027 оноос эхлэн 100 хувь найдвартай, тасралтгүй хангах боломж бүрдэнэ. -52,000 ахуйн хэрэглэгчийг хангах эрчим хүчний шинэ эх үүсвэр бий болж, баруун аймгуудын 4,430 аж ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.
		-ОХУ, БНХАУ-аас жил бүр импортоор авч байгаа 17.5 тэрбум төгрөгийг хэмнэнэ.
4	Эгийн голын 310 МВт-ын усан цахилгаан станц	-Эрчим хүчний системийн найдвартай, тогтвортой, шуурхай ажиллагааг хангаж, системийн эх үүсвэрийн зохистой харьцааг бүрдүүлнэ. -ОХУ-д жил бүр төлдөг 25 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэнэ. -Түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 438,7 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулна.

		-5.7 тэрбум шоо метр цэвэр усны нөөц бүрдүүлж, Монгол Улсын усан хангамжийн аюулгүй байдлыг хангана.
5.	Сэргээгдэх эрчим хүч ба тархмал эх үүсвэр	-Монгол Улс нь судалгаагаар 2,600 гВт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй болох нь тогтоогдсон бөгөөд шинээр эх үүсвэрүүдийг бий болгох замаар өсөн нэмэгдэж буй дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөх, бусад улс руу экспортлох боломжтой. -Сэргээгдэх эрчим хүчний салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүрдэхээс гадна хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нүүрс хүчлийн хийн (carbon credit) арилжаанд оролцож, нэмэлт орлого олох боломж нээгдэнэ.
6.	Хэрлэн-Тооно, Орхон-Онги ус дамжуулах шугам	<u>Хэрлэн-Тооно усан цогцолбор:</u> -Хэрлэн голын олон жилийн дундаж урсацын 5-9%-ийг битүү хоолойгоор дамжуулан Хэнтий, Чойр, Дорноговь, Өмнөговь аймгийн хүн ам, мал аж ахуй, үйлдвэр, уул уурхайн усны хэрэгцээг бүрэн хангана. - Жилдээ 30 мян.тн хүлэмжийн хийг бууруулна. -“Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд усны асуудлыг шийдвэрлэж, цөлжилт, хуурайшилтыг сааруулна. <u>Орхон-Онги усан цогцолбор:</u> -Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны төвшин тогтворжиж, нийгмийн хувьд Онги голын дагууд оршин сууж буй 29.2 мянган хүн ам, 230 гаруй мянган толгой мал сүргийг гадаргын усаар хангах нөхцөл бүрдэнэ. -Агаар, хөрсний чийгшил, газрын доорх усны тэжээгдэл нэмэгдэж, нуурын орчны бүсийн экосистем, биологийн олон янз байдал сэргэж, хөрсний элэгдэл эвдрэлд орох нөхцөл багасаж, цөлжилтийг бууруулна.
7.	Эрээнцав-Чойбалсан-Баруун Урт-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн авто зам	Худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, тээврийн зардлыг бууруулах ач холбогдолтой.
8.	Монгол, Францын хамтарсан уран,	-Үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажиллавал жилд 2,500 тонн ураныг олборлож экспортолно.

	атомын цахилгаан станц	-Төсөл хэрэгжих хугацаанд улс, орон нутгийн төсөвт нэг тэрбум гаруй ам.долларын татвар төлөх тооцоотой. -Үйлдвэрлэлийн туршилтын төсөл дээр үндсэн үйлдвэрлэлийн олборлолт эхлэхэд 1,000 гаруй ажлын байр бий болно. Улс, орон нутгийн хэмжээнд томоохон хэмжээний худалдан авалт хийж, бизнесийн боломж нэмэгдэнэ.
9.	Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор	-Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах үйлдвэрлэлийг нэг шат ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхийн эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ. <u>Кокс-химийн үйлдвэр:</u> -Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр шатанд 10 сая тонн коксжих нүүрсийг угааж, 5.4 сая тонн баяжуулсан нүүрс, 3 сая тонн завсрын бүтээгдэхүүн (мидлинг) үйлдвэрлэнэ. -2.7 сая тонн баяжуулсан нүүрсийг боловсруулж, 2 сая тонн хатуу кокс, 107 МВт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэнэ. -Дотоодын хэрэглээнээс илүү гарсан 1.5 сая тонн коксын бүтээгдэхүүнийг экспортолно. <u>Алтанширээт УТП:</u> 140 га талбайд төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс угаах үйлдвэр, коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн гэх мэт дагалдах үйлдвэрүүд бүхий 500 мян.тн/жил ширэм үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр ашиглалтад орно.
10.	Зэс боловсруулах цогцолбор	-Жилд 560 мян.тн зэсийн баяжмал боловсруулж, 125 мян.тн катодын зэс, 72 кг алт, 38.2 тн мөнгөн гулдмай болон 182 мян.тн элементийн хүхэр үйлдвэрлэж, 1.1 тэрбум ам долларын борлуулалтын орлогыг бүрдүүлнэ. -Катодын зэсийн үйлдвэр нь дотоодын зэс утас, кабель, цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэх салбарыг хөгжүүлэхэд томоохон түлхэц үзүүлнэ. -Үйлдвэрээс гарган авах 182 мянган тонн элементийн хүхэр нь химийн болон бордооны үйлдвэрлэлд өргөн

		ашиглагдах тул нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг нэмэгдүүлнэ.
11.	Гангийн үйлдвэр	-Дотоодын тасралтгүй нэмэгдэж буй ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд 1.0 сая тонн ган бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. -Гангийн үйлдвэрийг ашиглалтад оруулж эхний ээлжид 500 мян.тн ширэм, 500 мян.тн ган бэлдэц үйлдвэрлэж, ган бэлдцээс барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг ган бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматурын хэрэгцээг бүрэн хангана.
12.	Газрын боловсруулах цогцолбор тос	Жилд 1.5 сая.тн түүхий тосноос 1.3 сая.тн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг бүрэн хангах боломж бүрдэнэ. Ингэснээр импортын хараат байдлыг бууруулах, шатахууны үнийг бие даан уян хатан зохицуулах боломж бүрдэнэ.
13.	Оюу толгой төсөлд түшиглэсэн алт цэвэршүүлэх үйлдвэр	- Жилд гадаад орны алт цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлж, мөнгөжүүлдэг алтны 70 хувийг дотооддоо цэвэршүүлэх боломж бүрдэнэ. -Баяжуулсан алтны хувийг нэмэгдүүлж, олон улсын зах зээлд борлуулж, валютын орлогыг нэмэгдүүлэх боломжтой. -Монгол Улс алтаа одоог хүртэл гадаад орнуудад цэвэршүүлж байгаа бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор үүнтэй холбогдон гарах тээвэр, даатгал, хамгаалалтын зардал хэмнэгдэнэ.
14.	Үндэсний хиймэл дагуул	-Монгол орны нийт газар нутгийн 26.8 хувьд 4G сүлжээ нэвтэрсэн. Үлдсэн 73.2 хувь буюу орон нутгийн иргэд, малчин айл өрхийг шилэн кабелиар интернет сүлжээнд холбоход шаардлагатай 29.0 их наяд төгрөгийг хэмнэж, улс орны өнцөг булан бүрд интернетийн сүлжээ нэвтэрнэ. -Байгалийн гамшиг, гэнэтийн аюул, ослын үед газрын сүлжээнд саад доголдол гарсан тохиолдолд сансрын холбооны сүлжээ нь найдвартай холбооны сүлжээ болно.

Дээрх төслүүдийг амжилттай хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлтийг 5-6 ба түүнээс дээш хувьд, инфляцыг нэг оронтой тоонд, зээлжих зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ. Түүнчлэн, Эдийн засгийн эрх чөлөөний байдлын үзүүлэлт, Дэлхийн инновацын үзүүлэлтийг тус тус 10 байраар ахиулна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 8,000-10,000 ам.долларт хүргэнэ. Хүний хөгжлийн үзүүлэлтийг 10 байраар ахиулж, ядуурлын түвшинг 2 дахин бууруулна.

Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд:

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж, цэгцлэх арга хэмжээ авна.

Авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг үргэлжлүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Шүүхийн процессыг цахимжуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг ил тод болгож, хэрэг, маргааныг түргэн шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, иргэдийн шүүх засаглалд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

Цахим засаглалын бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэн, хүний оролцоогүй, хиймэл оюун ухаанд суурилсан төрийн үйлчилгээний ухаалаг “E-Mongolia” нэгдсэн системийг нэвтрүүлж, бүртгэл нэртэй зөвшөөрлүүдийг цуцалж, зөвшөөрлүүдийг бүрэн цахимжуулна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлж, уул уурхайн төрийн өмчит компаниудыг олон улсын менежментийн багаар удирдуулж, үр ашгийг дээшлүүлнэ.

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын зөвлөх үйлчилгээ авч, цомхон, чадварлаг төрийн албыг бий болгох реформ хэрэгжүүлнэ. Төрийн албаны хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний цогц систем (DME-Design, Monitoring Evaluation)-ийг хөгжүүлж гүйцэтгэлийг үнэлнэ.

Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулж, төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг “1+2” буюу гадаадад хэлний болон ахисан түвшний сургалтад хамруулна.

Засгийн газрын тусгай сангуудын санхүүжилт, сонгон шалгаруулалтыг цахимжуулж ил тод, шударга болгоно.

Дээрх засаглалын бодлогыг хэрэгжүүлснээр засаглалын үзүүлэлтийн индекс болон Дэлхийн сайн орны үзүүлэлтийг тус бүр 10 байраар, Авлигын индексийг 30 байраар тус тус урагшлуулна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан бодлого, зорилтын хүрээнд бүтээн байгуулалтын үндэсний хэмжээний томоохон **149 төслийг** хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Эдгээр төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн чадавх, манлайлал нэн тэргүүнд тавигдах бөгөөд нийт төслийн 54.1 хувь нь дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд, 18 хувь нь аж үйлдвэрийг хөгжүүлэхэд, 27.8 хувь нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд тус тус чиглэгдэж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан **нийт 149 төслийг** үр дүнтэй хэрэгжүүлэхэд эдийн засгийн өсөлтийг жил бүр 5 хувиас доошгүй түвшинд хадгалах

бодлогыг баримтлах шаардлагатай бөгөөд **нийт 120 орчим их наяд** төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шаардлагатай гэсэн санхүүгийн урьдчилсан тооцоо гарсан.

Эдгээрээс улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар **12.3 хувийг** санхүүжүүлэх боломжтой бөгөөд төр, хувийн хэвшлийн түншлэлээр **24.4 хувь**, гадаад, дотоодын зээл, тусламжийн хөрөнгөөр **17.3 хувийг** тус тус хэрэгжүүлж, үлдсэн **46 хувийг** бусад эх үүсвэрийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна. Иймээс төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, төсөв, мөнгөний бодлогын уялдааг сайжруулахад чиглэсэн эрх зүйн шинэчлэлийг авч хэрэгжүүлнэ.

Дэлхийн дахиныг хамарсан геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логиستيкийн доголдол, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, байгаль, цаг уур, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн давагдашгүй хүчин зүйлс зэрэг гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөнөөс үүдэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд учирч болзошгүй эрсдэлийг тооцон үзэж, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангаж, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

Мөн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, удирдлагын төлөвлөгөөг сайжруулан шинээр үүсэж болзошгүй нөхцөл байдал, хямралын дараах сорилтын бэлэн байдлыг хангаж ажиллана.

--oo00oo--

НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Бүс нутагт амьдрахад таатай нөхцөлийг бий болгох, хот, хөдөөгийн тэнцвэрийг хангах бүсчилсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, иргэдэд таатай, эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэд бүтэц бүхий хотуудыг хөгжүүлнэ.

1.1. Улаанбаатар хот - “20 минутын хот” стандарт

1.1.1. Хот төлөвлөлт, засаглалын реформ

- 1.1.1.1. “20 минутын хот” буюу иргэн оршин суугаа газраасаа 300-500 метрт цэцэрлэг, сургууль, цэцэрлэгт хүрээлэн, эмнэлэг, эмийн сан, тоглоомын талбай, спортын талбай, худалдаа, үзвэр үйлчилгээ, цагдаа зэрэг төрийн үйлчилгээг авах бололцоог бүрдүүлсэн “Нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040”-г боловсруулж, батлуулна.
- 1.1.1.2. Хот төлөвлөлт, орчны стандарт алдагдсан орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлнэ.

1.1.2. Эрчим хүчээр хангагдсан хот

- 1.1.2.1. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн дулааны станцууд болон хотын дэд төвүүдийн дулааны станцуудыг үе шаттайгаар барина.
- 1.1.2.2. Нийслэл хотод бие даасан, тархмал цахилгаан, дулааны эх үүсвэрийг байгуулж, суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 1.1.2.3. Хүрэн нүүрсний ордыг түшиглэсэн 300МВт-ын хүчин чадал бүхий дулааны цахилгаан станцыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна.
- 1.1.2.4. Хог шатаах аргаар эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн төслийг дэмжинэ.
- 1.1.2.5. “Парк”, “Дамбадаржаа”, “Баянхошуу”, “Их наран” дэд станц, 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барина.
- 1.1.2.6. “ДЦС 2”, “ДЦС 3”-ын дэд бүтцийг түшиглэн станцуудын хүчин чадлыг өргөтгөх төслийг хэрэгжүүлнэ.
- 1.1.2.7. Багануур дүүрэгт 50 МВт буюу 200 МВт/цаг батарей хуримтлуурын төслийг барьж, оргил ачааллыг бууруулна.
- 1.1.2.8. Ердийн ачааллын үеийн цахилгааныг хуримтлуулж, оргил ачааллын үед төвийн системд нийлүүлэх төслүүдийг дэмжинэ.
- 1.1.2.9. “ДЦС-4” 500 тонн/цагийн уур үйлдвэрлэх хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөнө.
- 1.1.2.10. Налайх дүүргийн дулааны станцын шинэ эх үүсвэрийг барьж, дулааны хүчин чадлыг 216 МВт-аар нэмэгдүүлэх төсөлд дэмжлэг үзүүлнэ.
- 1.1.2.11. Гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт бий болгох дулаалгын төслийг хэрэгжүүлнэ.

1.1.3. Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт

- 1.1.3.1. Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу дэд төв орчмын газрыг үргэлжлүүлэн чөлөөлж, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг барих, 20,000 айлыг орон сууцжуулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, Толгойт, Шархад, Дэнжийн 1000, Дамбадаржаа, Яармаг дэд төвүүдийн инженерийн дэд бүтцийг барьж байгуулна.
- 1.1.3.2. Цэвэрлэх байгууламжийн тархмал дэд төвүүдийг шинээр байгуулах замаар нүхэн жорлонгийн тоог 2 дахин бууруулж, хөрсний бохирдлыг бууруулна.
- 1.1.3.3. Ипотекийн зээлийн 50-иас багагүй хувийг дэд төв, дагуул хот, гэр хорооллын өрхөд олгоно.
- 1.1.3.4. Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 1.1.3.5. Гэр хороолол, дэд төв, дагуул хотуудад орон сууц барьсан аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх бодлого баримтална.
- 1.1.3.6. Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийг шинээр болон өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

1.1.4. Ногоон - ухаалаг хот

- 1.1.4.1. Хууль бусаар олгосон газрыг нийтийн эзэмшлийн газар болгож, уг газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн барьж, хотын иргэн оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.4.2. Тээврийн хэрэгслийн насжилт, түүнээс гарах бохирдолд тавих стандартыг дээшлүүлж мөрдүүлэх, нийтийн тээвэр, явган зорчигчдод ээлтэй дэд бүтцийг бий болгон алхах, дугуй унахад аюулгүй тав, тухтай байдлыг ханган автомашины хэрэглээг бууруулж, автомашинаас гарах бохирдлын хэмжээг хоёр дахин бууруулна.
- 1.1.4.3. Улаанбаатар хотын төв, хүн ам ихээр төвлөрсөн бүсүүдээр аюултай ачаа тээвэрлэхгүй байх зохицуулалтыг хийнэ.
- 1.1.4.4. Улаанбаатар хотын хөдөлгөөн удирдлагын төвийн системд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологийг нэвтрүүлж гэрлэн дохионы зохицуулалтыг хөдөлгөөний урсгалаас хамаарч ухаалгаар зохицуулах боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.4.5. Хяналтын камер, урсгал мэдрэгч төхөөрөмжүүдийг иж бүрэн суурилуулан, хотын хөдөлгөөн, бохирдол, эрчим хүчний хэрэглээ, аюулгүй байдлын мэдээллийг цаг алдалгүй авч анализ хийдэг, зохицуулах арга хэмжээ авдаг системийг нэвтрүүлж, хиймэл оюун ухаанд суурилсан гамшгийн эрсдэлийн удирдлага, менежментийг хөгжүүлнэ.
- 1.1.4.6. Туул, Сэлбэ, Улиастай, Нарангийн голын эргийн хамгаалалтын 30 км далан болон ус зайлуулах 100 км суваг шинээр барьж, дөрвөн байршилд усан сан, хөв, цөөрөм байгуулж хот доторх гол, горхины урсцад тохируулга хийдэг болно.
- 1.1.4.7. “Туул усан цогцолбор төсөл”-ийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, ундны ус, ахуйн усан хангамжийг нэмэгдүүлнэ.

1.1.5. Олон төрөлт нийтийн тээвэр, авто зам

- 1.1.5.1. Нийслэлийн их, бага тойруу буюу 770 га газарт төвлөрсөн төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу “Go Mongolia” ган татлагат гүүрийн төсөл, Хөшигийн хөндийн туннелын төслийг хэрэгжүүлнэ.
- 1.1.5.2. Туулын замыг Нисэхийн хурдны авто замтай холбож, наадамчдын авто зам дээгүүр гүүрэн байгууламж барина.
- 1.1.5.3. Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км “Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1”, Ард Аюушийн өргөн чөлөө-Их тойруу-Намъянжүгийн гудамж-Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урт тусгай замын автобус “BRT Шугам-1”, Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт “Дүүжин тээвэр шугам-1” бүхий олон төрөлт их багтаамжийн нийтийн тээврийн системүүдийн уялдаа холбоог хангаж, үе шаттай барьж байгуулна.
- 1.1.5.4. Олон улсын чанартай 88 км “Шинэ тойрог зам”, Туулын хурдны замыг барьж, ачаа тээврийн хөдөлгөөнийг хотын гадуур тойруулна.
- 1.1.5.5. Улаанбаатар хотод тойрог замын зохион байгуулалт хийж, замын хөдөлгөөний эрчмийг 30 хувиар нэмэгдүүлж, их өгөгдөлд үндэслэн автобусны сүлжээ, чиглэлийг оновчилж, төлбөрийн системийг хялбарчилж, хүн амын нягтаршилд тохируулж, нийтийн тээврийн хэрэгслийг оршин суугчдад хүртээмжтэй байдлаар дахин төлөвлөнө.

1.2. Бие даасан эдийн засаг бүхий дагуул хот**1.2.1. Дагуул хотуудын дэд бүтэц**

- 1.2.1.1. Шинэ Зуунмод хотод төрийн байгууллагуудыг үе шаттайгаар шилжүүлэн байршуулж, олон улсын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, аялал жуулчлалын цогцолбор, ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв, сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор, их сургуулийн хотхон бүхий аялал жуулчлал, олон улсын бизнес, санхүүгийн төрөлжсөн эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлнэ.
- 1.2.1.2. Аялал, жуулчлал, тээвэр логистик, олон улсын санхүүгийн төв, эдийн засгийн чөлөөт бүс бүхий эко-ухаалаг Шинэ Зуунмод дагуул хотын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үе шаттайгаар шийдвэрлэж, дулааны станц, цэвэрлэх байгууламжийн дэд бүтцийг барьж байгуулна.
- 1.2.1.3. Багануур, Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк, Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгана.
- 1.2.1.4. Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамжийг дүүрэг бүрд байгуулна.
- 1.2.1.5. Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборыг ашиглалтад оруулна.

1.2.2. Дагуул хотуудын хөгжил

- 1.2.2.1. Номтын аманд төр захиргааны нэгдсэн байрыг барьж байгуулна.

- 1.2.2.2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суух иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор орон сууц, амины орон сууц, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, туслах аж ахуй эрхлэхэд газар олгох, хөрөнгө оруулалтаар дэмжих, ипотекийн зээлд хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.2.2.3. Налайх, Багануур зэрэг улсын зэрэглэлтэй хотын дэд бүтцийг эрчимжүүлж, эдийн засаг, санхүүгийн хувьд бие даасан байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.2.2.4. Хөшигийн хөндийд шинээр бий болох сургалт, эрдэм шинжилгээний цогцолборыг түшиглэн “Кино, контент үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулна.
- 1.2.2.5. Шинэ Зуунмод хот дахь чөлөөт бүсийг тулгуурлан “Цахиурын хөндий”, дата төв, хүлэмжийн болон сэргээгдэх эрчим хүчний хосолсон загвар аж ахуйг хөгжүүлнэ.
- 1.2.2.6. 45,000 тонн нарийн ногоо хураах өвлийн хүлэмжийн кластер бүхий Агросити эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 1.2.2.7. Олон улсын санхүүгийн төв байгуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

1.3. Бүсийн төрөлжсөн хөгжил

1.3.1. Хангайн бүс - “Уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн, хот байгуулалтын дэд бүс”

- 1.3.1.1. Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтад шаардлагатай суурь судалгаа, иж бүрэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусган, дэд бүтэц, бүтээн байгуулалтын эхний ээлжийн ажлыг эхлүүлнэ.
- 1.3.1.2. Шинэ Хархорум хотын усны хэрэгцээг хангах бүтээн байгуулалтыг эхлүүлж, Орхон голд урсцын тохиргоо хийж, усан хангамжийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.3.1.3. Орхон голын сав, Хангай нурууны экосистемд түшиглэсэн рашаан сувилал, адал явдалт, түүх соёлын аяллыг хөгжүүлж, археологийн нөөцөд тулгуурласан “Төв Азийн түүх, соёлын голомт” соёлын аялал жуулчлалын цогцолборыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- 1.3.1.4. Бүс нутгийн онцлогт тохирсон мал үржүүлэг, үржлийн цөм сүрэг бий болгож, орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжинэ.
- 1.3.1.5. Байдрагийн усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ.

1.3.2. Баруун бүс - “Эрчим хүчний төрөлжсөн, байгалийн аялал жуулчлалын дэд бүс”

- 1.3.2.1. Алтайн нуруу, байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн адал явдалт, тусгай сонирхол, хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Их нуурууд, Отгонтэнгэр хайрханд тулгуурласан аялал жуулчлалын

тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.

- 1.3.2.2. Асгатын мөнгөний ордын нөөцийг тогтоож эргэлтэд оруулна.
- 1.3.2.3. Хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк, эрдэс-түүхий эдийн нөөцөд тулгуурлан дэвшилтэт технологийн шохойн үйлдвэр, Алтайн нурууны байгаль, соёлын өвийг түшиглэсэн эко парк, цогцолбор байгуулахыг төр хувийн хэвшлийн хүрээнд хамтран хэрэгжүүлнэ.
- 1.3.2.4. Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын төсөл, Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын төслийг хэрэгжүүлнэ.
- 1.3.2.5. Дээд боловсролын сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолборыг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Их сургуулийн хотхоныг баруун бүсэд байгуулна.

1.3.3. Хойд бүс - “Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”

- 1.3.3.1. Бүсийн байгаль, газарзүйн онцлогт түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, Хөвсгөл нуурт тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
- 1.3.3.2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр байгуулна.
- 1.3.3.3. Эгийн голд эрчим хүчний нэгдсэн системийн горим тохируулгын үндсэн эх үүсвэр 310 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барина.
- 1.3.3.4. Босоо тэнхлэгийн Бага- Илэнх боомт - Хутаг-Өндөр чиглэлийн 137 км авто замыг барина.
- 1.3.3.5. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг төрөлжүүлэх, 2 аймагт салбар дундын дадлага, үйлдвэрлэлийн баазыг байгуулна.

1.3.4. Говийн бүс - “Аж үйлдвэрийн төрөлжсөн, ногоон эрчим хүчний дэд бүс”

- 1.3.4.1. “Тавантолгой” УТП-ийг түшиглэсэн Кокс-химийн цогцолбор барих ажлыг эхлүүлнэ.
- 1.3.4.2. Тавантолгойн бүлэг ордыг түшиглэн хүнд үйлдвэрлэлийн “Үйлдвэр технологийн парк” байгуулах, “Алтанширээт” үйлдвэрлэл технологийн парк, “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулахыг төр хувийн хэвшлийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 1.3.4.3. Говийн бүсэд нар, салхины тус бүр 100 МВт хүртэл хүчин чадалтай цахилгаан станц барина.
- 1.3.4.4. Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.
- 1.3.4.5. Бага-Илэнх боомт-Шивээхүрэн боомт чиглэлийн босоо тэнхлэгийн авто замын говийн бүсэд ногдох хэсгийг барина.

1.3.5. Төвийн бүс - “Хөдөө аж ахуйн төрөлжсөн, аж үйлдвэрийн дэд бүс”

- 1.3.5.1. Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логикийн цогцолбор, “Үйлдвэр технологийн парк”-уудыг хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг тэргүүн ээлжид дэмжин хөгжүүлнэ.
- 1.3.5.2. Дархан-Сэлэнгийн бүсэд металл боловсруулах болон металл бүтээгдэхүүний үйлдвэр, дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулна.
- 1.3.5.3. Шүрэнгийн усан цахилгаан станц барина.
- 1.3.5.4. Төвийн бүсэд Хөдөө аж ахуйн их сургуулийн нэгдсэн хотхон (кампус) байгуулна.
- 1.3.5.5. Хөшигийн хөндий болон Алтанбулаг чөлөөт бүсэд ачаа тээвэр, барилгын материалын логикийн төв байгуулна.
- 1.3.5.6. “Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, судалгаа, хөгжлийн төв”-ийг байгуулж, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг үе шаттайгаар нүүлгэнэ.

1.3.6. Зүүн бүс - “Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс”

- 1.3.6.1. Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх хүрээнд Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтай овоо, түүхэн аялал жуулчлалын газар нутгийг дэд бүтцээр холбох, усан боомт болон олон улсын 4С нисэх буудал байгуулна.
- 1.3.6.2. Зүүн бүсийг эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүсийн хувьд хөдөө аж ахуйн экспортыг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 1.3.6.3. Зүүн бүсийг Говийн бүстэй интеграцчилан хөгжүүлж, кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс-эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн паркийг төр-хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.

1.4. Орон нутгийн хөгжил**1.4.1. Шилжилт хөдөлгөөн**

- 1.4.1.1. Орон нутгийн нэмэгдлийг төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар тооцож улсын төсвөөс, төрийн захиргааны албан хаагчид 80 хувь хүртэл нэмэгдүүлэх эрхийг аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.4.1.2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан болон аймаг, сум Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт анх удаа орон сууц худалдан авах иргэдэд арилжааны банкнаас олгох ипотекийн зээлийг 3 хувийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- 1.4.1.3. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар нэгж, болон салбарын нийт албан хаагчдынхаа арваас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.4.1.4. Төвлөрлийг сааруулах хүрээнд Улаанбаатар хотоос орон нутагт шилжин үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжих нэг хувийн хүүтэй 500 сая хүртэлх зээл олгох бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.4.1.5. Бүсийн хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааг хангах төсөл, арга хэмжээ, түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.4.1.6. Орон нутагт чөлөөт бүс тусгай бүс аж үйлдвэрийн парк байгуулж боомт, хөрш орны хотуудтай холбоно.
- 1.4.1.7. Орон нутгийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлнэ.
- 1.4.1.8. Аймаг, нийслэл, сумын хот байгуулалтын баримт бичгийг бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.4.2. Орон нутгийн хөгжлийн нийтлэг зорилт

- 1.4.2.1. Орон нутгийн хөгжлийн төвүүдэд хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, бирж, тээвэр логикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх хувийн хэвшил, хоршоодыг дэмжинэ.
- 1.4.2.2. Стандартын шаардлага хангасан хүнс, эм, хүрээлэн буй орчны бүсчилсэн лабораторийн нэгдсэн тогтолцоог бий болгож хөгжүүлнэ.
- 1.4.2.3. Бүсүүдийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан аймгуудын мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудыг төрөлжүүлэн хөгжүүлнэ.
- 1.4.2.4. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан орон нутгийн иргэдэд нарийн мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллагыг төрөлжүүлнэ.
- 1.4.2.5. Орчин үеийн эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээний төвийг бий болгох, эм, эмнэлгийн хэрэгслийг тогтвортой хүргэх зорилгоор нөөцийн агуулах байгуулна.
- 1.4.2.6. Хот, суурин газруудын хүн амын ундны цэвэр усны шугамыг зэс шугамаар сольж ундны усны чанар, аюулгүй байдлыг хангана.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хөгжих, суралцах, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлж, чинээлэг, баялагтаа эзэн, эрдэм боловсролтой, эрүүл монгол хүнийг хөгжүүлнэ.

2.1. Чинээлэг монгол хүн

2.1.1. Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого

Гэр бүл

- 2.1.1.1. Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.1.2. Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, “Чанартай амьдрал-гэр бүлийн гишүүдийн оролцоо” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.1.3. Хиймэл оюун ухаан ашиглан иргэн бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 2.1.1.4. Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр бүх аймаг, дүүрэгт ажиллуулна.

Хүүхэд

- 2.1.1.5. Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ.
- 2.1.1.6. Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог иргэд, олон нийтийн оролцоотой бүрдүүлж, гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулна.
- 2.1.1.7. Сум, хороо бүрд хүүхэд гэр бүл, хүүхэд хөгжил, хамгааллын нийгмийн ажилтан ажиллуулж, хүүхдийн хөгжих таатай орчныг бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, хөгжил, хамгааллын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэнэ.
- 2.1.1.8. Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эх, эцгийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжих бодлого баримтална.

Эхчүүд, эмэгтэйчүүд

- 2.1.1.9. “Цалинтай эх, эцэг” нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно.
- 2.1.1.10. Эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.

Эрэгтэйчүүд

- 2.1.1.11. Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх чиглэлээр нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.1.1.12. Гэр бүлийн хөгжлийн цогц төвөөр дамжуулан эрэгтэйчүүдэд зориулсан хөгжил, нийгмийн үйлчилгээг үзүүлнэ.

- 2.1.1.13. Эрэгтэйчүүдийн зонхилон ажилладаг салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулна.
- 2.1.1.14. Эрэгтэйчүүдийн гэр бүлдээ зарцуулах цаг, оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангасан хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Ахмад настан

- 2.1.1.15. Ахмад настанд Гэр бүлийн хөгжлийн цогц төвөөр дамжуулан тэдний эрэлт, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн болон нийгмийн үйлчилгээ үзүүлж, идэвхтэй насжилтыг дэмжинэ.
- 2.1.1.16. Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна.
- 2.1.1.17. Ахмад настныг шинэ ур чадварт сургах, ажил, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.1.18. Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын оролцоог дэмжинэ.
- 2.1.1.19. Тэтгэврийн хэмжээг инфляц, хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн

- 2.1.1.20. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулна.
- 2.1.1.21. Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийг батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.
- 2.1.1.22. Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттай нэвтрүүлж, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.
- 2.1.1.23. Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүх аймаг, дүүрэгт байгуулна.
- 2.1.1.24. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна.

- 2.1.1.25. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангаж, цахимаар, зайнаас, цагаар болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

Оюутан, залуучууд

- 2.1.1.26. 2025 оныг “Залуучуудын жил” болгон зарлаж, оюутан, залуучуудын чөлөөт цагаараа ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулж, нийгмийн идэвх, оролцоог дэмжинэ.
- 2.1.1.27. Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцоог дэмжих “Залуусын оролцоо хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.
- 2.1.1.28. Залуучуудад чиглэсэн спорт, соёл урлагийн арга хэмжээнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг ашиглан оролцох боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.1.29. Их, дээд сургуулийн хөтөлбөрт өөрчлөлт оруулж, Зэвсэгт хүчний анги, байгууллагад хугацаат цэргийн алба хаах хугацаандаа цахимаар, зайнаас суралцах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.2. Хөдөлмөр эрхлэлт

- 2.1.2.1. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний нэгдсэн бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчныг шинэчилж, салбар хоорондын хамтын ажиллагаа, бодлогын уялдааг хангана.
- 2.1.2.2. Бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж инновацад суурилсан гарааны бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилт (венчур сан, matching хөтөлбөр)-ийн орчныг сайжруулна.
- 2.1.2.3. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим болон зайн ажлын байрыг нэмэгдүүлэх “Бүтээмжийн хувьсгал” санаачилгыг бүх түвшинд өрнүүлж, ажилгүйдлийн түвшнийг тууштай бууруулах бодлого баримтална.
- 2.1.2.4. Гадаадад ажиллаж амьдарч буй монгол иргэдийг эх орондоо эргэн суурьшихад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэх, зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлнэ.
- 2.1.2.5. Ядуурал, ажилгүйдэл болон хүн амын амьжиргааны түвшнийг тооцох аргачлалыг үндэсний онцлогт нийцүүлж, их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилан шинэчилнэ.
- 2.1.2.6. Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг нэмэгдүүлнэ.
- 2.1.2.7. Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно.
- 2.1.2.8. Зайнаас, цахимаар, цагаар ажиллах хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, эрх зүйн орчныг сайжруулна.
- 2.1.2.9. Тогтвортой ажлын байрыг шинээр бий болгосон жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг татвар, эдийн засгийн бодлогоор дэмжинэ.

2.1.3. Нийгмийн баталгаа**Нийгмийн даатгал**

- 2.1.3.1. Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, Үндэсний баялгийн сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, “И-Монгол” платформоор дамжуулан иргэн бүрд хуримтлалын данс нээнэ.
- 2.1.3.2. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.3.3. Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал”-тай болгож, тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.
- 2.1.3.4. Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хуулийн зохицуулалтыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.1.3.5. Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ.
- 2.1.3.6. Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулна.
- 2.1.3.7. Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно.

Нийгмийн үйлчилгээ

- 2.1.3.8. Халамжаас хөдөлмөрт шилжих бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн үйлчилгээний эрх зүйн орчныг шинэчилж, ядуурлыг бууруулах бодлого баримтална.
- 2.1.3.9. Төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- 2.1.3.10. “Хүүхдийн мөнгө” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.1.3.11. Орлого багатай иргэдийн нэмэлт орлогын эх үүсвэрээс авах татварыг бодлогоор бууруулна.
- 2.1.3.12. Жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.1.3.13. Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтыг төрийн худалдан авалтаар дэмжиж, худалдан авах бүтээгдэхүүний төсөвт өртгийг зах зээлийн үнэлгээнд нийцүүлнэ.
- 2.1.3.14. Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулан хөгжүүлнэ.
- 2.1.3.15. Гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлнэ.
- 2.1.3.16. Зохистой болон өндөр технологийн ажлын байрыг бий болгож, дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

- 2.1.4.1. Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна.
- 2.1.4.2. Спортын сургалт-дасгалжуулалтыг сайжруулж, шигшээ багийн нөөц тамирчдыг бэлтгэн, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон олимпын наадамд гаргасан амжилтыг хадгалж, Азийн наадамд улсын дүнгээр эхний 15-р байрт орох алхмыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.1.4.3. Спортын авьяасыг нээн илрүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлж, хөгжих боломжийг олгоно.
- 2.1.4.4. Спортын санаачилга, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх компанит ажлуудаар идэвхтэй хөдөлгөөн болон эрүүл амьдралын хэв маягийг дэмжинэ.

2.2. Эрдэм боловсролтой монгол хүн**2.2.1. Тэгш, хүртээмжтэй, чанартай боловсрол**

- 2.2.1.1. Дижитал шилжилт, технологийн өөрчлөлт шинэчлэлийн сорилтыг даван туулах чадвартай, монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч хүмүүжлийг олгох боловсролын үндэсний хөтөлбөрийг хөгжүүлнэ.
- 2.2.1.2. Шинжлэх ухаанч сэтгэлгээ, зөөлөн ур чадвар (soft skills), асуудалд суурилсан (Problem based learning) шүүмжлэн эргэцүүлэх чадамжтай (critical thinking), эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай гэр бүлийн гишүүн байх дэлхийн Монгол иргэнийг бэлтгэх боловсролын тогтолцоог бэхжүүлнэ.
- 2.2.1.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг их өгөгдөлд суурилан тооцоолж, шаардлагатай хүний нөөцийг бэлтгэнэ.
- 2.2.1.4. Боловсролд бүх хүүхэд, залуучуудыг тэгш хамруулах зарчмыг баримталж, ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, залуучуудыг хамруулсан, тэдний гэр бүл, орон нутгийн онцлог байдалд нийцсэн, тохируулгад орчин, дэд бүтэцтэй, хувилбартай, гэрийн сургалттай боловсролын үйлчилгээг бүх түвшинд бий болгоно.
- 2.2.1.5. Хот, суурин газрын сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд хүргэх “Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги”, “Гэрт ойр сургууль/цэцэрлэг-хамгийн сайн сургууль/цэцэрлэг” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.2.1.6. Хот, хөдөөгийн болон нийгэм, эдийн засгийн ялгаатай бүлгийн хүүхэд, залуучуудын боловсролын чанарын ялгааг арилгаж, малчин эцэг, эх, асран хамгаалагчийн дэргэд бага боловсрол эзэмших боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.1.7. Хүүхдийн тооны өсөлт, ахлах сургуулийн төрөлжилт, сургалтын байгууллагыг цогцолбороор хөгжүүлэхтэй уялдуулан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг өргөтгөж, шинээр барина. Сургууль, цэцэрлэгийн барилгын гамшиг, газар хөдлөлт, эрүүл

- ахуй, аюулгүй байдлын стандартыг дээд зэргээр хангасан ижил загварын зурагтай болно.
- 2.2.1.8. Хүүхэд харах үйлчилгээний хүрээнд нялх балчир насны (2 хүртэл) хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх, 1-2 насны хүүхдийн яслийн үйлчилгээний хувилбарыг бий болгоно.
- 2.2.1.9. Сургуулийн өмнөх боловсролыг академик мэдлэг олгоход бус хүүхдийг сургуульд бэлтгэх, зөв хүмүүжлийн хандлага төлөвшүүлэх, зөв хооллолт болон өөрийгөө арчилж чаддаг чадварт сургахад чиглэнэ.
- 2.2.1.10. Ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангиас эхлэн англи хэл, кодчилал, роботик болон хиймэл оюуны ур чадварыг хөгжүүлэх сургалтыг нэвтрүүлнэ. Бүх түвшинд англи хэлний сургалтын чанарыг сайжруулж, ахлах сургууль, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагад зарим хичээлийг англи хэлээр заах боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.1.11. Дунд, ахлах сургуулийн боловсролын агуулгыг дэлхийн ирээдүйн хөгжлийн чиг баримжаанд нийцүүлж, өндөр технологи, байгаль орчин, сансар судлалын мэдлэг, мэдээллээр баяжуулан сургалтын хөтөлбөрийг шинэчилнэ.
- 2.2.1.12. Албан боловсролын сургалтад хамрагдах боломжгүй суралцагчдад зориулсан алтернатив сургалтыг хэрэгжүүлэх “Боловсролын чөлөөт бүс” бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.2.1.13. Цахим сургалтын байгууллагыг байгуулж, суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадварыг албан боловсролын сургалтад дүйцүүлэн дэвшин суралцаж, төгсдөг боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.1.14. Сургуульд суурилсан хүүхдийн эрүүл мэндийн эрт илрүүлгийн үндэсний тогтолцоог бий болгоно.
- 2.2.1.15. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны зардлыг хувьсах зардлаар санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, шаардлагатай шим тэжээлийн хэмжээ, инфляцын түвшинтэй уялдуулан тухай бүр нэмэгдүүлнэ.
- 2.2.1.16. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын дотуур байрны хүртээмж, орчин, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүний эрхэд ээлтэй дотуур байрыг бий болгоно.
- 2.2.1.17. Боловсролын хөрөнгө оруулалтыг үе шаттай нэмэгдүүлж, төсвийг Тогтвортой хөгжлийн зорилгын зорилтот түвшинд хүргэж, эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.2.1.18. Боловсролын даатгалын тогтолцоог бий болгон хөгжүүлж, эрсдэлээс хамгаална.
- 2.2.1.19. Боловсролыг дэмжих сангийн эрх зүйн орчныг шинэчилж, сангийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, тайлан, боловсролын тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг ил тод болгож цахимжуулан, хяналтыг тогтмолжуулна.

2.2.2. Мэдлэг чадвартай мэргэжилтэн

- 2.2.2.1. Мэргэжлийн ур чадвартай ажилтан, мэргэжилтнийг ахлах сургуулиас эхлэн бэлтгэнэ.

- 2.2.2.2. Боловсролын эрс хувирган өөрчлөлтийн туршилт, судалгааны “Боловсрол XXI” төслийг сонгогдсон 5 хүртэлх ЕБС дээр тусгай нөхцөлтэйгөөр хэрэгжүүлнэ.
- 2.2.2.3. Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг олгож, мэргэжлийн эрх олгох, сонгох боломжтой төрөлжсөн ахлах сургуулийг аймаг, дүүрэг бүрд байгуулна.
- 2.2.2.4. Төрийн өмчийн зарим их сургууль, политехник коллежийг түшиглэн, техникийн болон дээд боловсролын шаталсан тогтолцоо бүхий “сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” их сургууль, төрөлжсөн коллежийг бүсүүдэд хотхон хэлбэрээр хөгжүүлнэ.
- 2.2.2.5. Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлтийн хувийг эрэлттэй нийцүүлж, элсэлтийн шалгалтын босго оноог нэмэгдүүлж, элсэгчийн чанарыг сайжруулна.
- 2.2.2.6. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг ажил олгогчийн шаардлага болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн, иргэдийг ажиллангаа суралцах, суралцангаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хосмог, ажлын байрны сургалтыг нэвтрүүлнэ.
- 2.2.2.7. Төрийн өмчийн их сургуулиудыг сургалтын их сургуулиас-Судалгааны их сургууль болгож хөгжүүлж, академик эрх чөлөөг ханган инновацын эко-системийг бүрдүүлнэ.
- 2.2.2.8. "Ерөнхийлөгчийн илгээлт 2100" тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
- 2.2.2.9. Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж томилно.
- 2.2.2.10. Хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэх, бүс, орон нутгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан 5 жилийн сургалттай КООСЭН сургалтыг коллежийг түшиглэн нэвтрүүлнэ.
- 2.2.2.11. Суралцагчдад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөрөөр суралцах, дараагийн түвшний сургалтад кредит шилжүүлэн сурах, зарим мэргэжлийн дээд боловсролын сургалтын байгууллагыг 3 жилд төгсөх боломжийг олгох зорилгоор мэргэжлийн эрхтэй ахлах сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, технологийн коллеж, их сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлнэ.
- 2.2.2.12. Монгол Улсын их, дээд сургуулиуд дэлхийн шилдэг их сургуулиудтай хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, гадаадын нэр хүнд бүхий судлаач, эрдэмтдийг урьж ажиллуулах, оюутнуудыг гадаад улсад зуны сургалтад хамруулах бодлого хэрэгжүүлнэ.
- 2.2.2.13. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг үдийн сүүгээр хангах “Өдөр бүр нэг аяга сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2.3. Багшлах хүний нөөц

- 2.2.3.1. Багшийн чанар, үнэлэмж, гүйцэтгэл, менежментийг сайжруулах “Сайн багшийг таны дэргэд” цогц арга хэмжээг Багшийн 3 тулгуурт бодлогын хүрээнд хэрэгжүүлнэ.
- 2.2.3.2. Багшлах эрх олгох хялбаршуулсан сургалтын тогтолцоог бий болгож, багш бус мэргэжилтэй шилдэг боловсон хүчнийг багшаар бэлтгэх замаар багшийн хомсдолыг бууруулна.
- 2.2.3.3. Багшийн хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор үнэлж, багш, ажилчдын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг мөнгө, төсвийн бодлоготой уялдуулан, үе шаттайгаар нэмэгдүүлж, улсын дундаж хэмжээнд хүргэж, нийгмийн баталгааг хангана.
- 2.2.3.4. Багшлах хүний нөөцийг чадавхжуулж цэцэрлэгийн багш 10,000, бага ангийн багш 2,000, ЕБС-ийн багш 11,000, англи хэлний 2,000, МСҮТ-ийн 2,000 багшийг гадаад, дотоодод бэлтгэнэ.

2.2.4. Цахимжсан боловсрол

- 2.2.4.1. Боловсролын бодлого, санхүүжилт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд хүн ам, орон зай их өгөгдөлд тулгуурласан хиймэл оюун ухааныг ашиглах замаар үр ашиг, оновчтой байдлыг сайжруулна.
- 2.2.4.2. Боловсрол сургалтын үйл ажиллагаанд хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, багш, суралцагч, эцэг эх асран хамгаалагч нарт зориулсан контент, сургалтын сан, платформ, мэдээллийн технологийн хөтөлбөр, агуулгыг боловсруулж, хиймэл оюунд суурилсан цахим/дигитал сурах бичгийг хөгжүүлж, хүүхэд бүрд цахим төхөөрөмж олгоно.
- 2.2.4.3. Иргэдэд насан туршдаа суралцах тэгш боломжийг бүрдүүлж, нээлттэй боловсролын тогтолцоог хөгжүүлж, хүн бүрд орон зай, цаг хугацаанаас үл хамааран суралцах, боловсрол эзэмших тэгш хүртээмжтэй сургалтын контент, мэдээллийн системийг нэвтрүүлж, ур чадвар, чадамжийг дэмжсэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, гэрчилгээ олгох, микро кредитийн сургалтыг холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.2.4.4. Хүүхэд, залуучуудыг сургалтын байгууллагын орчинд цахим эрсдэлээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр стандарт боловсруулж, мөрдөнө.

2.3. Эрүүл монгол хүн**2.3.1. Нийгмийн эрүүл мэнд**

- 2.3.1.1. Эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 2.3.1.2. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж буй хүчин зүйлс, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратеги (one or two way messaging)-ийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжинэ.

- 2.3.1.3. “Эрүүл шүд”, “Хорт хавдраас сэргийлэх, хянах”, “Зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс сэргийлэх “Эрүүл Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ.
- 2.3.1.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх дэд төвийг бүс бүрт байгуулна.

2.3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж

- 2.3.2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, орон нутгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг бэхжүүлж, зарим тусламж, үйлчилгээний төвүүдийг төрөлжүүлэн байгуулна. /Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв, Хавдар судлалын үндэсний төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв-2, Зүрх судасны үндэсний төв/
- 2.3.2.2. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх тогтолцоог бэхжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.2.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, зарцуулалтыг оновчтой болгон иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад төлөх төлбөрийн хэмжээг бууруулна.
- 2.3.2.4. Маш цөөн хийгддэг, зардлын хувьд өндөр тусламж үйлчилгээг гадаад улс орны эмнэлэгтэй хамтын гэрээ байгуулан тусламж үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.3.2.5. Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж, уламжлалт эмийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэн экспортод гарах гарцыг нэмэгдүүлнэ.
- 2.3.2.6. Иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи телемедицин, хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ.
- 2.3.2.7. Эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санг олон улсын стандартын дагуу бүрдүүлж, их өгөгдөл үүсгэнэ.

2.3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмж

- 2.3.3.1. Олон улсын зохистой дадал, стандартыг бүрэн нэвтрүүлэхийн зэрэгцээ эм, эмнэлгийн хэрэгслийн салбар дундын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эмийн импортыг бүрэн цахимжуулна.
- 2.3.3.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарыг хянах лабораторийг үндэсний түвшинд бэхжүүлэх, дотоодын эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг олон улсын түвшинд хүргэж, экспортод гаргах боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.3.3.3. Эмийн худалдан авалтад үнийн хэлцэл хийх, олон улсын байгууллагаар дамжуулан худалдан авах, ДЭМБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаадын улс орноос эм, эмнэлгийн хэрэгсэл шууд худалдан авах тогтолцоог бүрдүүлнэ.

2.3.4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц

- 2.3.4.1. Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх зорилгоор шинэ дэвшилтэт технологи, арга, аргачлал нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, сургах, гадаадын ур чадвар бүхий мэргэжлийн багийг эх орондоо урьж, туршлага солилцуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.3.4.2. Эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн бэлтгэж байгаа их, дээд сургуулийн сургалтын чанарыг олон улсын жишигт нийцүүлнэ. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ажиллах эмч, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сувилагч нарыг түлхүү бэлтгэнэ.
- 2.3.4.3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулж, алслагдсан орон нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох төрийн дэмжлэг, хөнгөлөлт, урамшууллыг нэмэгдүүлнэ.

2.4. Баялагтаа эзэн монгол хүн**2.4.1. Үндэсний баялгийн сан, төлбөрийн чадварт нийцсэн орон сууцжуулалт**

- 2.4.1.1. Үндэсний баялгийн сангаар дамжуулан иргэдийг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд орлогод нийцсэн орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, орон сууцжуулалтыг эрчимжүүлнэ.
- 2.4.1.2. Өрхийн төлбөрийн чадварт нийцүүлж ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.4.1.3. Үндэсний орон сууцны корпорац байгуулж, орон сууцны ипотекийн хөтөлбөрийг үе шаттайгаар Засгийн газарт шилжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.4.1.4. “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүнийг өмчлөх хэлбэрийг орон сууцны төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 2.4.1.5. “Хашаандаа сайхан амьдаръя” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй амины орон сууц шинээр барих, засварлахад хөнгөлөлттэй зээл болон бусад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.4.1.6. Эх үүсвэрээ бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.1.7. Гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.1.8. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөрийг эхний 3 жилд хэрэгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.2. Барилга, барилгын материалын үйлдвэрлэл

- 2.4.2.1. Эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй ногоон барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн санхүүжилт, төр, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 2.4.2.2. Нийслэл, орон нутагт эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй амины болон олон нийтийн зориулалттай орон сууцыг барих хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлнэ.
- 2.4.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулахад хууль, эрх зүй, стандартыг боловсронгуй болгож, ээлтэй хот, барилга байгууламжид тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.4.2.4. Барилгын үйлдвэрлэлд хэрэглэгдэх гол нэр төрлийн материал болох ган туйван, цемент, хавтгай шилийг эрдэс, түүхий эдээр дотооддоо үйлдвэрлэж, импортыг бууруулна.
- 2.4.2.5. Импортын барилгын материалын чанар, хяналт, шинжилгээний лабораториудын хүчин чадлыг үе шаттай нэмэгдүүлнэ.
- 2.4.2.6. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, цементийн үйлдвэрүүдийг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 2.4.2.7. Үл хөдлөх салбарын хамтын хөрөнгө оруулалтын сан (REIT)-ийн хуулийг батална.
- 2.4.2.8. Үйлдвэрлэлийн процесс дэх төрийн оролцоог багасгах зорилгоор барилгын салбарын төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод үе шаттайгаар шилжүүлж, дагалдах хариуцлагын тогтолцоог бэхжүүлнэ.

2.4.3. Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтэц

- 2.4.3.1. Барилга, орон сууцны ашиглалтын эрх зүйн орчныг шинэчилж, орон сууц ашиглалтын контор болон сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулна.
- 2.4.3.2. Хүн амын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хүртээмжтэй, тогтвортой, чанартай үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 2.4.3.3. Ус хангамж, ариутгах татуурга, орон сууц нийтийн аж ахуйн салбарын мастер төлөвлөгөөг аймаг, нийслэл бүрээр гаргаж, бодлогын түвшинд хэрэгжүүлнэ.
- 2.4.3.4. Орон сууц, нийтийн аж ахуйн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг өргөтгөн шинэчлэх, дэвшилтэт техник тоног төхөөрөмж суурилуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, ашиглалтын түвшнийг сайжруулна.
- 2.4.3.5. Үерийн эрсдэл, хохирлын үнэлгээг бүс, орон нутаг тус бүрээр нарийвчлан гаргаж, инженерийн бэлтгэл арга хэмжээг салбарын уялдаатай хангаж, арга хэмжээний барилга байгууламжийг хот байгуулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхийн өмнө болон уялдуулан хэрэгжүүлэхийг салбар бүрд бодлогоор хэрэгжүүлж, үер, усны эрсдэл, хор хохирлоос урьдчилан сэргийлнэ.
- 2.4.3.6. Саарал усыг дахин ашиглана.
- 2.4.3.7. Бохирдуулагч үйлдвэр, үйлчилгээний салбарын хаягдал усны хяналтыг сайжруулна.

- 2.4.3.8. Зам, замын байгууламжийг хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний нэгдсэн төлөвлөлттэй уялдуулж, ус зайлуулах шугам сүлжээг барьж, байгуулна.
- 2.4.3.9. Хэрэглээний халуун, хүйтэн ус, дулаан, цахилгаан түгээх болон нийлүүлэх ажлыг гүйцэтгэж буй төрийн өмчит компаниудад менежментийн шинэчлэл хийж, томоохон хөрөнгө оруулагчдыг оруулах замаар хуучин дэд бүтцийн шугам, хоолой засварлах болон өргөтгөх ажлуудыг гүйцэтгэнэ.

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, олон тулгуурт, хүртээмжтэй, экспортын баримжаатай эдийн засгийг бэхжүүлнэ. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамж бүхий ногоон хөгжлийг цогцлооно.

3.1. Эдийн засгийн эрх чөлөө

3.1.1. Макро эдийн засгийн тогтвортой байдал

- 3.1.1.1. Эдийн засгийн өсөлтийг жил бүр 6 ба түүнээс дээш хувьд тогтвортой байлгах, инфляцыг 5 хувиас бага түвшинд хадгалах бодлогыг баримталж, гадаад валютын нөөцийг 10 тэрбум ам.доллар хүртэл нэмэгдүүлнэ.
- 3.1.1.2. Төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг хангана.
- 3.1.1.3. Монгол Улсын Үндсэн хуульд заасан байгалийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, “Ирээдүйн өв сан”-д ирээдүй үедээ хуримтлал үүсгэж, зээлжих зэрэглэл өндөртэй Засгийн газруудын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийн, Хөгжлийн сангаар улс орны эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх томоохон төслүүдийг санхүүжүүлнэ.

3.1.2. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа

- 3.1.2.1. Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, зохицуулалтыг хялбарчлан, салбаруудын болон хувийн секторын чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ.
- 3.1.2.2. Эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн, төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг оновчилж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож, төрийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах тогтолцоог оновчтой болгож, хиймэл оюун ухааныг ашиглана.
- 3.1.2.3. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх зарчмыг баримталж, төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.
- 3.1.2.4. Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.

3.1.3. Банк, санхүү, даатгалын салбарын реформ

- 3.1.3.1. Санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ.
- 3.1.3.2. Бичил, жижиг, дунд, бизнес эрхлэгчдэд таатай нөхцөлөөр санал болгох санхүүгийн бүтээгдэхүүнийг дэмжинэ.
- 3.1.3.3. Банкны салбарын реформыг үргэлжлүүлнэ.
- 3.1.3.4. Гадаадын банкны салбар нэгжийг дотоодын зах зээлд нэвтрүүлж, гадаадын хөрөнгө оруулалттай банк, санхүүгийн байгууллагыг байгуулна.

- 3.1.3.5. Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн оролцогчдын хүрээг тэлэх бодлого хэрэгжүүлж, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах татварын таатай орчин бүрдүүлнэ.
- 3.1.3.6. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл, тэтгэврийн нөөц сан, хувийн нэмэлт тэтгэврийн сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг эрх бүхий мэргэжлийн байгууллагын менежментээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.1.3.7. Олон улсын цахим төлбөрийн системүүдийг нэвтрүүлж, төлбөр тооцоог саадгүй хүлээн авах боломжийг бүрдүүлэн цахим худалдааг дэмжинэ.
- 3.1.3.8. Хөгжлийн банкны үйл ажиллагааг экспорт-импортын банк болгон өргөжүүлж, засаглалыг сайжруулан, ногоон орон сууцны санхүүжилтийн хөрөнгө оруулалтын сан байгуулна.
- 3.1.3.9. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системийн цогц шинэчлэлийг хэрэгжүүлж, олон улсын стандарт бүхий нэгдсэн шийдлийг зах зээлд нэвтрүүлнэ.
- 3.1.3.10. Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагаанд шударга өрсөлдөөнийг бий болгож, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бүрдүүлнэ.

3.2. Бизнес, хөрөнгө оруулалтын орчин

3.2.1. Татвар, нийгмийн даатгалын реформ

- 3.2.1.1. Татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах зарчим баримталж, бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 3.2.1.2. Татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулна.
- 3.2.1.3. Жижиг, дунд болон гарааны бизнес эрхлэгчдийн татварын дэмжлэгийг оновчтой болгож, татварын орчныг сайжруулна.
- 3.2.1.4. Бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална.
- 3.2.1.5. Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийг үргэлжлүүлэн ажил олгогч, даатгуулагчид харилцан өгөөжтэй байх эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлнэ.
- 3.2.1.6. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөдөлмөрийн хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл ногдуулахдаа уян хатан, хөнгөлөлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2.1.7. Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн импортыг дэмжих татварын таатай орчин бүрдүүлнэ.

3.2.2. Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин

- 3.2.2.1. Иргэн, хуулийн этгээдийн хувийн өмчийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулна.
- 3.2.2.2. Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа багц хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнес эрхлэгчийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

- 3.2.2.3. Шинэ аж ахуйн нэгжүүдийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг саад хоригийг арилгаж, стартап компаниудын гарааны бизнесийг дэмжих эко системийг бүрдүүлэх, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, монополын эсрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.2.2.4. Төрийн байгууллагуудаас зөвшөөрөл олгох үйл ажиллагааг бүрэн цахим цахимжуулж, “Зөвшөөрөл 2.0”-г эхлүүлнэ.
- 3.2.2.5. Өндөр мэдлэг, ур чадвар бүхий нарийн мэргэжлийн ажиллах хүч болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах зорилгоор гадаадаас авах ажиллах хүчний тоонд тавих хязгаарлалтыг уян хатан болгох, төлбөрөөс бүрэн чөлөөлөх бодлого баримтална.
- 3.2.2.6. Арилжаа, бизнес эрхлэгчдийн хоорондын маргааныг шүүхийн бус журмаар шуурхай шийдвэрлэх эрх зүйн тогтолцоог сайжруулна.
- 3.2.2.7. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, компани, шударга өрсөлдөөн, монопол, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 3.2.2.8. Татварын өр хураах, хөрөнгө битүүмжлэх үйл ажиллагааг татвар төлөгчийн үйл ажиллагааны эрсдэлийн түвшингээс хамаарч уян хатан зохицуулдаг болж хариуцлагатай татвар төлөгчийг дэмжинэ.
- 3.2.2.9. Арилжааны хуулийг баталж, бизнес эрхлэгчдийн ашгийн төлөөх зорилгыг дэмжих, бизнесийн харилцааны шуурхай байдлыг сайжруулах, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2.2.10. Худалдааны хуулийг баталж, Дэлхийн худалдааны байгууллагын хэлэлцээрээр Монгол Улсад олгогдсон боломжийг бүрэн ашиглаж дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, гадаад худалдаанд үүсэх эрсдэл, саад тотгорыг бууруулна.
- 3.2.2.11. Бүсүүдийн тэргүүлэх чиглэл, онцлог, нөөц, байршлын давуу талд тулгуурлан эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, одоо байгаа татварын хөнгөлөлт бүхий чөлөөт бүсүүдийг бүрэн ашиглалтад оруулна.
- 3.2.2.12. Чөлөөт бүсүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн болон нарийвчилсан төлөвлөгөөнүүдэд тодотгол хийж, дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар хийж, чөлөөт бүсийн хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ.
- 3.2.2.13. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулж, бизнес дэх байгаль орчны үнэлгээний ангиллыг цөөрүүлж, төрийн оролцоог бууруулна.

3.3. Эдийн засгийн төрөлжилт, либералчлал

3.3.1. Уул уурхай

- 3.3.1.1. Боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй дэмжиж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.
- 3.3.1.2. Геологийн эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ.
- 3.3.1.3. Оюутолгойн түшиглэж алт, зэс боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлнэ.

- 3.3.1.4. Оюутолгойтой дүйцэхүйц дараагийн стратегийн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
- 3.3.1.5. Түүхий эд, бүтээгдэхүүнийг анхан шатнаас гүн боловсруулах Кокс-химийн цогцолбор, Нүүрс-Химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Жоншны хүдэр боловсруулах цогцолбор, Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулна.
- 3.3.1.6. Газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшийг дотоодоосоо хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.3.1.7. Уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 3.3.1.8. Газрын ховор элемент боловсруулах үйлдвэрийн төслүүдийг бодлогоор дэмжинэ.
- 3.3.1.9. Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.
- 3.3.1.10. Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна.
- 3.3.1.11. Алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барина.
- 3.3.1.12. Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулна.
- 3.3.1.13. “Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.1.14. Зөөвч-Овоо, Дулаан уулын ураны ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна.

3.3.2. Боомтын шинэчлэл, тээвэр логистик

- 3.3.2.1. Боомтын шинэчлэлийг үргэлжлүүлж, боомтын үйл ажиллагааг цахимжуулах замаар “Ухаалаг гарц”-ыг бүрэн ашиглалтад оруулна.
- 3.3.2.2. Хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100.0 сая тоннд хүргэнэ.
- 3.3.2.3. “Гашуунсухайт-Ганцмод”, “Ханги-Мандал”, “Бичигт-Зүүнхатавч” хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина.
- 3.3.2.4. Идэвхтэй ажиллагаатай боомтын тоог нэмэгдүүлж, ажлын цагийг уртасган, зарим боомтын тээвэрлэлтийг 24 цагийн горимд шилжүүлнэ.
- 3.3.2.5. Тээврийн ерөнхий хууль, зам тээврийн салбарын стратеги төлөвлөлтийг далайд гарцгүй орны онцлог болон бүсчилсэн хөгжлийн төлөвлөлттэй нийцүүлэн боловсруулж, үндэсний тээвэр логистикийн нэгдсэн тогтолцоог хөгжүүлнэ.
- 3.3.2.6. Зам, тээврийн салбарт дэвшилтэт техник технологи, инновац, дижитал шилжилтийг нэвтрүүлж, тээвэрлэлтийн аюулгүй, найдвартай байдлыг хангасан тээврийн мэдээллийн нэгдсэн цахим систем хөгжүүлнэ.

- 3.3.2.7. Ханги-Номгон-Хөшигийн хөндий-Сүхбаатар чиглэлийн хоёр дахь төмөр зам, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр зам болон Улаанбаатар-Шинэ Хархорум хот чиглэлийн ачаа, зорчигч тээврийн 1 дүгээр зэрэглэлийн төмөр зам барьж, төмөр замын сүлжээг өргөтгөж, 3,200 км орчим төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
- 3.3.2.8. Нарансэвстэйн боомтыг сэргээж, нээнэ.
- 3.3.2.9. Улаанбаатар хотыг Шивээхүрэн боомттой холбосон автозамын төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.2.10. Аялал жуулчлалын гол замуудыг хатуу хучилттай авто замаар холбоно.
- 3.3.2.11. Орон нутгийн нисэх буудлуудыг 4C, 4D ангиллын шаардлагад нийцүүлэн өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.
- 3.3.2.12. Авто замын засвар арчлалтын компаниудын үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн шинэчилж, засвар арчлалтад шаардагдах хөрөнгийг төвлөрүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгож, авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангана.
- 3.3.2.13. Төмөр замын тээврийн үнэ, тарифыг зах зээлийн зарчимд нийцүүлнэ.
- 3.3.2.14. Агаарын тээврийн салбарын либералчлалыг үргэлжлүүлж, нислэгийн тоо, давтамжийг нэмэгдүүлнэ.
- 3.3.2.15. Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Чойбалсан-Бичигт чиглэлийн төмөр замын төслийг үргэлжлүүлнэ.
- 3.3.2.16. Замын-Үүд-Алтанбулаг болон Улаанбаатар-Мандалговь-Даланзадгад чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөж, Хөшигийн хөндий-Чойр-Замын-Үүд чиглэлийн 2 эгнээ тусгай зориулалтын авто зам, Улаанбаатар-Лүн чиглэлийн 6 эгнээ авто замын төслийг эхлүүлж, Чойр-Мандалговь-Арвайхээр чиглэлийн авто замыг бүрэн ашиглалтад оруулна.
- 3.3.2.17. “Сайншанд-Баруун-Урт-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.2.18. Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал боомтуудын хил дамнасан төмөр замуудыг барьж хөрш орны төмөр замтай холбоно.
- 3.3.2.19. Хавиргын хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбож, Сүмбэр хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.
- 3.3.2.20. Бичигт-Зүүнхатавч боомтын хил дамнасан төмөр замыг барьж хөрш орны төмөр замтай холбоно.
- 3.3.2.21. Бичигт боомтыг холбох авто замын төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.2.22. Бүсүүдийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, тээвэр логиستيкийн сүлжээг сайжруулах, улсын болон орон нутгийн чанартай авто зам, төмөр замын дэд бүтцийг бүтээн байгуулж, боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.
- 3.3.2.23. Бүсүүдийн хөгжлийг дэмжих, олон улсын авто замын шинэ коридор байгуулах, хилийн боомтууд болон аймгийн төв, сумдыг холбох “Шинэ сэргэлтийн таван тойрог” авто замын төслийг хэрэгжүүлж, олон улсын, улсын болон орон нутгийн чанартай хатуу хучилттай авто замын сүлжээг өргөжүүлнэ.

3.3.3. Эрчим хүчний салбарын өсөлт, либералчлал

- 3.3.3.1. Эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээлийн зарчимд шилжүүлж, үнэ тарифыг зохистой түвшинд хүргэн, цаашид тогтмол индексжүүлэх механизмыг нэвтрүүлж, салбарын эрх зүйн орчныг шинэчилнэ.
- 3.3.3.2. Утаа багатай түлшний стандартыг мөрдүүлж, шахмал түлшний зах зээлийг либералчилж, үнийг үе шаттай чөлөөлнө.
- 3.3.3.3. Урсгал зардал өндөртэй нийгмийн үйлчилгээний байгууллагуудад эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлнэ.
- 3.3.3.4. Иргэн, аж ахуй нэгж сэргээгдэх эрчим хүчийг жижиг, дунд төхөөрөмжөөр үйлдвэрлэж хэрэглэх, хэрэгцээнээс давсан хэсгийг түгээх сүлжээнд нийлүүлэх, худалдах боломжоор хангана.
- 3.3.3.5. Дэд станц, шугам сүлжээг өргөтгөж, ухаалаг удирдлагын систем нэвтрүүлэн, шугамын алдагдлыг бууруулна.
- 3.3.3.6. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үйлдвэрлэлийн өртгийг бууруулна.
- 3.3.3.7. Ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж, суурь судалгааг хийнэ.
- 3.3.3.8. Газрын дунд, гүн болон хөрсний дулаан хангамжийн төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.3.9. Нарны дулааны станц бүхий хэсэгчилсэн дулаан хангамжийн жишиг төслийг эхлүүлнэ.
- 3.3.3.10. Өндөр түрэлтийн болон ус хуримтлуурт усан цахилгаан станцын төслүүдийн суурь судалгааны ажлыг хийнэ.
- 3.3.3.11. Шинээр барьж байгуулах нар, салхины эх үүсвэрийн төслүүдтэй уялдуулан 200 МВт-аас дээш хүчин чадалтай горим тохируулгын батарей хуримтлуурын системүүдийг барьж байгуулна.
- 3.3.3.12. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар системийн суурь горимд ажиллах дулааны цахилгаан станцын төслүүдэд дэмжлэг үзүүлж, хэрэгжүүлнэ. /Тосонцэнгэлийн 30 МВт, Төв аймгийн Баян суманд баригдах 660 МВт, нүүрсний хийн 300 МВт, Сүхбаатарын 70 МВт, Бөөрөлжүүтийн хоёрдугаар үе шат 300 МВт, Шивээ-Овоо 200 МВт/
- 3.3.3.13. Ус хуримтлуурт усан цахилгаан станц болон дотоодын урсгалтай голуудад усан цахилгаан станц барих төслүүдэд дэмжлэг үзүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.
- 3.3.3.14. Эрчим хүчний аюулгүй байдал, чухал ашигт малтмалын салбарт Монгол Улсын байр суурь, оролцоо, хамтран ажиллах хоёр болон гурван талт механизмыг хөгжүүлнэ.
- 3.3.3.15. Төвлөрсөн дулаан хангамжийн системгүй аймгийн төвүүдэд дулааны станц барина.
- 3.3.3.16. 300 МВт хүртэлх салхи, 200 МВт хүртэлх нарны цахилгаан станцын төслүүдийг тархмал хэлбэрээр, хувийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 3.3.3.17. Эрчим хүчний хэрэглээний хамгийн бага гүйцэтгэлийн стандарт, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 3.3.3.18. Цахилгаан эрчим хүчнээс үүдэлтэй ойн хээрийн түймэр, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болно.

- 3.3.3.19. Эрчим хүчний тогтворжилтыг хангах, сэргээгдэх эрчим хүчийг зөв, зохистой хөгжүүлэх үндсэн баримт бичиг болох нэгдсэн сүлжээний дүрэм, менежментийн тогтолцоог бий болно.
- 3.3.3.20. Байдрагийн усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.3.21. Баруун бүсийн цахилгаан эрчим хүчний нэгдсэн системийг бүрдүүлэх усан цахилгаан станц болон бусад сэргээгдэх эрчим хүчний тархмал эх үүсвэрийг хөгжүүлнэ.
- 3.3.3.22. Тавантолгойн 450 МВт-ын дулааны цахилгаан станц барина.
- 3.3.3.23. Эрчим хүчний найдвартай, аюулгүй, тогтвортой байдлыг хангах, говийн бүсэд эхний ээлжид 300 МВт болон түүнээс дээш хүчин чадалтай цахилгаан станц барьж, ашиглалтад оруулан дотоодын хэрэгцээг бүрэн хангана.
- 3.3.3.24. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт нар, салхины нөөцийн давхцалын бүсүүдийг түшиглэн 3 ГВт-ын нар, салхины сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг барьж байгуулах, экспортлох төслүүдийг дэмжинэ.
- 3.3.3.25. Чойрт 100 МВт салхи, 40 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.3.26. Мандалговь 200 МВт нарны цахилгаан станц, 100 МВт цэнэг хураагуурын төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.3.27. Нарийнсухайт 30 МВт цахилгаан станц төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.3.28. Говьсүмбэр, Дундговь аймгийн төвүүдэд шинэ дулааны станц барина.
- 3.3.3.29. Говийн бүсийн нар, салхины нөөцийг ашиглан, нар, салхины сэргээгдэх эрчим хүчний станцуудыг байгуулна.
- 3.3.3.30. Багануур-Чойр чиглэлийн 220 кВ, Чойр-Сайншанд чиглэлийн 220 кВ, Мандалговь-Арвайхээр чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, Сайншанд-Цагаансуварга чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын төслийн бэлтгэл ажлыг хангана.
- 3.3.3.31. Мандалговийн 2,000 Мвт нар-салхины эрчим хүчний паркийн төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.3.32. Сэлэнгэ аймгийн төвд 70 МВт-ын дулааны цахилгаан станцыг барих хувийн хэвшлийг дэмжинэ.
- 3.3.3.33. Бөөрөлжүүт-Сэргэлэн чиглэлийн 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барина.
- 3.3.3.34. Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд ажиллах 100 МВт-ын ус хуримтлуурт усан цахилгаан станцын төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.
- 3.3.3.35. Дархан УХУЦС 100 МВт төслийг хэрэгжүүлнэ.
- 3.3.3.36. Нэгдсэн сүлжээний горим тохируулах үүрэг бүхий 100 МВт хүртэл хүчин чадал бүхий усан цэнэгт цахилгаан станц барина.
- 3.3.3.37. Бүсүүдийг холбох өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцуудыг барих төслийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангана. /Багануур-Налайх-Улаанбаатар, Чойр-Мандалговь, Сонгино-Дархан, Тавантолгойн ДЦС-Оюутолгой, Багануур-Чингис-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын, Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн 500 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам/
- 3.3.3.38. Аймгийн төвүүд, сум суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах, үр ашиг өндөртэй нүүрс, сэргээгдэх эрчим хүчний технологийг ашигласан станцуудыг байгуулах суурь судалгааг хийх, төслүүдийг эхлүүлнэ.

- 3.3.3.39. Аймгуудын төв болон сум суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах, үр ашиг өндөртэй нүүрс, сэргээгдэх эрчим хүч технологийг ашигласан станцуудыг байгуулах суурь судалгааг хийж, төслүүдийг эхлүүлнэ.
- 3.3.3.40. Цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох реформ хийнэ.
- 3.3.3.41. Төрийн байгууллагуудын эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг нь харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх бодлогын хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг холбогдох харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлнэ.

3.3.4. Хөдөө аж ахуй-Шинэ хоршоо хөдөлгөөн, Чинээлэг малчин хөтөлбөр

- 3.3.4.1. “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ийг үргэлжлүүлж, “Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.3.4.2. “Хүнсний хангамж аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангаж, экспортод гаргах чиглэл баримтална.
- 3.3.4.3. Малын гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх дундын хоршоог сумдаар бүсчлэн байгуулна.
- 3.3.4.4. Ноос боловсруулах үйлдвэрийг сэргээж, ноосон эдлэл, бүтээгдэхүүн, ялангуяа шинэ бүтээгдэхүүн болох ноосон бордоо, ноосоор хийсэн барилгын дулаалга бүтээгдэхүүнийг экспортлоход анхаарна.
- 3.3.4.5. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах иж бүрэн механикжсан агуулахын нэгдсэн цогцолборыг байгуулна.
- 3.3.4.6. Малчдад өвөлжөө, хаваржааны газрыг урт хугацаатай эзэмших, ашиглах, тэжээлийн ургамал тариалах боломжийг олгох эрх зүйн орчныг бий болгоно.
- 3.3.4.7. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 3.3.4.8. Байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулна.
- 3.3.4.9. Олон улсын стандартад нийцсэн малын вакциныг дотооддоо үйлдвэрлэж, мал эмнэлгийн лабораторийн чадавхыг сайжруулна.
- 3.3.4.10. Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт малын эзлэх хувийг нэмэгдүүлж, малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.
- 3.3.4.11. Орон нутгийн онцлогт тохирсон үржлийн цөм сүрэг бий болгох ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй, хүртээмжтэй зохион байгуулж, үржлийн аж ахуйг бүсүүдэд байгуулахыг дэмжинэ.
- 3.3.4.12. Хүн амын өсөн нэмэгдэж буй хүнсний хэрэгцээг хангах зорилгоор “Атар IV” аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн нийт эргэлтийн талбайг 200 мянган га-гаар нэмэгдүүлнэ.
- 3.3.4.13. “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд малын гаралтай түүхий эдийн инновац шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ.

- 3.3.4.14. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүнийг хаягдалгүй боловсруулж, уургийн агууламж өндөртэй түүхий эд бэлтгэх, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлд хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 3.3.4.15. Экспортын түүхий махны мал эмнэлэг, хорио цээрийн олон улсын шаардлагыг хангасан “Монгол мах” брэндийг хөгжүүлж, махны үнийг зах зээлийн зарчимд шилжүүлнэ.
- 3.3.4.16. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, хорио цээрийн олон улсын стандартыг нутагшуулж, гадаад худалдааны хориг, хязгаарлалтыг арилгаж, сүү, цагаан идээ, мах, ноолуур, арьс ширийг дотоод, гадаадын зах зээлд борлуулах боломжийг бүрдүүлнэ.
- 3.3.4.17. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийн мөшгөлт, чанарын хяналтыг сайжруулж, биржээр дамжуулан экспортолно.
- 3.3.4.18. Стратегийн хүнсний хангамж, нөөцийн тогтвортой байдлыг бэхжүүлнэ.
- 3.3.4.19. Өвлийн хүлэмжийн агро паркийн цогцолборыг 50 га талбайд байгуулж, хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор бүрэн хангана.
- 3.3.4.20. Бэлчээрийг нөхөн сэргээх, сэлгэх, тарималжуулах, хамгаалах, усжуулах, ургамал хамгааллыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.3.4.21. Тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалан сайжруулж, усалгаатай газар тариаланг нэмэгдүүлэх хөв цөөрөм байгуулна.
- 3.3.4.22. Чанар стандартын шаардлага хангасан бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
- 3.3.4.23. Арьс ширний үйлдвэрийн бүсүүдэд дундын хаягдал ус цэвэрлэх байгууламж байгуулна.
- 3.3.4.24. Итгэмжлэгдсэн лабораториудыг лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоонд нэгтгэн, мэдээллийн нэгдсэн санг бий болгож, лабораторийн хүний нөөцийг чадавхжуулж, хүчин чадлыг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн лабораторийг хөгжүүлнэ.
- 3.3.4.25. Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд олон улсын стандартад нийцсэн арга зүйг нэвтрүүлэн, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг сайжруулна.
- 3.3.4.26. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.
- 3.3.4.27. Биокомбинат ТӨХК-ийн өргөтгөл, шинэчлэлийг эхлүүлж, олон улсын стандартад нийцсэн малын халдварт, гоц халдварт өвчний вакциныг үйлдвэрлэнэ.
- 3.3.4.28. Малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлж, өндөр ашиг шимт үхэр сүргийн тоо толгойг нэмэгдүүлж 200 мянгад хүргэнэ.

3.3.5. Дөрвөн улирлын аялал жуулчлал

- 3.3.5.1. “Go Mongolia” арга хэмжээг үргэлжлүүлж, гадаад жуулчдын тоог жилд 2 саяд хүргэнэ.
- 3.3.5.2. Аялал жуулчлалын томоохон парк, цогцолборыг бүсчилсэн хөгжлийн хүрээнд байгуулж, шашин, соёл, спорт, адал явдалт аялал зэрэг дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 3.3.5.3. Монгол орны онцлог, өв уламжлалыг дэлхийд сурталчилна.
- 3.3.5.4. Аялал жуулчлалын салбарын стандарт, үйлчилгээний чанар, визний шаардлагыг хөнгөвчилнэ.

- 3.3.5.5. Түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулж, жуулчдын нэвтрэх урсгалыг нэмэгдүүлнэ.
- 3.3.5.6. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдааны сувгуудаар дэмжинэ.
- 3.3.5.7. Аялал жуулчлалын гол зам дагуу амрах өртөө, түр отоглох цэг, зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулна.
- 3.3.5.8. Монголын нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, брэндийг хөгжүүлж, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт нийцүүлнэ.
- 3.3.5.9. Бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан соёлын орон зай, хүртээмжийг нэмэгдүүлж, өөрийн орны иргэд, гадаадын жуулчдад үзүүлэх, борлуулах нөөцтэй болно.
- 3.3.5.10. Говийн бүсийн марс гарагт төсөөтэй онцлогийг шинжлэх ухаан, инновац шингэсэн технологиор баяжуулж, байгаль орчинд ээлтэй дөрвөн улирлын тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 3.3.5.11. Үндэсний болон олон улсын спортын арга хэмжээг зохион байгуулах, дэмжих замаар аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

3.3.6. Соёлын бүтээлч үйлдвэрлэл

- 3.3.6.1. Үндэсний соёлын өвийн баялаг байдлыг олон талт агуулгаар баяжуулж, дэлхий дахинд сурталчлан таниулна.
- 3.3.6.2. Монгол үндэстний бахархал, өв соёл, нүүдлийн соёлыг дэлхийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн түүх, орчин цагийг хослуулах замаар шинэ үеийн монгол бахархал бий болгоно.
- 3.3.6.3. Төр-иргэний хамтын ажиллагааны түншлэлд үндэслэн соёлын өвийн эх төрх, бүрэн бүтэн байдал, оршин тогтнох чадварыг хамгаалан хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг дээшлүүлнэ.
- 3.3.6.4. Үндэсний түүхэн болон уран барилгын дурсгалуудыг сэргээн шинэчилж, “Соёлын өвийг сэргээн засварлах хөтөлбөр” хэрэгжүүлнэ.
- 3.3.6.5. Соёлын биет болон биет бус өвийг эдийн засгийн эргэлтэд оруулах хатуу, зөөлөн дэд бүтэц, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.3.6.6. Төв Азийн нүүдэлчдийн соёлын их наадмыг ЮНЕСКО-той хамтран зохион байгуулна.
- 3.3.6.7. Гандантэгчэнлин хийд орчмын орон зайг “Далх, Тасганы дэнжийн Үндэсний соёлын өвийн дурсгалт газар” концепцоор хөгжүүлж “Буддын шашны соёлын өвийн цогцолбор” болгоно.
- 3.3.6.8. Богд хааны ордон музейн орчмыг VIII Богд Жавзандамба хутагтын амьдарч ирсэн түүх, соёлд тулгуурлан төрөлжүүлж, хөгжүүлнэ.
- 3.3.6.9. “Кино үйлдвэр” орчмыг “Монгол киноны түүх соёл”-д тулгуурлан төрөлжүүлж, хөгжүүлнэ.
- 3.3.6.10. Үндэсний өв уламжлал, түүх уран зохиол, нүүдлийн ахуй соёлыг шингээсэн хөтөлбөр, уран бүтээл, дижитал контент бүтээгчдийг дэмжиж, соёлын боловсролтой, эерэг хандлагатай, бүтээлч иргэдийг төлөвшүүлнэ.

- 3.3.6.11. Нүүдлийн соёлын онцлог, ялгарлыг дэлхийд таниулах кино, контентыг олон улсын мэргэжлийн агентлагуудтай хамтран бүтээж, сурталчлан, гадаад зах зээл дэх Монгол Улсын талаарх сонирхлыг нэмэгдүүлнэ.
- 3.3.6.12. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг эдийн засгийн бие даасан салбар болгон хөгжүүлнэ.
- 3.3.6.13. “Соёлын бүтээлч үйлдвэрлэл III” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.3.6.14. Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний түгээлтийн цахим шилжилтийн хүрээнд дэвшилтэт технологийг ашиглаж, “Цахим соёл II”, “Соёлын эрхийн бичиг” системийг нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.3.6.15. Соёлын бүтээгдэхүүн, контентыг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, соёл, аялал жуулчлалын салбарыг 1 тэрбум ам.долларын орлого бүхий салбар болгон хөгжүүлнэ.

3.3.7. Шинжлэх ухаан, технологи, инновац

- 3.3.7.1. Шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийн суурийг бэхжүүлнэ.
- 3.3.7.2. Оюуны бүтээлийн үнэлэмжийг нэмэгдүүлж, шинэ бүтээл, оюуны өмч, судалгаа шинжилгээ, шинэ технологийг эдийн засгийн эргэлтэд оруулж, салбаруудын бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.3.7.3. Шинжлэх ухаан, технологийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэл бүхий адилтгах санхүүжилт (Matching fund)-ийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.3.7.4. Мэдээллийн технологи, судалгаа хөгжүүлэлт, инновацын үйл ажиллагаа эрхлэх татварын хөнгөлөлттэй чөлөөт бүс, шинжлэх ухааны паркийг хөгжүүлнэ.
- 3.3.7.5. Мэдээлэл харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг салбарт нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.3.7.6. Инновацын хөрөнгө оруулалтын сан, технологийн парк байгуулан шинжлэх ухаан, хиймэл оюун ухаан, дижитал бизнес, ногоон төсөл, бүтээмжийн зах зээлийг дэмжих гарааны хөрөнгө оруулалт, техникийн туслалцааны инкубатор санг хөгжүүлнэ.
- 3.3.7.7. Эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн санг шинээр бий болгож, дотоодын бүх эрдэм шинжилгээний ажлыг нэг платформоос үзэх боломжийг бүрдүүлнэ.
- 3.3.7.8. Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгааны лабораториудыг шинжлэх ухааны салбараар төрөлжүүлж, салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулан хөгжүүлнэ.

3.4. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт, ногоон санхүүжилт

3.4.1. Биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар нутгийн менежмент

- 3.4.1.1. Байгалийн төрхийг хадгалж, тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөн, хамгаалалтын менежментийг сайжруулна.
- 3.4.1.2. Биологийн олон янз байдлын алдагдлыг зогсоож, генетик нөөцийг нэмэгдүүлэн тогтвортой ашиглаж, байгалийн нөөцийг хамгаалж экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоон, биоаюулгүй байдлыг хангана.

- 3.4.1.3. Байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлж, байгаль хамгааллын тогтвортой санхүүжилтийн механизмыг бүрдүүлнэ.
- 3.4.1.4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нийт газар нутгийн 8.8 хувьд хүргэнэ.
- 3.4.1.5. Ойн хөнөөлт шавжтай тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах менежментийг сайжруулж, ойн хомсдол, доройтлыг бууруулахад ухаалаг, дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
- 3.4.1.6. Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, экосистемийн тэнцвэртэй байдлыг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.4.1.7. Усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, усны үнэ цэн, үнэлэмжийг нэмэгдүүлэн ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг дэмжинэ.

3.4.2. Уур амьсгалын өөрчлөлт

- 3.4.2.1. Хүлэмжийн хийн тайлагналын тогтолцоог бэхжүүлж, нүүрстөрөгчийн кредит тооцох, арилжаанд оролцох нөхцөлийг бүрдүүлэн ногоон санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн салбар дундын зохицуулалтаар хангах эрх зүйн орчныг сайжруулна.
- 3.4.2.2. Уур амьсгалын өөрчлөлтийн олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулах, хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх зах зээлийн болон зах зээлийн бус хэрэгслийг ил тод, байгаль орчны үр нөлөөг тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.4.2.3. Хөдөө аж ахуй, газар тариалангийн бүс нутагт байгальд ээлтэй технологи нэвтрүүлж, нөхөн сэргээх, газар тариалангийн хамгаалалтын зурвасыг нэмэгдүүлэх байгальд түшиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.4.2.4. Говийн болон ус хангамжийн дутагдалтай бүс нутгийн ус хангамжийг нэмэгдүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 3.4.2.5. Усны чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг эрчимжүүлж, экологийн чухал ач холбогдолтой Хөвсгөл нуур, Ганга нуур, Өгий нуур, Хэрлэн гол зэрэг усны сан бүхий газрыг нөхөн сэргээж, хамгаална.
- 3.4.2.6. Байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гарз хохирлын эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхыг бэхжүүлнэ.
- 3.4.2.7. Байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй амьдралын хэв маяг, хандлага, дадлыг хэвшүүлнэ.
- 3.4.2.8. Уул уурхайн нөхөн сэргээлтийн чанар, хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлт хийгээгүй хуулийн этгээдэд ногдуулах хариуцлагыг чангатгана.

3.4.3. Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар

- 3.4.3.1. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын түншлэлд тулгуурласан “Стандарттай байгаль орчны салбар” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.4.3.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын үр дүнд суурилсан, хүрээлэн буй орчин, хүнд ээлтэй орчныг төлөвлөж, нийгэм, эдийн засгийн ногоон хөгжлийн загварыг бий болгоно.

- 3.4.3.3. Орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх, бууруулах, хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.4.3.4. Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 3.4.3.5. Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах туршилтын төсөл хэрэгжүүлнэ.
- 3.4.3.6. Генийн санг хамгаалах, түүнийг баяжуулах биотехнологийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтийг бодлогоор дэмжинэ.
- 3.4.3.7. Тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг нэвтрүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
- 3.4.3.8. Энгийн болон аюултай хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах оновчтой менежментийн тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.4.3.9. Хог хаягдлаас үүдэн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулж, хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагад урамшуулал олгон, татварын бодлогоор дэмжин ажиллана.
- 3.4.3.10. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилгоор эрчим хүч, ус, бохирын хувьд бие даасан, байгальд ээлтэй, зөөврийн орон сууцны технологийн судалгаанд хөрөнгө оруулалт хийнэ.

ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Монгол үндэсний үнэлэмжийг нэмэгдүүлж, эх оронч сэтгэлгээг бий болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гадаад бодлогын нээлттэй олон тулгуурт зарчмыг баримтална.

4.1. Хүний эрх, эрх чөлөө

4.1.1. Хүний эрх

- 4.1.1.1. Иргэний үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэх, эрх мэдэл хуваарилалтын хяналт, тэнцлийг хангуулах чиглэлээр Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг тодотгоно.
- 4.1.1.2. “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний II хөтөлбөр” батлуулж, хэрэгжүүлнэ.
- 4.1.1.3. Иргэний улс төрийн эрх, эрх чөлөөг бүрэн хангах баталгааг бүрдүүлж, жагсаал, цуглаан хийхэд зөвшөөрөл олгох тогтолцоог хална. Жагсаал, цуглааны төрөл, хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрч, уг эрхээ эдэлсний төлөө хууль бусаар мөрдөн хавчигддаг, үндэслэлгүйгээр хууль зүйн хариуцлагад татагддаггүй байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 4.1.1.4. Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, цахим орчин дахь ялгаварлал, хүчирхийллээс хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.
- 4.1.1.5. Жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагыг тус арга хэмжээнд татан оролцуулж үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулна.
- 4.1.1.6. Төрөөс шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон хүний эрхийн зөрчлөөс сэргийлж ажиллана.
- 4.1.1.7. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг баталгаажуулж, шүүхийн шийдвэргүйгээр баривчлах, цагдан хорих, иргэний эрхийг хязгаарлах ажиллагааг зогсоон, хүний эрхийг хамгаалах, процессын шударга ёсыг хангах, мэргэжлийн байлгах чиглэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай, Таслан сэргийлэх ажиллагааны тухай, Шүүхийн шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны тухай хуулиудыг бүрэн процессжуулан хуульчилна.
- 4.1.1.8. Хувь хүний орон байрны халдашгүй байдлыг хамгаалах эрх зүйн орчныг олон улсын сайн жишигт нийцүүлэн сайжруулна.
- 4.1.1.9. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 4.1.1.10. Визийн зөрчилтэй гадаад иргэдийн тоог бууруулж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.
- 4.1.1.11. Ази тивийн хүний эрхийн төвийг Монгол Улсад байгуулна.

- 4.1.1.12. Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргах шийдвэрт тухайн харьяалах нутаг дэвсгэрийн иргэдийн саналыг тусгана.
- 4.1.1.13. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хуулиас давсан зохицуулалт бүхий дүрэм, журмуудад дүн шинжилгээ хийж, цэгцлэх арга хэмжээ авна.
- 4.1.1.14. Орон нутаг дахь цагдан хорих байрнуудыг үе шаттай шинэчлэх, хорих ял эдлүүлэх байрны цогцолборын барилгыг ашиглалтад оруулна.
- 4.1.1.15. Монгол Улсын Үндсэн хууль, хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагын захиалгаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий Хууль судлалын институтыг байгуулна.
- 4.1.1.16. "Эрх зүйн шинэтгэлийн II хөтөлбөр"-ийг батлуулан хэрэгжүүлнэ.
- 4.1.1.17. Үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар хоригдлын ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр ашгийг сайжруулан, улсын төсвийн ачааллыг бууруулна.
- 4.1.1.18. Хорих ял эдлүүлэх орчин, нөхцөлийг сайжруулах зорилгоор "Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага"-ын цогцолбор барилгыг ашиглалтад оруулж хүний эрхийг хангана.
- 4.1.1.19. Прокурорын байгууллагын томилгоо, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах замаар хараат бус байдлыг нэмэгдүүлнэ.
- 4.1.1.20. Иргэний боловсролыг дэмжих хүрээнд хувь хүний эрх чөлөө, ардчилал, чөлөөт эдийн засаг, хуулийн засаглал, Үндсэн хуулийн байгуулалтын ач холбогдлыг таниулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.1.2. Хэвлэлийн эрх чөлөө

- 4.1.2.1. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт, хараат бус, бие даасан байдлыг хангах, тэдгээрийн редакцыг эздийн нөлөөллөөс гаргах, сэтгүүлчийн хэвлэн нийтлэх эрх чөлөө болон мэргэжлийн ёс зүй, хариуцлагатай ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

4.1.3. Иргэний нийгэм, хувийн хэвшил, төрийн түншлэл, хамтын ажиллагаа

- 4.1.3.1. Иргэний нийгэм, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, оролцоо, санаачилгыг дэмжих бодлогыг баримтлах бөгөөд төрийн зарим чиг үүргийг иргэний нийгэм, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.
- 4.1.3.2. Улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд гурван талт болон олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ.
- 4.1.3.3. Нийгмийн зөвшилцөлд үндэслэн шийдвэр гаргах түвшинд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшилтэй зөвлөлдөх, санал авах, гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавихад оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.

4.1.4. Ил тод байдал ба хяналт

- 4.1.4.1. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 4.1.4.2. Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх, төрийн өмчийн бүртгэл ашиглалт, үр өгөөж, хяналтыг сайжруулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг шинэчилнэ.

4.1.5. Парламентын засаглал ба эрх мэдлийн хяналт, тэнцэл

- 4.1.5.1. Улс орны хөгжлийн амин чухал асуудлаар үндэсний зөвшилцөлд хүрч, төрийн залгамж чанар, бодлогын тогтвортой байдлыг хангах бөгөөд улс төрийн намуудыг нийтийн эрх ашгийн төлөө үйлчилдэг бодлогын институт болгох эрх зүйн орчныг бүрдүүлж, хатуу гишүүнчлэлээс татгалзаж, санхүүжилтийг ил тод болгоно.
- 4.1.5.2. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ.

4.1.6. Шүүх засаглал

- 4.1.6.1. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нээлттэй, шуурхай, үр дүнтэй, хариуцлагатай болгоно.
- 4.1.6.2. Шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчныг сайжруулах, хараат бус, бие даасан байдлын баталгааг нэмэгдүүлж, шүүгчийн мэргэжлийн ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлнэ.
- 4.1.6.3. Шүүхийн процессыг цахимжуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг ил тод болгож, хэрэг, маргааныг түргэн шуурхай, үр дүнтэй, шийдвэрлэнэ.
- 4.1.6.4. Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг олон улсын сайн жишигт хүргэнэ.
- 4.1.6.5. Хуульчдын холбоог шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн холбоо болон бусад хуульчдын холбооны гишүүнчлэлтэй, гишүүддээ үйлчилдэг мэргэжлийн холбоо байхаар өөрчлөн зохион байгуулна.
- 4.1.6.6. Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шинэ төрлийн шинжилгээний чанар, үр дүнг олон улсын жишигт хүргэж, шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.

4.2. Авлигагүй засаглал

4.2.1. Авлига, гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагаа

Авлигатай тэмцэх ажиллагаа

- 4.2.1.1. Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлнэ.
- 4.2.1.2. Төрийн өндөр албан тушаалтны зарлага, орлогын албан татвар төлөлтийг ил болгох, хянах тогтолцоог бүрдүүлнэ.
- 4.2.1.3. Авлига, ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх тогтолцоог хялбаршуулах, энэ төрлийн гэмт хэргийн эсрэг шүгэл үлээгчийг хамгаалах, дэмжих хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 4.2.1.4. Авлигаас олсон орлогыг хураан авч, тухайн орлогыг гэмт хэргийн хохирлыг барагдуулах, хууль сахиулах байгууллагын чадавхыг нэмэгдүүлэх болон нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 4.2.1.5. Улс төрийн хүрээнд авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлт, манлайлал, ил тод байдлыг төгөлдөршүүлж, улс төрийн намын санхүүжилтийн талаарх эрх зүйн зохицуулалтыг сайжруулна.
- 4.2.1.6. Олон нийтийг авлигаас ангид байлгах, шударга ёсыг шаардах, авлигыг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг иргэн бүрд төлөвшүүлэхийг эрмэлзэх бөгөөд авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага нэхэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.2.1.7. Авлигажих, хүнд суртал, дур зорго үүсэх, хүний эрхэд халдах шалтгаан, нөхцөлийг бүрдүүлж байгаа журам батлах эрх олгосон хуулийн зохицуулалтаас татгалзана.

Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаа

- 4.2.1.8. Улс дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөх албыг байгуулан мэргэшүүлж, гадаад хамтын ажиллагааг сайжруулна.
- 4.2.1.9. Цахимаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэгтэй тэмцэх албаны чадавхыг дээшлүүлж, иргэдийг энэ төрлийн гэмт хэрэг, гэмт халдлагаас хамгаална.
- 4.2.1.10. Төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйлдлээс хохирсон иргэд, бизнес эрхлэгчдийн хохирлыг барагдуулах механизмыг бүрдүүлнэ.
- 4.2.1.11. Ялын бодлогыг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах, ялтныг хөдөлмөрлөх нөхцөлөөр хангаж, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирол барагдуулалтыг нэмэгдүүлэх, ялтныг нийгэмшүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 4.2.1.12. Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор камерын нэгдсэн системийг суурьшлын бүсийн 80 хувьд хүргэнэ.
- 4.2.1.13. Нууц мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд авагдсан мэдээ, баримтыг процессын төгсгөлд шүүхэд, эсвэл тус ажиллагаанд өртсөн иргэнд хүргүүлэх механизмыг хуульчилна.
- 4.2.1.14. Гэрч, хохирогчийг хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажилгааны эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах алба шинээр байгуулж, хохирогчийн эрхийг хангах, хохирол барагдуулах үйл ажиллагааг шинэ шатанд гаргана.

- 4.2.1.15. Гүйцэтгэх ажлын тухай хуулийг хүчингүй болгож, тагнуулын үйл ажиллагааг тусдаа хуулиар, нууц мөрдөн шалгах ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон Хууль сахиулах ажиллагааны тухай хуулиар зохицуулж, шүүхийн хяналтад оруулна.
- 4.2.1.16. Иргэдийг чадавхжуулах, гамшиг, аюулаас сэргийлэх сургалт, авран хамгаалах зохион байгуулалтыг дэмжин ажиллах, орон нутгийн хамгаалалт, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах болон үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхид дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий үндэсний тогтолцоо бий болгоно.

4.2.2. Дэвшилтэт технологид суурилсан цахим засаглал

- 4.2.2.1. Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөн үе шаттай байхаар дахин инженерчлэл хийж, төрийн үйлчилгээг иргэнд шуурхай, чирэгдэлгүй хүргэнэ.
- 4.2.2.2. Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх цахим төрийн тогтолцоонд шилжинэ.
- 4.2.2.3. Төр хувийн хэвшил, иргэний нийгэмтэй хамтран ажиллахыг эрэлхийлдэг, тэдгээрийн оролцоог шийдвэр гаргах үйл явцдаа хангаж, ил тод байдлыг бий болгосон төрийн шинэ тогтолцоог бий болгоно.
- 4.2.2.4. Төрийн тогтолцооны цахим дэд бүтцийг хөгжүүлж, шийдвэр гаргах үйл явцыг мэдэгдэхүйц хурдан, ил тод, нээлттэй болгоно.
- 4.2.2.5. Төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, зөвшөөрлийн тогтолцоог шинэчилж, бүрэн цахимжуулан төрийн захиргааны үйл ажиллагааг идэвхжүүлэх ба төрийн албан хаагчдыг тогтмол чадавхжуулна.

4.2.3. Төрийн албаны реформ

- 4.2.3.1. Чадварлаг, цомхон, чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх улмаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албаны бүтэц, зохион байгуулалт, төрийн байгууллагын чиг үүрэг, үйлчилгээний төрлийг оновчилж, төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний менежментийг сайжруулан төрийн захиргааны албан хаагчдын тоог зохистой хэмжээнд хүргэнэ.
- 4.2.3.2. Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний цогц систем (DME-Design, Monitoring Evaluation)-ийг хөгжүүлж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үнэлгээг боловсронгуй болгоно.
- 4.2.3.3. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг үргэлжлүүлэн төрд байгаа мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг бүрэн халах, иргэн, хуулийн этгээд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.2.3.4. Даргын эрх мэдлийг баталгаажуулсан байгууллагын хуулийг халж, иргэнд үйлчлэх албаны хууль болгоно.
- 4.2.3.5. Төрийн албанд ёс зүйн төлөвшлийг бэхжүүлж ёс зүйн зөрчлийг үл тэвчих сэтгэлгээг бий болгох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагад хэрэгжүүлэх, төрийн албаны чадамжид суурилсан хүний нөөцийн бодлогын

хэрэгжилтэд ёс зүйн хэм хэмжээ, шалгуур үзүүлэлтийг суурь болгон оруулна.

- 4.2.3.6. Төрийн албан хаагчийг улс төрчийн болон удирдлагын хууль бус шийдвэр, аливаа дарамт шахалтаас ангид байлгах, эвлэлдэн нэгдэж, эрх ашгаа хамтран хамгаалах боломжийг бүрдүүлж, тогтвортой ажиллах нөхцөлөөр хангана.
- 4.2.3.7. Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог сайжруулж, Төрийн албанд таваас дээш жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн гурван жилд нь “маш сайн” үнэлэгдсэн төрийн албан хаагчийг “1+2” буюу гадаадад хэлний болон ахисан түвшний сургалтад хамруулах бодлого баримтална.
- 4.2.3.8. Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 4.2.3.9. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтлан орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ. Төрийн албанаас эрт тэтгэвэрт гарч буй иргэд хөдөлмөр эрхлэх, жижиг, дунд, бичил бизнесийн салбарт ажиллах, орлого олох, баялаг бүтээх боломжийг бүрдүүлнэ.
- 4.2.3.10. Төрийн албан хаагчдын цахим мэдээллийг өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулна.
- 4.2.3.11. Төрийн албан хаагчдын цахим мэдээллийг өөрт нь нээлттэй болгох замаар төрийн албан хаагчийн иж бүрэн цахим платформыг хөгжүүлж, мэдээллийн үнэн зөв, бүрэн гүйцэд байдлыг сайжруулна.

4.2.4. Орон нутгийн засаглалын бие даасан байдал

- 4.2.4.1. Шинээр байгуулсан хотын ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг оршин суугч, хувийн хэвшлийн саналыг харгалзан боловсруулан батлуулж, түүнтэй уялдсан төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.4.2. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд хотын Зөвлөл, Захирагчийн сонгуулийг цахимаар явуулж, оршин суугчдаас шууд сонгох эрх зүйн орчныг бүрдүүлж, шинээр байгуулсан хотуудыг зохион байгуулна.
- 4.2.4.3. Хот байгуулалтын болон газрын багц хуулийг шинэчлэн баталж, Ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана.

4.3. Цахим засаглал, төрийн бүтээмжийн дахин инженерчлэл

4.3.1. “E-Mongolia”-блок чейн-Цахим засаглал

- 4.3.1.1. Төрийн бүх үйлчилгээг хиймэл юуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий “Ухаалаг E-Mongolia” системийг хөгжүүлнэ.
- 4.3.1.2. Үндэсний баялгийн сангийн нэгээс доошгүй хувийг инновац, технологийн салбарт зориулж, эдийн засгийн салбаруудын бүтээмж, экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.

- 4.3.1.3. Мэдээлэл харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг бүх салбарт өргөнөөр нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.3.1.4. Төрөөс иргэн, бизнест үзүүлж байгаа үйлчилгээнүүдэд процессын шинжилгээ хийж бүрэн цахимжуулах, хиймэл оюун ухаан ашиглах, автоматжуулах боломжийг тодорхойлж, үйлчилгээ авах хугацаа болон үе шатыг 2 дахин бууруулна.
- 4.3.1.5. Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг “блокчейн” технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

4.3.2. Сансар судлал, харилцаа холбоо, мэдээлэл технологи

- 4.3.2.1. Үндэсний хиймэл дагуул хөөргөж, нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжинэ.
- 4.3.2.2. Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг тэлэн орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг хүртээмжтэй болгож, интернэтийн орон нутгийн тарифыг эрс бууруулж, Улаанбаатар хотын тарифтай ойртуулж төрийн үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай авах боломжийг бүрдүүлнэ.
- 4.3.2.3. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих татварын хөнгөлөлттэй виртуал бүсийг байгуулж, “венч” зэрэг хөрөнгө оруулалтын тогтолцоог хөгжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийтийн мэдээллийн системүүдийг хөгжүүлнэ.
- 4.3.2.4. Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, үүлэн тооцоолуур, “блокчейн”, IoT-ийг төрийн үйл ажиллагаа, үйлчилгээнд хэрэглэж болох чиглэлүүдийг тодорхойлох, судалгааны ажлуудыг санхүүжүүлэх, үе шаттай туршилтын төслүүдийг эхлүүлнэ. Төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ.
- 4.3.2.5. Аливаа контентын жинхэнэ эсвэл хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн эсэхийг тодорхойлох, байгууллагын болон иргэдийн нэр хүндэд халдах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх системийг бүрдүүлнэ.
- 4.3.2.6. Дэлхийд өрсөлдөх чадвартай, технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай 1,000 мэргэжилтэн бэлтгэж, 1,000 өндөр технологийн ажлын байр бий болгох үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 4.3.2.7. Олон улсын цахим төлбөрийн системүүдийг нэвтрүүлж, төлбөр тооцоог саадгүй хүлээн авах боломжийг бүрдүүлэн цахим худалдааг дэмжинэ.

4.3.3. Цахим орчин дахь хүний эрх, кибер аюулгүй байдал

- 4.3.3.1. Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, мэдээллийн аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлого, зохистой хэрэглээний талаар хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 4.3.3.2. Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг хэрэгжүүлнэ. Их өгөгдөл, хиймэл оюун ухаанд суурилан кибер аюулгүй байдлын тогтолцоог олон улсын түвшинд хүргэн бэхжүүлнэ.
- 4.3.3.3. Кибер аюулгүй байдлыг хамгаалах тогтолцоог олон улсын түвшинд хүргэн бэхжүүлж, төр, иргэний цахим мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.

- 4.3.3.4. Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, цахим болон тоон гарын үсэг, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах цахим засаглалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 4.3.3.5. Бүх салбарын цахим шилжилтийн үйл ажиллагааг интеграцлагдсан кибер аюулгүй байдлын тогтолцоогоор хангана. Үүний хүрээнд төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг улсын хэмжээнд өргөжүүлнэ.
- 4.3.3.6. Кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг чадавхжуулж, бүх нийтийн кибер аюулгүй байдлын мэдлэг ойлголтыг дээшлүүлнэ.

4.4. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм

4.4.1. Үндэсний эв нэгдэл

- 4.4.1.1. Монгол хүний бахархал, өв соёл, нүүдлийн соёлыг дэмжих үндэсний соёлын үнэт зүйлд суурилсан нийгмийн соён гэгээрлийн бодлого баримталж, үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлнэ.
- 4.4.1.2. Улс, үндэстний эх орон, газар нутаг, тусгаар тогтнолоороо бахархах үзлийг сэргээж, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- 4.4.1.3. Монгол Улсын үндэсний эв нэгдэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс, аливаа талцал, хуваагдал, Үндсэн хуульт ёсны эсрэг үзэл, хандлага, ёс суртахууны доголдол, гаднын зөөлөн хүчний бодлогын нөлөөнд орох эрсдэлээс хамгаалах, үндэсний эрх ашгийг нэгдүгээрт эрэмбэлэх ойлголт, хандлага, соёлыг нийгэмд төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.4.1.4. Эрүүл чийрэг, эх оронч, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлэх “Эх оронч монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 4.4.1.5. Хилийн чанадад амьдарч буй гэр бүл, хүүхдүүдэд зориулсан монгол хэл, соёлд суралцах хөтөлбөр хэрэгжүүлж, цахим сургалтын агуулгыг нэмэгдүүлнэ.
- 4.4.1.6. Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээрүүд, төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар улсын хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлнэ.
- 4.4.1.7. Хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлэх, анги, салбарт хяналт, удирдлагын төвийг байгуулах, мэргэшсэн хилчин, технологид суурилсан хил хамгаалах албыг бэхжүүлэн, зэвсэглэл, инженер, дохиолол хамгаалалт, тоон радио релейн болон хяналтын систем, цэргийн холбоо, техник, дрон, тусгай хэрэгслээр бүрэн хангаж, хилийн аюулгүй байдлыг сахиулах арга хэмжээ авна.
- 4.4.1.8. Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шуурхай шалган нэвтрүүлэх хүрээнд ухаалаг цахим гарцыг нэмэгдүүлэх, хилийн боомтуудыг дохиолол хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөх, шалгалтын техник хэрэгслээр ханган, боомтын сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.4.1.9. Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж, барилга, дэд бүтцийн 50-аас доошгүй хувийг шинэчилж, хилийн заставт жишиг орон сууц барих, байнгын цахилгааны эх үүсвэрт холбох ажлыг үргэлжлүүлнэ.

- 4.4.1.10. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, албаны аюулгүй байдал, эрүүл мэнд, сэтгэл зүйн үйлчилгээг сайжруулах, хилчдийн орон сууцны хүрэлцээг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авна.
- 4.4.1.11. Хилийн нисэх албыг өргөжүүлэн, хилийн цэргийн нисэх анги байгуулан, улсын хил хамгаалалтын зориулалттай нисдэг тэрэг, агаарын хөлөг, нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах замаар хил хамгаалалтын үр дүнг дээшлүүлнэ.
- 4.4.1.12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус эргэлт, хэрэглээтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хууль бус эргэлттэй тэмцэхэд төрөөс баримтлах бодлого, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой бүхий л үйл ажиллагааг төрийн хяналтад авч, уг үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлүүлэх, мансуурах донтой хүнд олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, нийгэм хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх, мансуурах донг эрт илрүүлэх, эмчлэх, хяналтад авах, нийгэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 4.4.1.13. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог боловсронгуй болгож, олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон санхүүгийн системийг хөгжүүлнэ.
- 4.4.1.14. Согтууруулах ундааны эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

4.4.2. Гадаад бодлого

- 4.4.2.1. “Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт” суурь зарчмыг тууштай баримталж, хоёр хөрш болон гуравдагч хөрш улсуудад таниулан, харилцааны тэнцвэр, байр сууриа хадгалж, гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг ханган, олон улсад Монгол Улсын нэр хүнд, эзлэх байр суурь, нөлөөг нэмэгдүүлэх замаар хөгжлийн гадаад таатай орчныг бүрдүүлнэ.
- 4.4.2.2. Монгол Улсын гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг ханган үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах гадаад таатай орчин бүрдүүлэх, эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 4.4.2.3. Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын нэн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны хүрээнд улс төр, эдийн засаг, батлан хамгаалах, худалдаа, соёл, хүмүүнлэг, гурван улсын эдийн засгийн коридорын төслүүд зэрэг бүх салбарт өргөн хүрээтэй хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлнэ.

- 4.4.2.4. Гадаад бодлогын үзэл баримтлалыг сансар судлал, шинжлэх ухаан, технологийн салбар дахь дэлхийн чиг хандлагатай нийцүүлэн шинэчилнэ.
- 4.4.2.5. “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана.
- 4.4.2.6. Монгол Улс бусад улстай харилцахдаа тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, энхийг эрхэмлэсэн, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, НҮБ-ын дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээг удирдлага болгоно.
- 4.4.2.7. Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна.

Олон талт хамтын ажиллагаа

- 4.4.2.8. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн түвшинд хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.4.2.9. Олон улсын сансар судлалын хамтын судалгааны уулзвар цэг байх, хамтын ажиллагааны таатай орчин бүрдүүлэх бодлого баримтална.
- 4.4.2.10. Олон улсын харилцаа, геополитикийн нөхцөл байдал хурцдаж, мөргөлдөөн, сэргөлдөөний голомт олширч, улс гүрэн хоорондын талцал гүнзгийрч буйг харгалзан гадаад бодлогын үйл ажиллагааны механизм, арга барилыг боловсронгуй болгох, гадаад харилцааны хүний нөөцийг бэхжүүлнэ.

Бүс нутгийн эдийн засгийн интеграци

- 4.4.2.11. Бүгд Найрамдах Солонгос Улс болон Евро-Азийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулж, худалдааны түнш улс орнуудтай хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ.
- 4.4.2.12. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдийг хөрш орнуудын төлөвлөлттэй харилцан уялдуулж хөгжүүлнэ.
- 4.4.2.13. Эдийн засгийн хамтын ажиллагааны бүсэд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татаж, төр хувийн хэвшлийн түншлэлийг дэмжин хамтран ажиллана.
- 4.4.2.14. Чөлөөт бүсүүдэд бизнес инкубатор төвийг байгуулж, гадаад худалдааны түүхий эд, технологийн солилцоогоор аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ.

- 4.4.2.15. Монгол Улсын хөгжлийн бодит хэрэгцээ, шаардлагыг хангахуйц эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн гадаад харилцаа, гадаадын хөрөнгө оруулалтын чиглэлд төрийн бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үр өгөөжийг нь дээшлүүлэх шаардлага улам нэмэгдэж байна.
- 4.4.2.16. Бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэж, экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.

Гадаад харилцааны салбар

- 4.4.2.17. Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно.
- 4.4.2.18. Үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах, дүн шинжилгээг сайжруулах, гадаад бодлогын нэг цонхны зарчмыг хэрэгжүүлэх, дипломат албыг бэхжүүлэхэд чиглэгдсэн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

Гадаадад сурч, хөдөлмөрлөж, амьдарч буй иргэд

- 4.4.2.19. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 4.4.2.20. Хилийн чанад дахь Монгол Улсын иргэд гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлж, хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллана.
- 4.4.2.21. Бусад улстай хоёр талт болон олон талт олон улсын гэрээ байгуулах замаар хилийн чанадад зорчих иргэдийн визийн нөхцөлийг хөнгөвчилнө.
- 4.4.2.22. “Хүчирхэг Монгол паспорт” зорилтын хүрээнд Монгол Улсын иргэд визгүй зорчих улсын тоог нэмэгдүүлнэ.

4.4.3. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах тогтолцоо

- 4.4.3.1. Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны харилцааг зохицуулах хууль, эрх зүйг шинэчилж, цогц байдлыг хангана.
- 4.4.3.2. “Технологийн дэвшил - Зэвсэг техникийн шинэчлэл”-д нийцүүлэн Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах төрийн бодлогыг хэрэгжүүлж, орчин үеийн дэвшилтэт техник, хэрэгслээр хангана.
- 4.4.3.3. “Сөрөн тэсвэрлэх чадавх - Батлан хамгаалах тогтолцоо” -ны хүрээнд батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бэлэн байдлыг хангаж, дайчилгааны төлөвлөлтийг боловсронгуй болгож, иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлнэ.

- 4.4.3.4. “Хүртээмжтэй төсөв - Тогтвортой өсөлт”-ийн хүрээнд Зэвсэгт хүчний бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлж, төрлийн цэргийг хөгжүүлж, бэхжүүлнэ.
- 4.4.3.5. “Дэлхийн монгол цэрэг – Гадаад харилцаа”-ны хүрээнд батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, шинжлэх ухаан, инновац, техник, технологи, аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн алба хаагчдыг сургаж бэлтгэнэ.
- 4.4.3.6. “Цэнхэр дуулга, хар сүлд – Бүтээн байгуулалт”-ын хүрээнд энхийг дэмжих ажиллагаа болон улс орныг хөгжүүлэх стратегийн бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлж, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлнэ.
- 4.4.3.7. “Эх орны дуудлага - Эр цэргийн алба”-ны хүрээнд иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх, цэргийн алба, алба хаагчийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлнэ.
- 4.4.3.8. “Салбарын хүний нөөц - Нийгмийн хамгаалал”-ын хүрээнд алба хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлж, орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлж, тогтвор суурьшилтай ажиллах баталгааг дээшлүүлнэ.
- 4.4.3.9. Бүсийн сургалтын төвүүдийг шинээр байгуулж “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах суралцагчдын тоог шат дараатай нэмэгдүүлэн улс орны батлан хамгаалах чадавхыг дээшлүүлнэ.
- 4.4.3.10. Батлан хамгаалах материаллаг нөөцийг бүрдүүлэх, түүний хадгалалт, хамгаалалтыг сайжруулах шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.4.4. Гамшгийн үеийн бэлэн байдал, эрсдэлийн удирдлага

Гамшгийн үеийн бэлэн байдал, иргэний хамгааллын тогтолцоо

- 4.4.4.1. Гамшгийн үеийн бэлэн байдал, холбоо, зарлан мэдээллийн тогтолцоонд дэвшилтэт технологи, инновацыг шингээн шинэ шатанд гаргана.
- 4.4.4.2. Гамшиг, аюулт үзэгдэл, ослыг зарлан мэдээлэх системийг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.4.4.3. Онцгой байдлын байгууллагын харилцаа холбооны бэлтгэл бэлэн байдлыг дээшлүүлэн, сансрын хиймэл дагуулын болон цаг агаарын мэдээллийг шуурхай боловсруулж хэрэглэгчдэд хүргэх, гамшгийн удирдлагын нэгдсэн төвтэй болно.
- 4.4.4.4. Гал түймэр унтраах болон эрэн хайх, аврах нэгжийг орон нутагт өргөтгөж, тусгай зориулалтын автомашин, техник хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- 4.4.4.5. Хүн амын нягтаршил ихтэй болон алслагдсан байршилд гал түймэр унтраах, аврах анги шинээр байгуулна.
- 4.4.4.6. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт, хүч хэрэгсэл, агуулахын аж ахуйн технологийг хөгжүүлж, гамшгийн үеийн болон стратегийн зориулалттай бараа материалын нөөц, хангамжийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 4.4.4.7. Хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан агуулах барьж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангана.

4.4.4.8. Шатахуун, шатах тослох материалын бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулах барина.

Стандарттай гамшгийн удирдлага

4.4.4.9. Цаг агаарын болон биологийн гаралтай аюулт үзэгдэл, техник технологийн горим зөрчлийн эрсдэлийг бууруулна.

4.4.4.10. Эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгаас хамгаалах удирдлага, үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Гамшгийн зураглал, эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах механизмыг хөгжүүлнэ.

4.4.4.11. Гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахад хөрөнгө оруулалтыг бодитойгоор нэмэгдүүлнэ.

4.4.4.12. Гамшгийн эрсдэлийг бууруулах хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон нийтийн оролцоог дэмжиж ажиллана.

4.4.4.13. Нэг улс, нэгдсэн стандарт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа

4.4.4.14. Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна.

4.4.4.15. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэлзүйн үйлчилгээ, мэргэжлийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулна.

4.4.4.16. Гамшгийн үед хариу арга хэмжээ авах үндэсний чадавхыг сайжруулж, Олон улсын эрэн хайх, аврах зөвлөлдөх бүлэг (INSARAG)-ийн стандартад нийцсэн дунд түвшний ангиллын багтай болж, аврах ажиллагааны дэвшилтэт арга технологи, шинэ техник, багаж төхөөрөмжийг нэвтрүүлнэ.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Дэлхийн дахиныг хамарсан геополитикийн тогтворгүй байдал, цар тахлын дараах эдийн засгийн хямрал, эрчим хүчний дутагдал, тээвэр логистикийн доголдол, хиймэл оюун ухаан, кибер аюулгүй байдал ба дэвшилтэт технологийн хурдацтай шилжилтийн тодорхой бус байдал, санхүүгийн эх үүсвэрийн хүрэлцээгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль, цаг уурын нөлөөлөл зэрэг гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөнөөс үүдэн дараах эрсдэлүүд учирч болзошгүй байна.

ОХУ-Украины дайн, Ойрх Дорнодод өрнөж буй мөргөлдөөн, БНХАУ-Тайваны сөргөлдөөн зэрэг геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилсэн хэвээр байгаа нь түүхий эдийн үнэ хэлбэлзэх, үнийн өсөлт үргэлжлэх эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн, АНУ зэрэг бусад өндөр хөгжилтэй улс орнуудад үйлчилгээний салбарын инфляц өндөр хэвээр байгаа бөгөөд мөнгөний хатуу бодлого үргэлжилснээр олон улсын санхүүгийн зах зээл тогтворгүй байдалд орж дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж болзошгүй юм. Дэлхийн эдийн засгийн идэвхжил саарах, түүхий эдийн үнийн тогтворгүй байдал үүсэх нь манай улсад орох хөрөнгийн урсгалыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Мөн хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, гадаад зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

Манай экспортын бүтээгдэхүүний гол худалдан авагч болох БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарт уналт үргэлжилж, үл хөдлөх хөрөнгө болон барилгын салбарын бууралт нь гангийн эрэлтэд цаашлаад бүтээгдэхүүний эрэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Ингэснээр дэлхийн зах зээл дээрх зэс, нүүрс зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурах, эдийн засгийн өсөлт саарах эрсдэлтэй байна.

Энэ онд өвөлжилт, хаваржилт хүндэрсний улмаас эхний хагас жилийн байдлаар том малын зүй бус хорогдол 8.1 сая буюу нийт малын 13 хувьд хүрсэн нь хөдөө аж ахуйн салбарын нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж, өрхийн бодит орлогыг бууруулах, нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт, ажилгүйдлийн түвшин, тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна.

Цахилгаан станц, дамжуулах шугам, дэд станц, түгээх шугамуудад үүсэх гэмтэл, байгалийн гамшиг болон хүний алдаанаас гарах осол, эвдрэл, тасалдал, хангамжийн тогтворгүй байдал үүсэх аюултай. Иймд, цахилгаан станцуудыг нэмж барьж байгуулах, нийслэлд дулааны төвлөрсөн бус эх үүсвэрүүдийг бий болгох, хийн цахилгаан, дулааны станцыг барих, эрчим хүчний нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Дээр дурдсан эрсдэлийг даван туулах, хариу бэлтгэл арга хэмжээг шуурхай авах хүрээнд үүсэж болзошгүй нөхцөл байдалтай уялдуулан холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангах, богино, дунд, урт хугацааны эрсдэлийн удирдлагын цогц бодлого, төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

Үүний тулд эдийн засаг, байгаль орчин, аюулгүй байдал болон бусад эрсдэлийг урьдчилан сэрэмжлүүлэх, эрт таних, илрүүлэх системийг хөгжүүлэх, цаг алдалгүй менежментийн шинэчлэлийг эхлүүлнэ. Түүнчлэн, үндэсний түвшинд мониторинг хийх, үнэлэх, эрсдэлийн удирдлагыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Мөн байгаль, цаг уур, эдийн засаг, кибер аюулгүй байдал болон бусад эрсдэлийг тэсвэрлэх, даван туулах дэд бүтцийн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулж, эрсдэлийн удирдлага, шийдлийг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаагаар хангах бодлого баримтална.

Эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, удирдлагын төлөвлөгөөг сайжруулан шинээр үүсэж болзошгүй нөхцөл байдал, хямралын дараах сорилтын бэлэн байдлыг хангана. Хамтрагч, түншлэгч талууд болон олон нийтэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх, солилцох нөхцөлийг бүрдүүлж, хамтын итгэлцлийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагын менежмент, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх хүрээнд гадаад болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

----oOo----

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ...
дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

№	Бодлогын үндэслэл	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин				Мэдээллийн үзүүлэлтүүд		
					Он	Түвшин	2025 он	2026 он	2027 он	2028 он	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж
1.	АХ-2	Хүний хөгжлийн үзүүлэлтийг 10 байр ахиулна.	Хүний хөгжлийн индекс	байр	2022	96/193	95	93	90	86	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр	Үндэсний хэмжээний түүвэр судалгаа	Жилд нэг удаа
2.	АХ-3	Ядуурлын түвшнийг 2 дахин бууруулна. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган ам.долларт хүргэнэ.	Ядуурлын түвшин	хувь	2022	27.1	25	22	18	14	ҮСХ	Статистик мэдээ	2 жилд нэг удаа
3.	АХ-3	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган ам.долларт хүргэнэ.	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн	ам.доллар	2023	5,875	6,520	8,090	9,120	10,400	ҮСХ	Статистик мэдээ	Жилд нэг удаа
4.	АХ-4	Эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш түвшинд хадгална.	Эдийн засгийн өсөлт	хувь	2024	6	8	6.5	6.5	6.5	ҮСХ	Статистик мэдээ	Жилд нэг удаа
5.	АХ-4	Инфляцыг 5 хувиас доош түвшинд хадгална.	Инфляц	хувь	2024	8	7	5	5	5	ҮСХ	Статистик мэдээ	Жилд нэг удаа
6.	АХ-4	Зэрэглэлийг тогтвортой түвшинд хадгална.	Зэрэглэх зэрэглэл	түвшин	2024	В3	В3	В3	В3	В3	Мүүдиз	Олон эх үүсвэр	Жилд нэг удаа
7.	АХ-4	Эдийн засгийн эрх чөлөөний байдлын	Эдийн засгийн эрх чөлөөний	байр	2024	76/176	75	73	70	66	Дэлхийн өв	Олон эх үүсвэр	Жилд нэг удаа

№	Бодлогын үндэслэл	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин				Мэдээллийн үзүүлэлтүүд		
					он	түвшин	2025 он	2026 он	2027 он	2028 он	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж
		үзүүлэлтийг 10 байраар ахиулна.	байдлын индекс								уламжлалын сан		
8.	АХ-4	Бизнесийн орчны ерөнхий үнэлгээг 3.5 оноонд хүргэн ахиулна.	Бизнесийн орчны ерөнхий үнэлгээ	оноо	2023	2.71	2.8	3	3.3	3.5	МУХАҮТ	Монголын бизнесийн орчны судалгаа	Гурван жилд нэг удаа
9.	АХ-2	Дэлхийн инновацийн үзүүлэлтийг 10 байраар ахиулна.	Дэлхийн инновацийн индекс	байр	2023	68/132	67	65	62	58	Дэлхийн оюуны өмчийн байгууллага	Олон эх үүсвэр	Жилд нэг удаа
10.	АХ-5	Засаглалын үзүүлэлтийн дунджийг 10 байраар ахиулна.	Засаглалын үзүүлэлтийн дундаж	байр	2022	113/215	112	110	107	103	Дэлхийн банк	Олон эх үүсвэр	Жилд нэг удаа
11.	АХ-6	Дэлхийн сайн орны үзүүлэлтийг 10 байраар ахиулна.	Дэлхийн сайн орон индекс	байр	2022	106/169	105	103	100	96	Дэлхийн сайн орон индекс	Үндэсний хэмжээний түүвэр судалгаа	Жилд нэг удаа
12.	АХ-5	Авлигын үзүүлэлтийг 30 байраар ахиулна.	Авлигын төсөөллийн индекс	байр	2023	121/180	118	112	103	91	Транспаренси Интернэй шил олон улсын байгууллага	Олон эх үүсвэр	Жилд нэг удаа